

9-3
10-3
11-3
12-3
13-3
14-3
15-3
16-3
17-3
18-3
19-3
20-3
21-3
22-3
23-3
24-3
25-3
26-3
27-3
28-3
29-3
30-3
31-3
32-3
33-3
34-3
35-3
36-3
37-3
38-3
39-3
40-3
41-3
42-3
43-3
44-3
45-3
46-3
47-3
48-3
49-3
50-3
51-3
52-3
53-3
54-3
55-3
56-3
57-3
58-3
59-3
60-3
61-3
62-3
63-3
64-3
65-3
66-3
67-3
68-3
69-3
70-3
71-3
72-3
73-3
74-3
75-3
76-3
77-3
78-3
79-3
80-3
81-3
82-3
83-3
84-3
85-3
86-3
87-3
88-3
89-3
90-3
91-3
92-3
93-3
94-3
95-3
96-3
97-3
98-3
99-3
100-3

БӨЛГИЙН ТОО

Оршил	3
1.Монгол хамниганы тухай бидний мэдэх нь	9
2.Монгол хамниганы тархац овгийн учир	16
3.Монгол хамниганы утга соёлын учир	33
4.Монгол хамниганы хамниган буюу эвенки хэл	39
5.Хамниган эвенки хэлний угсийн зүйл	50
6.Монгол хамниганы эвенки хэлний хэлбэрзүйн зарим зүйлээс ...	69
7.Хамниган эвенки хэлний ярианы угсийн зүйлээс	76
8.Монгол хамниганы дундад эртний монгол аялгууны үлдэгдэл "хамниган аялгуу"	81
9."Хамниган аялгуу" гэдгийн ярианы жишээнээс	91
10.Хамниган монгол угийн бүгд хэлхээ	100

Зохиогч Б.Ринчен

Редактор Ш.Лувсанвандан

Тех.ред.хийж хуулан бичсэн Г.Дуламсүрэн.

1968 оны 12-р сард ерөлтөнд орж, 1969 оны 1-р сард 1000 ш. хэвлэгдэв.
Цаасны хэмжээ 70х108. 1/16. Хэвлэлийн хуудас 7,75. Хэвлэлийн нэгж хуу-
дас 10,85. В-37129 За № 473.

Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх үйлдвэр

Улаанбаатар хот.

Нэгдсэн Үндэстний гудамж 15

О Р Ш И Л

Угшингид толилуулан буй энэ ганц сэдэвт зохиолд, Монгол Ард Улсын нутагт оршин суугч хамниган үндэстний хэл аялгууны зүйлийг тоймлон өгүүдэхийг гол зорил болгосон билээ.

Хамниган гэж монголчуудын нэрлэн буй үндэстнийг европ зүгийн хэлнээ орос хэлээр дамжин тунгус хэмээн нэрлэх болсон бөгөөд тэр нэр тухам юуцаас үүссэн тухай лавлан магадлаж судласан зүйл хараахан үгүй, 1905 оны Этнографическое Обзорение гэдэг сэтгүүлийн 4.дэвтрийн 106-117. талд, мөн 1906 оны 3/4.дэвтрийн 208-217. талд А.Шиманский, Эд.К.Пекарский гэдэг хоёр эрдэмтэн, тэр хамниган гэдэг нэрийн учрыг нягтлаж бичсэн зүйл бийг сонирхогсон үзвэл болох юм гэж дурадъя. Олонхи, тэр тунгус гэдэг нэр, түрэг хэлтэн аймгийнхан, хамниганы их тэтэв нь гахай агнадаг, бойжуулдаг учраас гахайтан гэсэн үгний өнцөг нь эвдэрч, тунгус гэдэг аймгийн нэр болон дэлгэрсэн болов уу хэмээх ажээ. Түрэг хэлтэнд гахайг донгус, тонгус гэдэг ахам.

Монголчуудын хамниган гэдэг болсон тухай бас нарийвчлан нягтласан зүйл бараг үгүй. Зарим эрдэмтэн, хамниган гэдэг нэр бол, эртний Хавханас овгийн нэр, өнцөг нь сунжирч, одоо хамниган болж ирсэн гэж үзэх нь буй. Авнан зүйн хувислын үүднээс шинжсэн тэр бодрол ортой магад ч байж болох юм.

Энэ тухай америкийн монголч эрдэмтэн Кливес сонин магадлал гаргаж, эртний Кабканас Qabqanas гэдэг нэр сунжирч хамканас болсон нь хамнигас - хамнигас болсон тухай өгүүлдээ. Энэ тухай Harvard Journal of Asiatic Studies гэдэг сэтгүүлийн XIX/1956/192. талд үзмүү.

Өөрсдийгөө хамниган аймгийн хун, аймаг овгийн нэрээр нэрлэх тул, нийтэд нь биеэ тийм гэж бидний монгол хэмээдэгтэй адил эр нийтийн нэр үгүй. Дээр эртний нэгэн хамниган овогтон нь монгол хэл бичгийн цурсгалд Зурчин гэж нэртэй, эртний их улс байсан туухтэй, нангиал үсгээс үлгэр авч утга үсэгтэй байсан улс. Тэр утга үсгийн манай үе

хүртэл уламжилж ирсэн дурсгалы нь ширхэг дараалан хараахан одоо хүртэл уншин судлаж бараагүй.

Түүхэнд нэлдэрэм их нэрээ үлдээсэн тэр Зүрчид Алтан улсын аймагаас одоо манай Монгол Ард Улсын нутагт зүүн аймагт Зүрчид нэр нь монгол овгийн нэрийн дунд үлдэн уламжилж ирсэнийг дурдаж болно. Одоо биеэ Зүрчид хэмээн овоглож буй монголчууд, эртний тэр яс овгоо хадгалан ирсэн нь, хэлний хувьд монгол хэлтэн болсоор олон зуун жил болсон тул, жишээлбээс, орос ардын дунд Немчинов, Поляков, Литвинов гэж Герман, Польш, Литва гаралтай байсны нь дурдан заасан овгийн нэр болсонтой адил үзэгдэл ажээ.

Хамниган гэхэд суулийн гучаад жил дотор зарим жиртэн хүн, буриада гэж бодох болж, бас солоон гэж монголчуудын нэрлэдэг нэгэн хэсэг хамниганыг барга монгол гэж бодцгоох болсон нь буй, ажилтгавал, европ хүнийг орос гэж нэгэн хэсэг үе жиртэн хүний бодож байсантай адил үзэгдэл ажээ.

Солоон гэдэг нь барга монгол огт бус, биеэ эвенки гэдэг хамниган улс. Манай улсын дотор оршдог хамниганы их төлөв нь бас биеэ мөн эвенки гэдэг бөгөөд, Зөвлөлтийн хамниган ч мөн биеэ эвенки гэдэг байна. Уунд, Зөвлөлт Улс, Дундад Ард Улс, Монгол Ард Улс энэ гурван улсын нутаг дэвсгэрт орчин үеийн хамниган багтан оршдог бөгөөд, тус гурван улсын хамниган цөм биеэ эвенки хэмээн, жич дотрохи аймаг овгоор ялгахдаа, манай, эвен, үдихэ, ортон, оронзон гэх зэргээр ялгах тул, европ зүгийн шинжлэлийн бичиг зохиолд тунгус гэдэг нэр нь нийтий нь хамрасан нэр болж, монгол хэлнээ хамниган гэдэг нэр бол, тэр европ хэлний тунгус гэдэгтэй утга агуулгаар яг дүйх учраас, мөн хамниган нийтийн нэр нь байж, дотор нь ялгавал, эвенки, эвен, орчин, ортон, манагир, увачаан гэх зэргээр ялгадаг нь, шинжлэх ухааны монгол зохиолд хамниган гэдэг нэрийг европын тунгус гэдэг нэртэй утга агуулгын хувьд нэгэн адилаар хэрэглэж, дотор нь бас тус улсын дотор оршсоор ирсэн эл эртний үндэстэн улсын нэр болгон хэрэглэсээр ирсэн ажээ.

Монгол уншигчид, хамниган-манж хэл нь монгол-түрэг хэлтэй ямар харилцаатайг тоймыг үзсүгэй хэмээхүл, миний бичсэн Монгол бичгийн хэлний зүй, тэргүүн дэвтэр, удиртгал гэдэг номын 233-р хуудсанд Алтайн овог хэлний нэгэн салбар болох эл хамниган хэлний тухай үзэмуу.

1964 онд Улаанбаатар хотноо гарсан билээ.

Жич, Монгол Ард Улсын нутагт оршин буй хамниган угсаатны тухай бичсэн эл зохиолоо ганц сэдэвт хэмээн нэвдсэн тухай нэг хэдэн уг хэлмээр байгаа нь, эл ганц сэдэвт гэдэг нэр, уг нь монгол, утга нь олон улс нийтийн утгатай уг байгаа бөгөөд, тийм зүйлийн нэр, орчин үеийн өндөр соёлт улсын дунд ихэд дэлгэрч буйг дурдалтай. Европ зүгийн улс, герег-латин соёлын хүрээнээ багтсан учир, эртнээс нааш герег латин хоёр хэлийг номын хэл болгон үзсээр, тэр хоёр хэлээр наад зах нь хүний нэр, наад зах нь олон ухааны нэрийг зохион бүтээсээр ирээд, өөр өөрийн хэл бичиг хөгжөөд ирснээс хойш, орчин үед тэр номын хэлний зарим нэрийн зүйлийг өөрийнхөө хэлэнд оруулан нэрлэх болцгоож буйг европ зүгийн улс бүхний хэлнээ үзэж болно: аэроплан гэж герегийн дэр гэж агаар гэсэн уг, латинаар планум гэж хартгай самбар гэсэн уг, нийлүүлж, 1850 оны үес Адер гэдэг хүн зохион найруулсан нь, 1903 оны орчим нисэх онгоцны явдал дэлгэрч үүсэхэд түгэж ирсэн нь, хойно хойноо орос хэлнээ самолет гэх болж, аэроплан гэж амнаас гарахаа бараг байгаад, манай энд 1921 онд Магсар Хурцын Дугаржав нар Агаараар нисдэг айрополоон гэдэг туу зохиож байсан нь, орос хэлнээ аэроплан гэдэг нэр тэр үед байсныг давхаа батлаж, өөрсдөө хийдэг болоод ирэхдээ өөрийн нэр өгч орос хэлнээ самолет гэдэг нь нийтэд алдаршсан үес, монголчууд ч бас өөрсдөө түүнийг эзэмлэн жолоодог болоод ирэхдээ нисэх онгон гэж нэрлэх болоод, аэроплан, айрополоон гэж ер бичих туудах хуугүй болж, бусад улсад, герман бас өөрийн хэлээр флюгнойг гэж нэрлэдэг болсон нь, монголчилбол, нисдэг юм гэсэн утгатай уг, польш мөн самолёт, мажарууд репюлөөгээн буюу монголчилбол, репюлөө гэж нисэх, гээп гэж оньс гэсэн уг болж нисэх оньс гэсэн нэр болжээ. Герегийн моннос гэж ганц юм гэсэн нэр, графён гэж бичих гэсэн герег уг нийлүүлэн зохиосон monographie гэдэг нэрийг анх Кантолл гэдэг эрдэмтэн 1808 онд зохиосон нь ганц сэдэв голлон зохиосон зохиолын нэр болж ирсэн бөгөөд, орос хэлнээ монография гэж эм үгийн хүйсэнд оруулан -я залгаж, герег хэлбэрий нь орос хэлний хэлбэртэй болгож орос бичгийн хэлнээ хэрэглэн буйг франц хэлнээ мөн хуу франц хэлний зүйд нийлүүлэн monographie гэж бичдэг нь, хошоод уг нэг болгон хэрэглэдэг уунд,

монголоор тэр үгийг "ганц сэдэвт" гэж мөн хошоод үгий нь нэг болгон хэрэглэдэг нийтийн журмаар хэрэглэж, хэлбэрийн хувьд уг нь монгол, утга нь нийтийн агуулгатай хэвээр нь хэрэглэсэн нэр болохыг герег латин хэл бичиг мэдэгсэд аль ч улсын хүн үзүүт, утга учры нь ухах нийтийн нэртөмьёо монгол бичгийн хэлнээ буйг танин мэдэх болно.

Одоо монгол хэлээр шинжлэх ухааны зүйл бүрийн зохиол гарч, монгол бичгийн хэл, орчин үеийн соёлт улсын хэл тул, зүйл бүрийн ганц сэдэвт зохиол монгол хэлээр гарах болсон тул, тэр төрлийн зохиолын нэр нь монгол хэлнээ бий болж байгаа хэрэг.

Хамниган хэлний тухай монгол хэлээр цаашдаа бас ганц сэдэвтийн зүйл бий болох нь гарцаагүй бөгөөд, уншигчид толилуулан буй энэ хүү ганц сэдэвтийн зүйлд орсон мэдээ баримтын зүйлийг миний бие 1927 оноос эхлэн цуглуулсаар ирсэн үүнд, чухал ховор сонин мэдээ зүйл хэлж өгсөн хамниган олон өггөст талархлаа дэвшүүлэхийн ялдар, Улсын архивын газар еер сэдвийн бичиг баримт эрэхийн ялдар надад бас Сэцэн хан аймгийн ханы хамниган, Шанзодбын яамны бичиг баримтаас богдын хамниган шавь отгийн мэдээ баримтаас чухал мэдээ тэмдэглэж өгсөн Цэвэлгуай зэргийн нөхдийн тулалцсанд тал өгсүгэй.

Монголын судлалд хүчин санаа зориулах сэхээтэн багш нарт, тэдний цундаас хамниган-манж хэл судлах хүнд сануулан хүсэх нэгэн зүйл гэвэл, монгол газар орны нэрийн зүйлд хамнигантай холбогдолтой газрын нэр, одоо хамниган хүн огт байхгүй нутагт үлдсээр ирсэн нь, тууш нягтлаж судлан шинжвэл, хамниган зурчид зэргийн эртний нутаглаж байсан газрын гэрч болох тул, энэ тухай сонирхон тэмдэглэж байвал, бас сонин шинжлэл өгүүлэлийн сэдэв болохыг дурдууштай байна. Тэдгээр монгол бус, еер аймаг угсаатны үлдээсэн монгол газрын нэр бол, монгол улсын туухийг газрын нэрээр толилуулсан сонин зүйл болно. Эл сэдвийг эрхбиш сонирхон оролдох хүн, манай утга судлалтан philologues дотроос гарах ёстой тул, энэ талаар бас холбогдолтой мэдээ баримт цуглуулж байх нь чухал болохыг дүхас дурдалтай байна.

Ринчен др.проф. академич

Улаанбаатар, 1967 оны намар.

1.МОНГОЛ ХАМНИГАНЫ ТУХАЙ БИДНИЙ МЭДЭХ.НЬ

Монгол нутагт эртнээс нааш оршсоор ирсэн хамниган үндэстний тухай монгол бичиг зохиолд тусгайлан зориулж бичсэн ину, ардын төрийн өмнө байхгүй, гагц хуу албан цанс хараанд хамниган отгийн хүн амнаа албан татвар зэргийг оноосон цэс буюу отгийн дарга нарыг тохон тавьсан зэргийн мэдээ зүйл гарнам.

1930 оны үеэс Монгол Ард Улсын Шинжлэх ухааны Хүрээлэнгийн эрдэмтэн гишүүн Цэвээн доктор, тус улсын дотрохи дархад, Хөвсгөл нуурын урианхай, дөрвөд, хотон, баяд, өөлд, мянгад, захчин, торгууд, хошууд, пахар, дариганга, алтайн урианхай, хасаг, хамниган нарын гарал үндэс байдлын өгүүлэл гэдгийг албан мэдээ баримт зэргийг нягтлан шүүрдэж, мөн тэдгээр аймаг угсаатны тухай гарын дор бүхүй орос жуулчин, хүн судлалтан, угсаатны зүйч зэргийн эрдэмтний зохиолд гарсан баримт тэргүүтнийг өөрийн олон жилийн ажиглалт тэмдэглэлийн зүйлтэй нийцүүлэн бичсэний нь өдгөө энэ хуу ганц сэдэвтийг бичигчийн бие, тэр үед Шинжлэх ухааны хүрээлэнгийн дуун ухааны тасгийг эрхлэж, хөвлөлийн зүйлийг даалцаж байсны хувьд Монгол улсын 24, аргын улирлын 1934 онд тусгай нэгэн дэвтэр болгон гаргасан билээ. Түүнээс хойш энэ завсар гучин, нэлээд жил өнгөрч, уг дэвтэр олохуяа чухаг болж, эрэн сурвалжлагчид цөөнгүй үзэгдэм.

Монгол хэлээр хамниганы тухай анх шинжилгээний өгүүлэл гарсан нь даруй тэр дэвтрийн төгсгөлийн бөлөг нь бөгөөд, хэмжээ нь асар ихгүйн тул, ховордсон тэр дэвтрээс энд хэвээр сийрүүлбэл сонин гэж, худам монгол үсгээр гарсан үгий нь кирил үсэгт буулган, толилууллаа:




Хамниган

Ерөө голын эхэн хувь болох Ходоодны булан, Ялбаг, Танга, Бугант, Барлаг, Шарлун ба Харлан голын эхин хийгээд бас Цехөд орох Галттай ба Темертэй горихон хийгээд Минж голын Зэлтэй зэрэг газраа энд тэнд бөлөг цулгээр хамниган суумой. Ерөөгийн халуун ус болбаас, чухам хуу

хамнигын нутгийн төв хүйс нь боломой. Бас зүүнтийн явбаас харуул дагуу Онон голын эхин хувьдахи Гурван харуул /Агаца, Гилбэр, Улхун/ ба чанагшид Тогосогийн шилийн өвөр тал, одоогийн Улз голын хошууны хойт захаар⁺ цөөн хамниган байх ба Хөвсгөл Урианхай зүгт Собн Түнхэний нуруудын аль нэгэн завсраа Маниагар овгийн хамниган дөрвөн зуун ам буй хэмээн соностовч, үнэн худлыг мэдэхгүй.

Ер, хамниган ястныг нийтдөр авч өгүүлбээс, монгол түрэггүйгээр эерэгцэн, наигиад /хятад/ сударт дөрвөн мянган жилээс нааш оролцсоор ирсэн хуучны их үндэстэн даруй мөн болох бөгөөд Дорнодахи гадаад их далайн эргээс Өрнөдөхи их Алтай зүг хүртэл бэ монгол Говиос Умарт Мөсөн далай хүртэл тархаж түгсэн нь цаг үес бэ⁺⁺ газар оронд нэр алдар адилгүй боловч, бие бялдарын шинж бэ хэлний шинж нь нэгэн үндэстний ард хэмээн мэдэгдмээр баймой./Солоон, манж хэл, хамниган хэл-нэгэн төрөл буюу./

+ Уг ном зохиож байх үес аймаг, хошуу, сум, баг гэдэг захиргааны хувиар байсан хэрэг. Энэ завсаар хошуу татан бууж, сум болсон нь, Улз голын хошууны хойт зах нь даруй Дорнод аймгийн Дашбанбар сумын нутаг болно.

++ Худам монгол үсгээр  гэж бичлэгийг эр угний дараа орвол БА, эм угний дараа орвол БЭ гэж дуудах ёстойг Зүрхэн толтын зэрэг монгол үсгийн номлол бүхэнд гардгийг ахмад үеийн монголтой хүн бүхэн андахгүй мэдэх байсан боловч, сүүлийн үед латин үндэг, кирил үсэг зэргэд шилжих үес худам монгол үсгийн эртний уламжлалыг мэдэх нь ховорлож, гаднаас ирсэн орчуулагч нар монгол болгох зэргийн албан бичигт эл  гэдгийг гагц хуу БА гэж дуудах болсон. Гэтэл түрэг хэлтэнд эл  даруй БЭ гэдэг хэлбэртэй байдгийг дурдаж, монгол бичгийн хэлнээ эл БА, БЭ хэмээх хоёр хувилбартай байсан нь эр эм угийг цагаж тийм болсон учиртай байжээ.

Худам монгол гэж баруун монголчууд монгол үсгийн дотор гол монгол, худам монгол хэмээн ялгадаг хэзээний нэр. Ойрооос худам монгол үсгээ уйгаржин үсэг гэж бичих болсон нь, уйгаржин гэж уйгар гэсэн нэр тул, жинхэнэ уйгаржин хэлийн тэмдэглэх үсэг бол сая уйгаржин үсэг болно. Уйгар улсаас уйгаржин үсгийг нь аваад монголжин хэлнээ хэрэглэхэд уйгаржин үсэг биш, даруй монголжин үсэг хэмээх ину болно буй заа. Эл монголжин үсэг, эртнээс нааш баруун монголчуудын бичигтэн дунд худам монгол гэж нэртэй байсны нь монгол үсэгтээ хэрэглэн ялгаж байвал зохих ажээ.

Наггиад улсын сударт⁺ Дорнодахи Хуугийн аймаг буюу Дун Хуу хэмээн ерөнхийлор нэрийдсэн ину буй. Үүнийг бас Суушений аймаг ба Ниуджи хийгээд Зурчин ба Манж аймаг хэмээн бичсэн байх бөгөөд өөсөөн Эвенки ба Тунки хэмээх ину буй.

Эртний Хятад буюу Дай Ляо улсыг мөн ч хамниган үндэстэн монголлуугаа хавсарч байгуулсан ба дараахи Зурчин буюу Зурчидийн Алтан улс хэмээгч мөн хамниган үндэстний байгуулсан улс боломой. Бас Алтайн чанад биед Иля гол, Балхас нуур ба Төмөрт нуурын орчим эрт цагт Усуи хэмээх нэгэн улс байсан нь, сударт гарах бөгөөд тухам ямар үндэсний болохыг өдгөө бэлтэл шинжилж олоодүй буй. Гэтэл, Чингисийн тайлганы Алтан дэвтэр хэмээх бяцхан бичгийн дотор хэсэг түгэлийн үест Дөрвөн

+ Наггиад гэж монгол бичгийн хэлнээ аман хэлнээ дотор улс, хятад улс, иргэн улс гэх зэргээр нэрлэдэг улс үндэстний чухам хүү нэр. Дотор гэдэг нь Шанси хавтас монгол газар ирсэн худалдааны иргэн, наггиадын ᠙ гэсэн үсгийг монгол хэлнээ дундад гэж улсын хувьд орчуулдагийг мөдөхгүй дээрээс, тэр үсгийг гагц хүү дотор гэдэг ганц утгаар монголчилж, биеэ дотор хүн, дотор улс гэдэг байснаас дотор хүн, дотор улс гэдэг нэр хар хэлнээ тархажээ. Дайчин улсын нэг Монгол газардэлгэрчээ. Бичигт, наад зах нь албан бичигт огт үл тохюлдом. Иргэн гэдэг нь бас л наггиадын ᠢ гэсэн үсгийн орчуулга. Мөн Дайчин улсын үес монгол албан бичиг, хошуу тамгын гаарын албан хаагсадын хэлнээс хар хэлэнд орж, худалдааны иргэн гэсний хураангуй бөгөөд, цэрэг түшмэл биш, ер жирийн хүн гэсэн утгатай уг аж, иргэн хүн гэж манж нарын НИ-КАН гэж нэрлэдэг үндэстнийг хар хэлнээ нэрлэсэн нэр болж, хятад гэдгээс арай хүндтгэсэн гэж ойлгогдох болж ирсэн байна. Монгол сударт "иргэн", "хятад" гэдгийг гагц хүү наггиад гэж, дээр эрт цагт энэтхэгээс наггиад хэлээр дамжуулан орчуулсан зохиолд энэтхэгийн хэлээр тэр тэр гээд, дараа нь наггиадын хэлээр тэр тэр гэж заан суулд нь монголын хэлээр тэр гэсэн хэмээн дурдсан байдаг нь наггиад гэж бичгийн хэл, гүн ухаан зэргийн шинжлэх ухааны ном зохиолд гардаг нэр болном бөгөөд герг-латин соёлын хүрээний улсын номын хэлнээ Сөрс, Сина гэдгээс синологич гэх зэргээр наггиадыг судлах ухааны нэр бүтээсний нь даруй наггиадсудлал гэх зэргээр шинжлэх ухааны нэр үүсгэхэд чухал болно. Үүнээс сина- гэж наггиад, логия гэж судлал хэмээн нэгэн нийлбэр нэр болгон зохиосныг орос хэлнээ даруй -ия гэдэг суул залган хэрэглэдэг нь орчин үеийн олон улсын журам бөгөөд тэр ёсоор нь мөн монголын шинжлэх ухааны хэлнээ наггиадсудлал гэж нэгэн нийлмэл нэр болгох нь, наггиад судлал гэж салангид бичсэнээс утга санаа даруй өөр болно, наггиад судлал гэвэл наггиад хүн судласан судлал, наггиадсудлал гэвэл наггиадын тухай судлал гэж олон улсын орчин үеийн хам бичиж нэгэн нэр болгох зарчмаар монголынхоо шинжлэх ухааны хэлийг бид баяжуулах учиртай байна.

Ойрадаар дамжуулан тайлганы хувь түгээлийг Усны Гурван Зүрчидтөр хүргэ хэмээсэн үг буй тул, миний санахуйдор, энэ хүү Усны Гурван Зүрчид хэмээдэг нь, хуучин судрын Усун улс мөн бөгөөд үндэс нь хамниган үндэсний Зүрчид аймаг болохуу хэмээн санамой.

Нийтдөр хамниган хэмээх үндэсний олон аймгуудыг шинжилсэн Европын эрдэмтэн, XVIII зууны үеэс аваад өдгөө хүртэл олон байх бөгөөд хамниган аймгуудыг хоёр анги болгож, нэг нь хэдэн удаа их улс байгуулж, судар түүхэд ороод, суулийн манжийн үест өөрийн хүү үсэгтэй бичигтэй болж чадаад сая өнгөрсөн. Эдгээр аймгуудын бие нь том өндөр, нөгөө нь бие багашиг, умар зүг Сиберийн оронд⁺ ба дорно зүг Хар мөрний⁺⁺ алаг хувь хийгээд Умарт Мөсөн далайн хөвөө хүртэл саршин суумой хэмээжээ.

⁺ Сибер гэж орос хэлнээ Сибирь хэмээн тэмдэглэгдэн, түүгээр дамжин өрнө зүгийн олон хэлнээ Siberia гэж орсон нь даруй монгол хулам үсгээр ᠰᠢᠪᠢᠷ, түүнийг латинаар галиглавал Siber гэдэг монгол нэр. Одоо ч Монгол нутгийн газрын нэр мэтэст сн нь ши болж, Хар шивэр, Мухар Шивэр гэх зэргээр байдаг бөгөөд шивэр гэж ширилдэм их модтой газар гэсэн утгатай үг болно. Ши болоогүй Си- гэж дуудаж ах үед орос бичигт орсон нь монгол хэлний түүхэн судлалд сонин бөгөөд энэ тухай товч дурдвал, орос бичгийн хэлнээ орсон тэр Сиберийн газар орны монгол нэрийн зүйлийн хэлбэр нь монгол хэлний түүхэнд тун ч чухал сонин баримт болох тул, энэ тухай оролдон судлах хун, монгол хэлний хөгжлийн үе шатанд маш хэрэгтэй баримт гаргалга хийж болох байгааг дурдалтай.

⁺⁺ Хар мөрөн гэдгийн орос нэр нь Амур бөгөөд хэрхэн учир тийм нэр орос хэлнээ орсон тухай бичсэн зүйлээс Зөвлөлтөийн нэгэн нэвтэрхий толинд монголын ХарА МҮРөн гэсэн нэрэс сунжирч Амур болсон гэж дурдсан зүйл бий. Тэр нутгийн хамниган аймгийн хэлнээ Амур гэж байдаггүй, нангиад хэлнээ Хэй лун зиган буюу Хэй хэ - монголчилбол, Хар луугийн мөрөн буюу Хар гол гэсэн нэртэй нь, суулчийн нэр нь монго-лоос нангиад хэлнээ орсон байдалтай. Монгол улсын архивын газар энэ Хар мөрний нэр Хар мөрний жанжны газрын маш олон бичигт үлэмжид гарч, монгол газрын зурагт монголчууд цөм Хар мөрөн хэмээсээр ирсэн тул, суулийн үест газарзүйн сурах бичиг зэргийг орчуулагчид, Амур гэдгийг Хар мөрөн гэж мэдэхгүйн харгаагаар Амур, Амар гэх зэргээр бичсэн зүйл үзэгдэх боловч, монголчуудын хэзээний мэдсээр ирсэн тэр мөрнийг зүй нь монголоор бичих нэрлэхдээ монгол нэрээр нь Хар мөрөн гэх учиртай байна.

Монгол улсын дэвсгэр дээр сууж буй хамнигадын дотроос гагц хүү Ереэгийн хамниганыг бие бялдар ба зан суртлын үүднээс⁺ 1904 онд эрдэмтэн Талькогринцевич шинжилсэн байна. Үүний урд хожид бага сага шинжилсэн ину буй боловч, зам гудсын шинжилгээ болно. Учир иймийн тул, Талькогринцевичийн судалсан шинжилгээнийг баримтлаж, өчүүхэн төдий өгүүлэхээс еер, хамниганы дэлгэрэнгүй байдлыг хэлж үл чадмой.

Талькогринцевичийн уест хамнигадын хууч мэдэх хүний үгээр болбол, эрт урд гурван мянган жилийн өмнө Алтай зүгт суусны нэгэн цагт айл зэргэлдээ Соян улсын Байба хан, Бур хан хоёрын үед их самуурал болж, өлөсгөлөн тохиолдсон учир, тэндэхийн хамнигад уван цуван хөдлөж, бүтэн зуун жилд цувран явсаар Хар мөрөн хүртэл нүүсэн түүхтэй. Ийн хүү нүүхэд энд тэнд тасраж хопорсон нь Байгал орчим ба Армаг хийгээд Ерее голын хамниган мэт болно хэмээх бөгөөд хамнигад Алтайгаас Ерее хүртэл 30 жил явжээ хэмээмой. Хэдийвээр аман түүхийн үнэн худал нь магадгүй боловч, дээр пурдсан Усуны Зүрчидээс тасарсан байж болно.

+ Бие бялдар ба зан суртлын үүднээс гэж эл дэвтэр зохион бичих үес хэрэглэж байсан нэр бол, "со стороны антропометрической и этнографической" гэсэн нэр утгыг монголоор тойм санаагийг нь нэвтрүүлсэн зүйл бөгөөд герег-латин хэлний үгсийг олон улсын орчин үеийн зарчмаар өөрийн хэлэнд буулган, уг нь тухайн үндэсний хэлний үг, санаа нь нийгэм олон улсын байдаг хэлбэрийн шатанд тэр тухайн үед арай хүрч чадаагүй цагийн байдал ил үзэгдэнэ. Одоо бол, антропос гэдэг герег үг нь хун гэсэн үг, метрон гэж хэмжил гэсэн утгатай герег үг, -ия гэдэг орос төгсгөл нь зүй гэсэнтэй дүйх бөгөөд тухайлсан ухаан судлал гэдгийг заасан утгатай болохыг мэдэх хун, огт төвөггүйгээр антропо-метрия гэдгийг хүнхэмжилаүй гэж мөн тэр герег нэрийн нийлмэл бүтцийг яг л тэр зарчим ёсоор нь буулган, уг монгол, санаа нийтийн монгол нэр бүтээх хөгжлийн шатнаа хүрсэн тул, "бие бялдар" гэж тайлбарлан тоймлохгүй, яг олон улсын тогтсон зарчим бүхүй нэр болгож болох байна. Нөгөө "зан суртал" гэдэг нь даруй герегийн хэлнээс этнос гэсэн бөгөөд угсаатан гэсэн нэр, графейн гэж бичих зүй гэсэн үгтэй хоршиж, 1842 онд Мозен гэдэг эрдэмтний зохиосон нэрийг тэр гэрэг үгийг нь монголын хэлнээ буулган, Мозены аргаар нийлмэл үг болгоход даруй угсаатнызүй гэсэн нийлмэл нэр бүтэх ажээ. Энэ тухай монгол хэлний үгсийн санд огт үг чутахгүй тул, одооны олон улсын зарчмаар утга санаа нь олон улсын байдалтай, уг нь тухай тухайн улсын хэлний үгээр буулгадаг шинжлэх ухааны зарчим, дэлхий нийтийн хөгждөөр гарч ирсэн нь, монгол бичгийн хэлний нэр утга элбэг дэлгэр болоход бас нэгэн адил тухал болно.

Бас XVII зууны нэгэн хятад бичигт үзвээс, Хөх хотоос хамниган овгийн монголчууд урваж, умар зүг Говь туулан арилбай хэмээсэн буй тул, Эрөөгийн хамниган байж бас мэднэ. Кун ч болтугай, олон газар усны нэрийг байнгааваас, чухам хамниган хэлний үг болох бөгөөд, шингээлбээс: Эрөө, Хавла, Балжи, Балжихан, Минж, Хэрлэн, Онон, Хөлго, Зэдэ, Шөх, Орхон, Сэлэнгэ хэмээх нэрнүүд цөм хамниган хэлний нэр болой. Эдгээр нэрнүүд бөгөөс, Чингисээс уртрах ба Чингисийн үеийн сударуулт үзэгдэх тул, Эрөөгийн хамнигачдын ндээшин сууринсан нь их эртний явдал болж мэднэ.

Эдгөө бүхүй хамнигад, монголын тунд цөөн тооны хүмүүс суух тул эх хэлээ мартаж, монгол хатхын хэлтэй болсон ба зарим нь аялгуу баахан хатуугаар татах мэт үзэгднэ.

Талькогринцевичийн явах үест эдгөөгийн халуун усны орчим Сэцэн ханы албат хамнигад 250 өрх бөгөөд ам тоолбаас, 1000 илүү хүн бэ богд Жобзундамба гэгээний шавь хамнигад нь Илбаг, Тангу зэргэ нутгуудаар 200 өрх, хүн амын тоо 800 орчим байна хэмээжээ. Их Шавийн хамнигад хоёр отог байсныг Шанзоддын яамны дансаас мэдэж болно.

Эрөөгийн хамнигад нь овог ясаа мартсан боловч, урд 6 овог байсны 4 нь Нийнкин овог, 2 нь хамниган овог хэмээж, зургаан дугаартай явсан билээ хэмээхийг үзхүл, овог буюу отгоор ялгаварлан хэлэлцэх суртал нь саявтар болтол байсан ажээ.

Эрөөгийн хамнигачдын түүхэнд уг Алтайгаас гурван ах дуу удирдан хөдлөж, тэдний хойноос нум саадаг агсаж, ард олон нь явсан. Ан агнахаа мөргөн тул, замын гудас ангийн махаар хоол хийж явсан хэмээмөй. Тэр гурванаас салсан овог буй эсэхийг мэдэхгүй. Эрөө нутагт Өндөргэгээний үе хүртэл ан агнахыг эрхлэж, на гөрөөс, бугу, тураг, булга, шилүүс агнан байжээ. Халуун усны тусыг ч мэдэхчиг үгүй, түүхий мах түрж бордуудан идэж байсныг монгол ламнар очиж, өвчтнийг засахад тустай тул, бүзар үл оруулан, өвчтнийг халуун уснаа оруулахаар зохиосон хэмээжээ.

Сэцэн хан Богд гэгээн хоёрын харияат хамниган, алин алин нь ялгадаггүй, алба татварыг барагдаж, их л ядуурсан бөгөөд Сэцэн ханы хамнигад болбаас, нэргийн алба үзэж байсан ба хөрөнгөнш алба бас үзэх тул, шавьд хамнигачаас илүүхэн ядуурсан байлалтай байжээ. Их Шавийн

хариат хамнигадын өрх бүрийг 5-аас 100 дан хүртэл алба ногдож байсан бөгөөд, нэгэн жилд Шанзоцбын яамнаа тушаах алба нь 8000 дангаас илүү болмой. Сэцэн ханы хамнигадын тушаах алба нь үүнээс хэдэн давхар үлэмж хэмээжээ.

Шавийн хамнигачыг Шанзоцбын яамнаас тавьсан отгийн дарга нар элхирч явсан. Сэцэн ханы хамнигадыг 150 ам болгоныг нэг зайсан захирч явсан хэмээжээ.

Хамниганы зан ааль нь ер төлөв томоотой ба шидрага үнэнч, номхон тул,гэмт хэрэг будлиан гарах ч үгүй бөгөөд,дарга зайсангууд нь алба татвар хураахлас өөр ажил байхгүй бэ алба хуваахтал ардын сон-госон цтгэлт төдөөлөгчнт хуваалтаг ажээ. Урд ой тайгад ан гөрөөс элбэг байх цагт хамниган, мал ажлын дээр ан гөрөөл хийх тул, ятмаггүй, нилээд баялаг байжээ. Суулийн үест ой модыг хялан огтлож, ан гөрөөсийг гам хэмгүйяа дуустал алах болсноос хойш хамниганууд зөвхөн хэрэмчлэх төдий болсон ба мал нь бас цоройтжээ.Урд болбаас,хамниганы олонхи нь үхэр 60, адуу 20-30, хонь 300 хүртэл байсан ба баячууд нь адуу 1000 хүртэл байсан билээ. Өдгөө /1904 онд/ баян хүн нь үхэр 100, адуу 20, хонь 50-тай болбаас баян хэмээгдэх болжээ. Хамнигадын үхэрний нь мял-зан барсан ба сүүлийн хэдэн жилд бодоо тахлаар⁺ хүн олон үхигээж, тоо хорогцсон байна. Тийм боловч, хамниганы оюун сэргэлэн, аливааг онох мэдэхүйдор түргэн тул, ан агнахын оронд шинэ ажил эрж, алтны уурхайн газраа түлээ юм зөөх буюу уурхайн ажил хөдөлмөр хийх зэргийн олбор байх болсон байнам. Өвөлд хэрэглэсүгэй хэмээн мойл, сараанд, халиар, мангир,самар,мөхээр мэтийг тууж хатгалах бөгөөд ойр зэргэлдээ мон-голчууд нь энэ мэтийн бэлтгэл хийдэггүй байнам.

Хамниганы өнгөрсөн түүхийг үзвээс, монголын адил язгууртан ноёдын анги байхгүй тул, зан суртал ба өөрийн хүү'эрх чөлөөний мэдрэл нь бүрхэгдүүлэн ларагдаж алдагдаадуй бөгөөд хамнигадын зан ааль, үзэл бодол нь эвдрээдүй, ардчилсан үзэлтэй,эрх чөлөөгөө хамгаалах цуртай,

⁺ Бодоо гэдэг өвчнийг цээрлэн жинхэнэ нэрий нь зайлуудан нэрлэхдээ нэцэг өвчин, цагаан бурхан гэх зэргээр нэрлэх боловч, ёстой нэр нь бодоо мөн. Дайчин улсын албан бичигт бас "их зэргэ" хэмээн зайлуудан нэрлэх нгу буй. Оросоор бодоог оспа хэмээмүү.

бусаа хүмүүст үнэ хөлсгүйгээр туслахыг хичээх; хэлсэн үгэндээ эзэн болох тэргүүтэн сайн суртлын ард болмой. Хулгай худал байхгүй, архи согтлол уухгүй, гэрийн дотор эвтэй, эхнэрийн байдал нь монголчуудаас цээр бөгөөд дарлагдлыг үздэггүй бэ эрчүүд нь гэртээ бүхүй цагт эхнэ- рүүдтээ тус хийлцэж есвэрийн талаар болбаас, хамниган айлд дөрөв га- ван охид хөвүүд байх бөгөөд хааяа 13 хүүхэдтэй айл ч дайралдна хэмээх зэргийг эрдэмтэн Талькогринцевич тэмдэглэжээ.

Өдгөөгийн хамнигад ердөө монгол исгий гэрээр суумой. Хол нүүх- гүй. Өвөлжөөн зуслан хоёрыг ээлжлэхээс үл хэтрэнэ. Малын ажлыг эрх- лэх тул, өвс хадах болжээ. Гагцхуу Минж голын салбар Зэлтэй хэмээх горхоор суугч цөөн тооны хамниганыг 1927 онд Судар бичгийн хүрээ- лэнгээс явуулсан эрдэмтэн Кондратьев бээр замын гудаст шинжилсэн бөгөөд зуны цагт хар модны холтсоор барьсан гэртэй. Өвөлд мухар мо- дон байшинтай. Исгий гэр барихгүй. Ууний учир нь болбаас, хонь цөөн тул, исгийгүйгээс болмой. Зонхи ан агнаж амьдрах ба адуу сарлаг бай- на. Бүгд 42 ам хүнд адуу 42, үхэр 60, сарлаг 70-80, хайнаг 5, ямаа 40, хонь 100-гаас 200 хүртэл бий хэмээжээ. Суух орон сав 11-ийн дотор найм нь холтсон гэр, гурван нь дөрвөлжин мухар модон байшин байснаас гадна, зарим гэрийн дэргэд юм агуулах модон амбар пин ба тугалын хо- роо байна. Малаас гарах арис хялгасыг Улаанбаатарт аваачиж худалда- на. Ан агнахдаа зөвхөн идэхийн тулд агнах тул, ан гөрөөс нь дэргэдүүр ойр ажиггүй явж байна хэмээх зэргийг тэмдэглэжээ. Энэ Их Шавийн харьяат хамнигад болоюу. Сэцэн ханы харияат хамнигадыг ардын засаг байгуулж, нутгийн шинэ захиргаа явуулснаас хойш уул хошуунд татаж аваачсан хэмээх бөгөөд үүний үнэн худлыг магадлаж чалаадуй.

Кондратьевын хэлэх нь, мөн Талькогринцевичийн ажил, хамниган хүн, өөрийн үндэсний хэл мартжээ. Хэв байдал нь монгол болжээ хэмээ- жээ.

1931 оны эхэн хувьд Ходоодноор нутаглах Гомбо өвгөний зэрэг хамнигадлугаа танилцан, бага сага ярилцаас, их л төв бөгөөд сэргэлэн шудрага цэхч, ажил амьдралга нь мал маллахаас гадна ан агнах ба юм бага сага ачих мэт болой. Үлэмж баян ч үгүй, бүр хоосон ч үгүй, нэгэн жигд, дунд хирийн амьдралгатай, бие бялдар нь монгол буриаа алинаас ч чийраг чанга биетэй мэт үзэгдэнэм булгээ. Монгол буриаа дугаа дэмий

холилдохгүй, оордог суумой. Өөр зуур эв эе ихтэй, цагаан санаатай, шу- луун шудрага зантай хэмээн олон эрдэмтний шинжилдэг нь үнэн хэмээн саналаа. Талькогринцевич, Ерөөгийн хамнигадыг бие бялдарын талаар шинжилсэн нь их боловч, энд эс бичивэй. Нийтдээ олонхи нь дунд ба дун- цаас дээш биетэй мэт хэмээн эрдэмтэн Цэвээн, монгол хамниганы тухай бичсэн зүйлээ, хамниган ардын сайн сайхан санаатайгий нь магтан төгс- гөсөн билээ. Эдгээр мөрийг уншин үзэхэд, хамниган ардын тэр сайн сай- хан зан чанарын зүйл нь, Маркс Энгельсийн зохиолд дээр эртний үеийн хүний феодад хөрөнгөтний ёсонд эвдрээгүй сайн сайхан чанарыг магнай тэнийм үгээр бадруулан дурдсаныг санагдуулах алам.

Мөн Цэвээнгуайн 1911 онд Ононы хойт биеийн хамниганы тухай цуглуулсан үлэмж сонин материал бичмэл ганц хувь эхээр Ленинград хотноо тэр үеийн Азийн музей, өдгөөгийн Азийн улс түмний хүрээлэн- гийн бичмэлийн хөмөргөнд байгаа нь, тавин ялуу жилийн өмнөх Ононы хамниганы угсаатнызүй, хэлний байдлын талаар маш сонин гэрч бөгөөд тэр үеэс хойш ихэд өөр болсон байдалтай харшуулан үзэхэд нэн чухал зүйл бийг дурдалтай. Үүнд, монгол хамниганы тухай судлагаа хийх хүн, тэдгээр материалыг биеэр Ленинградын хөмөргөнөөс үзэх буюу хэвлэг- дэн гарах аваас, тухайлан эрэн сураглаж үзэх нь тун хэрэгтэй гэдгийг дурдалтай байнам.⁺

Монгол хамниганы тухай орчин үед гарсан зүйлээс мажарын эр- дэмтэн Көөхалми Каталины бичсэн нэгэн өгүүлэл, тусгайлан Хэнтийн Да- дал сумын монгол хамниганы аман аялгууны зүйл, Умарт Монгол газар, жич Байгалын өмнөх хязгаарт буй хамнигацуулын хэл аялгуу монголжсон асуудалд зориулан бичсэн өгүүлэл болно.⁺⁺

⁺ Польш Ард Улсын Краков хотондахь Шинжлэх ухааны Акаде- мийн салбарын бичмэлийн зүйлд Котвич Владислав монголч эрдэмтний цуглуулганаа Турухан хязгаарын хамниганы хэл аялгууны тухай хэрэг- лэгдэхүүн - өнгөрсөн зууны сүүлийн үес тэмдэглэсэн хамниган-орос то- лийн зэрэг зүйл, жич солоон манжийн хэл аялгууны хэрэглэгдэхүүний гар бичмэл зүйл бий нь, монгол хамниганы жинхэнэ хамниган хэл аялгуу тэр гүүтэнтэй харшуулан үзэхэд сонирхолтой зүйл байгааг дурдалтай.

⁺⁺ Käthe U.-Kohalmi, Der mongolisch-kamniganische Dialekt von Dadal Sum, und die Frage der Mongolisierung der Tungusen in der Nordmongolei und Transbaikalien. Acta Orient. Hung. Tomus ix. Fasc. 2. Pp. 163-204.

Монгол хамниганы хэл аялгууны тухай монгол хэлээр гарсан зохиол хэмээвээс дэд эрдэмтэн Мишигийн нэгэн өгүүлэл, Монголч эрдэмтний их хуралд илтгэл тавихаар зориулан бичсэн зүйл болно. Эрдэмтэн Цэвээнийн хамниганы бичсэн зүйл, мөн дэд эрдэмтэн Мишигийн бичсэн энэ хоёр зүйл, сая дурдсан мажар эрдэмтний герман хэлээр бичсэн өгүүлэл энэ гурван зүйл даруй монгол хамниганы тухайд тусгайлан бичсэн зүйл болном бөгөөд Көөхалмийн өгүүлэлд хамниган хэлний тухай бичигт зохиол нилээдийг шуурдан бичсэн сонин зүйл бий боловч, Хэнтийн Далай дахь хамнигануудын аман аялгууны тухай богино хугацаан дотор сурвалжилсан тул, монгол хамниганы хэл аялгуу, овог ясны талаар нарийвчлаж хараахан чадсангүй. Мишигийн зохиол мөн сонин мэдээ зүйл буй боловч, бас л дэлгэрүүлэн бүртгэх бололцоо олдсонгүй. Чингэвч, эл хоёр зохиол бие биедээ нөхвөр болно.

Уншигчид өдгөө толилуулан буй энэ ганц сэдэвт дотор өдгөөр урлах зохиолын дээр өгүүхэн нэмэрлэн ахиулахыг оролдсон хувьд, монгол хамниганы овог яс, хэл аялгууны байдлыг гол нь Хэнтий Дорнод аймгийн хамниган бүхүй нутгаар сурвалжласан зүйлийг цуглуулсан зүйлийнхээ хэмжээгээр үзүүлэхийг хичээсэн болно.

2.МОНГОЛ ХАМНИГАНЫ ТАРХАЦ ОВГИЙН УЧИР


Эрт дээр цагт хамниганы оршин сууж байсан газрыг гол мөрөн, уул усны нэр тэргүүтэнд хамниган нэр эртнээс үлдэснээр одоо цагт хамниган байдаггүй газар урьд дээр цагт хамниган аймаг оршиж байсан уугал хүмүүс байсныг газрын нэрзүйгээр⁺ танин мэдэж болно. Хөвсгөл

+ Гөрөг-латин соёлын хүрээний улсын зарим хэлнээ хэрэглэдэг гөрөг тогос хэмээх газар гэсэн үг, онома гэж нэр гэсэн хоёр үгийг нийлүүлэн Белгийн Курт гэдэг эрдэмтэн анх 1887 онд зохиомол нэр бүтээн. Газар орны нэрийн зүйлийг хэл буюу түүхийн үүцнээс судлах судлалын нэр болгосон нь франц хэлнээ *toponymie*, орос хэлнээ энэ зууны эхээр *топонимия* гэдэг хэлбэрээр орж ирсэн нь, тэдгээр гөрөг нэрий нь олон улсын журмаар монголчилбол, даруй газрын нэрзүй гэдэг судлал болно: топо-газрын, ним-нэр -ия-зүй. Үүнд зүй гэдэг үг бол монгол бичгийн хэлнээ ухааны нэрийг бүтээхэд орос хэлнээ -ия, -ика гэдгийн утгатай дүйнэм бөгөөд орос бичгийн хэлний -логия гэдгийг даруй судлал гэдэг монгол үгээр цүйлгэж, тухайн судлал ухааны нэр бүтээх нь: география-гео- = газар, графия бол бас = зүй тул, география = газарзүй, геология-газарсудлал гм.

аймагт Дэлгэр мөрөн гэдэг нэртэй мөрөн явсаар байгаад нэг газраас гэгт Сэлэнгэ болчдог нь, түүхийн ууднаас эхээр нь монголчууд хэзээний оршоор суусан учраас Дэлгэр гэдэг нэр өгсөн нь, эрт цагт хамниган суудаг нутагт тэр мөрөн үс нуруй хамниган Сэлэнгэ буюу түүнийг монголчилбол Темерт гэсэн нэртэй аж, эүүн зүгээс монголчууд тэр хамниганы нутагт хүрэлцэн ирэхдээ, уугал хамниган хүний эртнээс өгсөн нэрийн хэвээр хэрэглэн, нэгэн мөрөн үс, адаг дууд биедээ хамниган нэртэй, уугал монгол хүн нутагласаар ирсэн эхээрээ Дэлгэр гэдэг монгол нэртэй болж ирсэн түүхтэй ажээ. Тэр хамниган Сэлэнгэ гэдэг нэр нь эртний түрэг хөшөө чулууны бичээсэнд гэрчлээстэйг бодвол, эртний түрэгийн уест тэр хамниган нэрээр нь түрэгүүд нэрлэсээр ирсэн болно. Энэ мэтээр одоо хамниган байдаггүй газар эртний хамниган нэр бүхүй газар үс, манай нутагт үлэмж бий нь судлан шинжилж, хэл түүхийн ууднаас нягтлахад сонин зүйл гарах алам.

Тус улсын архивт буй албан бичиг дансын зүйлийг шуурдан үзэхэд, монгол хамниган ямар аймагт захирагдаж, албан үзэж байсны мэдээ буй нь манж Дайчин улсын Түгээмэл элбэгтийн 1-2-3 дугаар оны данс бичигт Сэцэн хан аймгийн Буяндэлгэрийн хошуунд хамниган олонтой. Гун Пунцагцэрингийн хошуунд хамниган олонтой. Засаг Дашдэндэвийн хошуунд хамниган олонтой. Гун Гонцогцэрингийн хошуунд хамниган олонтой. Энэ дөрвөн хошуунд тусгайлан хамниган багтай. Сэцэн хан аймгийн бу-сад олонхи хошуунд цөөн цөөн өрх хамнигантай боловч, тусгайлан хамниган отог баг гэх зэргийн захиргааны байгуулалт байхгүй, хошуу сумын дотор багтан захирагдаж байсан мэдээ, тайм хошуунд тэр тэр нэртэй хамниган өрх айл бий гэх зэргийн мэдээ бийг үзэхэд монгол хамниганы гол төлөв нь Сэцэн хан аймагт байжээ.

Түгээмэл элбэгтийн нэгдүгээр он гэдэг нь аргын 1851 он болох тул, хамниганы тухай данс бичиг нь зуу гаруй жилийн өмнөх баримт



болно. Агуулга нь, ⁺отгийн дарга мэтгэйт тохоон талбисан, алба оноосон, кич хөрөнгө малын байдал тодорхойлсон албан бичиг баримт болно.

Сэцэн хан аймгийн Буяндэлгэрийн хошуу нь суулдээ Өөрөөн засах Монгол улсын үед Далай Дархан бэйлийн хошуу гэдэг нэртэй болжээ. Бэйлийн хэргэм зэрэгтэй болохын өмнө даруй Барайшир гүнгийн хошуу гэж байсан учир, тэр хошууны хамниган биеэ Ба гүнгийн хамниган гэдэг байжээ. Одоо ч зарим настан хамниган мөн чингэж нэрлэх ину буй. Хожим Барайшир гүн нь Далай Дархан бэйлэ болоод, ардын засгийн үес аймаг хошууны нэрийг ноёдын нэрээр нэрлэдэг ёсыг халж, уул усны нэрээр нэрлэх болоход Хан Хэнтэй уулын аймгийн Хан Хэнтэй уулын хошуу болж, өдгөө Хэнтэй аймгийн Хэнтэй Жаргалтхаан суманд тэр хошууны нэгэн хэсэг нутаг дэвсгэр нь оржээ.

Гүн Пунцагдэрингийн хошуу нь, үе улиран залгамжилсаар Сэцэн хан аймгийн Эрдэнэ гүнгийн хошуу болж ирээд, ардын төрийн үес нутгийн захиргааг өөрчлөн зохиоход Хан Хэнтэй аймгийн Батхан уулын хошуу гэдэг нэртэй болж, өдгөө Дорнод аймгийн Баян-уул, Цагаан-овоо сум, Хэнтэй аймгийн Норовлин/чухамдаа Нораолон - Норболон/сум болжээ.

⁺ Агуулга гэдэг уг, монгол бичгийн хэлнээ шинэ уг болохыг энд дурдаж, түүнийг анх 1929-30 оны үес тэр үеийн Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл, сурах бичгийн зүйлийг эрхлэж байсан багш Индорж, германы Inhalt, орос бичгийн хэлнээ содержание гэсэн нэрийг монгол сурах бичиг тэргүүтэнд хэрэглэх хэрэгцээ гарсанд агуул- гэдэг үгнээс -га дагавар залган агуулга гэдэг "шинэ үг" үүсгэн анх хэрэглэсэн билээ. Тэхдээ, Шинжлэх ухааны хүрээлэнгийн дуун ухааны тасагт ирж, Inhalt - содержание гэдгийг монголоор нэрлэх хэрэгцээ, хичээл заах, сурах бичиг зохиоход хэрэгтэй болж байна, утга нь гэж хэлж болох боловч, номын эх буюу төгсгөлд "содержание - Inhalt" гэхэд утга нь хэмээхэд арай хайшаа юм бол, өөр үг, тэдгээр европ хэлнээс хуулбарлан авч, орос хэлнээ содержание гэж бий болгосны нэгэн адил арга хэрэглэвэл яана гэж санаачлан зохиосон нэр болно. Тэр содержание гэдэг утгаар ном дотрох зүйлийн агуулгыг тоочсон жагсаалтыг зарим хэвлэлд "гарчиг" гэж гаргадаг байсны нь, уг гарчиг гэдэг нэрийн утга бол, бүх европын хэлнээ "каталог" гэдэгтэй яг дүйдэг учрыг танин мэдэх тул, тийн хүү "содержание" гэдгийг "гарчиг" гэж болохгүй юм байна гэж "агуулга" хэмээсэн нь одоо бичиг зохиолд агуулга гэдэг нэр гүйлгээнд оржээ. Хожим монгол үгийн гарал үүслийн судлагаанд хэрэг болох цаг бий гэж үүнд тусгайлан өл үг бий болсон цаг, бий болгосон хүний нэрий нь дурдлаа.

Засаг Дэнзэвийн хошуу бол, суулдээ Сэцэн хан аймгийн Дайчин бэйлийн хошуу нэртэй болж, ардын төрийн өхөөн Хан Хэнтэй уулын аймгийн Батнорбо /арван хоёрдугаар бол Батноров/ уулын хошуу болж, хошуу татан буулгахад Батноров, Норовлин, Бэрхийн хороо захиргаа гэдэгт багтсан. Гүн Гончигчэрэнгийн хошуу нь суулдээ Хөвчийн Дайчин жонзон эвсгийн хошуу гэдэг нэртэй болж, нутгийн захиргаа өөрчлөх үед Хан Хэнтэй уулын аймгийн Биндурнаа⁺ хан уулын хошуу болоод, хожим хошуу татан буулгахад нутаг нь Биндурнаа /Биндэр/ сум, Баян-адарга сум, нэг хэсэг нь Хэнтэй аймгийн Хэнтэй суманд багтжээ. Бас нэг хэсэг нутаг нь Хэнтэй аймгийн Өмнөдөлгөр, Батширээт, Далайд оржээ.

Сэцэн хан аймгийн олон хошуунд тархан оршиж байсан эдгээр хамниганаас гадна Жөбзундамба хутагтын шавь хамниган Ерөөгөөр нутагтай байж эх нутаг нийлсэн хошууны хамнигантай төрөл саалий харилцаа холбоотой байжээ. Сэцэн ханы гол хошуунд захирагдаж байсан хамниган нь биеэ ханы хамниган – аман аялгуунаа ханы гэж ы-гий нь уртаар дуудахгүй сэрэмжлөөр, бараг хану хамниган нэмсэн дууддаг бөгөөд, нөгөө болдын шавь бологсод нь биеэ шавь хамниган хэмээдэг байлаа. Саадан хамаатнаа тун сайн мэдэх тул, тун саяхан болтол, ойр төрөл айлын хүн хоорондоо гэрлэхгүй байгааг манай мэдэлд буй мэдээ цөм нэгэн адил гэрчлэвэл.

Хэлний хүнд Ерөөгийн хамниган, Мөлгөөмөртын хамниган, Цэнхэрмандал, Мөрөн дээрэг дутгийн хамниган, орчин тойрныхоо монголчуудтай бараг илгээгүй хөл аялгуутай болж, нарийн ажигласхийвэл, орчин тойрны монголчуудын өө-гөөр дууддагийг ээ-гээр дуудан, ан гөрөө гэдгийг ан гүрээ, гөрөөлөх гэдгийг гүрөөлөх, малгайгий нь гэх мэтийг

⁺ Биндурнаа гэж монгол хэлнээ энэтхэг хэлнээс орсон нэгэн зүйл эрдэнийн чулууны нэр. Оросоор берилл, францаар берүл гэдэг нь латин хэлний *beryllus* гэдгээс арван хоёрдугаар зууны үед *Marbode* гэдэг хүний зохиолд гарсан бөгөөд уг нь гөрөг хэлнээс латин хэлнээ орсон нэр. Гөрөг нь эртний энэтхэгтэй харилцаатайгаар, манай биндурнаа гэдэг нэр, энэтхэг-гөрөгтэй соёлын хэлхээ бүхүй соёлын эртний соёлын өвийн үг болно. Суулийн хориод жилд Биндэр гэж хураан нэрлэх болсон нь, лаборатори гэдгийг лабон гэж манайхан, француудын адил хурааж нэрлэдэгтэй нэгэн адил үзэгдэл буюу.

малгайгий нь гэх мэтээр дуудах төдийхөн авианзүйн баалан ялгаа бүхүй зүйл авианзүйн талаар үзэгдэн, онь хөтнийг өгтрөө гэх зэргээр уг нь монгол боловч, орчин тойрынхоо монголчуудаас бага зэрэг өөр бөгөөд утга анил уг хэрэглэдэг удаа бий. Хэн нь монгол болчихсон боловч, уг нь хамниган угсаа гаралтай гэдгээ үл андах бөгөөд урд Сэцэн ханы нэгэн хэсэг хамниганыг ханы золыгт гарсан гэж хэлэгддэг нь ортой байж болом домог яриа бий. Түүний улмаас "золыгт гарсан" гэдгээс зайлуулж, зарим хамнигадуул биеэ хамниган гэхээс зайлан, монгол гэдэг байсан гэж өвгөцүүл нь хэлдэг бөгөөд залуучууд нь монгол хэлэнд оржганц нэг үгийн таталганц өвөрмөц зүйл үзэгддэг нь бий. Тийм аман аялгуутайг монгол хэлний нутгийн нэг салбар аман аялгуу гэхээс хамниган аялгуу гэж үзэхгүй, гагц хуу хамниган хэлний авианзүйн нөлөө туссан монгол хэлний нутгийн салбар аман аялгуу хэмээн хэлний шөгжлөлийн үүднээс үзэх бий.

Монгол хамниган дотор өндөр настан хэсэг хүмүүсийн аман аялгуунаа монгол хэлний түүхэнд сонин үзэгдэл бийг мөн маш нөөхөн нэгэн хэсэг хамниган, уугал хамниган хэлээрээ өөр зуураа хэлэлцэгсэд бийг хойшид өгуүлэх болно.

Монгол хамниган дотор нилээд хэдэн овог бий. Түүний зарим нь хамниган овог, нэгэн хэсэг нь монгол овог байгаа нь илэт үзэгдэл, түүхийн байдлаас нягтлаж үзвэл, хамниган дотор орж нутагласнаар хамниган хэл аялгууны нөлөө тусаад, биеэ нутгийн хамниганы дотор багтсаны хувил "хамниганжсан" монгол угсаатан, буриад, ар өвөр монгол овог байгаа нь, зарим монгол овогтон, манжийн байлдан дагуулах үес, дайн хөлийн учир хамниган нутагт нуун одоод, маж нар, хамниганыг өөртөйгөө угсаа аймаг нэгтэй гэж халдан довтлож, туйвсан үймүүлэхгүй байсан учраас, тийн хуу хамниган дунд нөөн монгол овогт айл орж, сүүлийн хошоод гурваад зуун жил дотор хамниган болсон бололтой.

Хамниган овгийн нэрийг үзэхэд, нэг хэсэг нь хамниган дагавартай боловч, нинээд олонхи нь монгол овгийн нэрнээ хэрэглэдэг хэсэгтооны дагавар хэрэглэсэн байнам. Эл үзэгдэл бол, гагц хамниганд ч үзэгдэж буй хэрэг бус, маш дээр нагт монгол бус овог аймгийн нэрнээ монгол хэлний хэсэгтооны дагавар хэрэглэдэг байсныг Судар бичгийн Ху-

рээлэнгийн хүндэт гишүүн нангиагч эрдэмтэн Пеллио /Pelliot / эртний нангиаг сударт Тү-кю гэж тэмдэглэсэн нэр бол, дээр эртний нангиаг урга үсгийн дуудалгыг сэргээн босговаас, даруй тюрк+үд гэж дуудаж байсан нэр болно хэмээн магадлан нутгаж, эртний жинхэнэ дуудалгы нь босгосон билээ. Үүнд монгол хэлний эртний ю нь шинэ үеийн монгол хэлнээ даруй у болон дуудах зүйтогтоолтой болсон тул бид монгол худам үсгээр Джю - латинаар галиглавал küñin , кирилээр галиглавал кю-мюн гэснийг шинэ үеийн монгол хэлнээ даруй хүмүн, хүмүүн гэж ү-гээр дуудах болсон авианзүйн хөгжлийн шатнаа явж байгаа тул, эртний герег латин зэргийн мөхсөн хэлтэй адилгүй, аман аялгуу нь хөгжин хэлэлцсээр буй хэлэндээ эртний эгшгийг одооныхоо амид бөгөөд хүчин төгөлдөр хэлнийхээ авианзүйн хууль зүйд нийцүүлэн "хүмүүжүүлэх" гэх мэтээр дуудахаас биш "кюмюжюкюлөкю" гэж дуудахгүй нь орчин үеийн монгол хэлний зүйтогтоол тул, эртний сударт гардаг нэр үгийн зүйлийг одооныхоо монгол хэлний авианзүйн ёсоор дуудахыг хэлний шинэжлэлийн боловсролтой хуу, эрхбиш ухамсарлавал таарах үүнд эртний тэр тюркют гэдгийг түргүүд буюу түрэгүүд гэж дуудах нь түмэн зүй болно. Үүнд монгол худам хэлнээ Джю гэдэг нь, эртний дуудлагаар даруй тюрюг, орчин үеийнхээр бол түрүг боловч, "үсгийн дүрэмд" ү-гээр эхэлсэн үгийн дараа цөм ө бичнэ гэж 1920-30 оны үес латин үсэг хэрэглэхэд тогтоосон зарчмыг кирел үсгийн "дүрэмд" нэгэн адил дагаж шийтгүүлэн буй учир түрүг гэдгийг түрэг хэмээн бичивч, амид хэлний аман дуудалганд түрүг гэж дуудан буйг аман хэлний авианзүйн үзэгдлийг ажиглагсад юун андах ажээ.

Эртний тэр түрэгүүдийн хэлнээ буй улс төрийн нэртөмбөо нь цөм-монгол хэлний хэсэгтооны дагавартай байдаг нь -4-5, зууны үед монголын соёл нь түрэг зэргийн аймаг улсын хэлнээ нөлөө тусгалаа үзүүлж байсны тодорхой гэрч баримт бөгөөд, монголын соёлын түүх судлах хүнд эл хэлний гэрч заалт бас чухал сонин баримт болно. Үүнд, хамниган угсаатны овгийн нэрнээ тэр эртний түргүүдийн овог угсаа, улс төрийн нэрнээ монгол /эртний сяньбий/ хэлний хэсэгтооны дагавар хэрэглэж байсны нэгэн адил үзэгдэл нь, заавал манжийн байлдан дагуулах үеийн арван долоо-наймдугаар зууны үзэгдэл биш, дундад эртний буюу бүр ч дээд эртний үеийн уламжлал байж болох тул, энэ тухай судлагаа хийхэд даруй

нэгэн зүйлийн сэдэв байна гэж үзэж болох байна.

Монгол улсын арвандооон он, аргын 1927 оноос өдгөө хүртэл мөнхий цуглуулсаар ирж, сүүлийн хэдэн жилд манай Хэл зохиолын хүрээдөнгийн шижээний ангийнхантай явалцаж, хамниган оршин суудаг аймаг суумаар энэ тухай сурвалжлалцан сурагнасан мэдээ баримтаар олж авсан хамниган угсаатны дунд одоо байгаа овгийг ихэвчлэн тэмдэглэж авсан гэж бодоход болмоор болж, эс дайралдсан учир тэмдэглэн бүртгэж зааглаагүй овог төдийл олонгүй байх гэж бодох үүнд, манай олсон хамниган овгийг цагаан толгой дэсвэр жагсаан, оршин буй аймаг сум зэргийг хадамаллааас төлөв ийм буй:

Алтанган. Дорнод аймагт Цагаан-овоо, Баян-уул сумнаа буй. Баян-уулд зарим хамниган бас Алтанган гэж дуудах агу буй. Одоогийн кирил үсгийн дүрэмд хэлний урдуурхи н, хэлний хойгуурхи н гэдгийг ялгахгүй ганц хэлний урдуурхи авиа тэмдэглэх н үсгээр хоёр өөр зүйлийн гийгүүлэгч авиа тэмдэглэдэг нь, хэлний хойгуурхи урдуурхи хоёр өөр газар үүсгэлт гийгүүлэгчийг ялгахын аргагүй тул, хойшо хамниган үгийн хэлхээнд тэр ялгаагий нь кирил үсгийн жинхэнэ журмаар нь үзүүлээ.

Багдарин. Хэнтэй аймаг Дадал суманд буй.

Багшиар. Дорнод аймаг, Баян-уул суманд буй.

Балихаагир. Хэнтэй аймаг, Дадал суманд буй.

Балтаагин. Дорнод аймаг Цагаан-овоо суманд бий.

Бамбадай. Дорнод аймаг Баян-уулд бий.

Бамбачаан. Хэнтэйд Дадалд, Дорнодод Баян-уулад.

Баргужин. Хэнтэйд Дадал суманд бий.

Баягид. Дорнод аймагт Цагаан-овоод бий.

Баахашид. Хэнтэйд Дадалд, Дорнод аймагт Баян-уулад. Баян-уулын зарим хамниган, эл овгийг бас Баахашид хэмээн дуудах агу буй.

Бопиндор. Дорнод аймгийн Дашбалбар суманд бий.

Бопонг ууд. Хэнтэйн Дадал суманд буй. Эл овог бас хори бурмадын арван нэгэн омгийн нэг нь бөгөөд Бодон гэсэн ангийн нэ-

рээс үүдсэн нэр бүхүй овог болно. Дээд эртний өвөг нь Бодон нэртэй хун байснаас үр хүүхэд нь олон болохдоо Бодонгууд хэмээн нэршсэн байж ч болно. Заавал Бодон султэн / / гэж үзэх баагүй болуу.

Гавунаг. Дорнод аймагт ийм хамниган овог буй хэмээн дэд эрдэмтэн Мишиг сураг гаргасан боловч, чухам сумы нь тодруулсангүй.

Гачинха. Дорнод аймаг Баян-уулад.

Горлууд. Дорнод аймаг Дашбалбарт. Тус сумын хамнигацуул бас эл овгийг Горлууд гэж дуудах ану буй. Горлус гэх ину буй, Горлуус хэмээгчид бас буй. Өвөр монголын Горлос гэдэг монголчууд хамниган дунд оролцоод, хамниган овогтон болсон ану буюу.

Гуринка. Хэнтэй аймаг Дадал суманд бий.

Гучид. Дорнод аймаг Баян-уул сумнаа бий. Хори арван нэгэн овгийн нэг нь хамниган дунд орсны гэрч буюу. Боржигин дунд бас Гучид гэдэг обог байдаг мэдээ бидэнд буй.

Гүнээкин. Дорнод аймгийн Дашбалбар, Булган, Баян-уул, Цагаан-уул сумнаа буй. Эл овог бас Увс аймгийн баяд дунд бий.

Дагаанхан. Хэнтэйд Дадалд; Дорнодод Дашбалбар, Баян-уул, Эрээнд, мөн Баяндун суманд бий.

Дагуур. Дэд эрдэмтэн Мишигийн мэдээгээр Хэнтэйн Дадалд бий.

Долаар. Дорнод аймгийн Цагаан-овоо суманд буй.

Долоод. Дорнод аймгийн Цагаан-овоо сумын хамниган дунд эл овог буй. Жич бидний олж авсан мэдээгээр эл овог бас халх монголчуудын дунд буй. Үүгээр бодвол, хамниган дунд дээр нэгэн цагт орсон монгол овог омгийн хүмүүс болном бөгөөд уг овгийн нэр нь монгол хэлний тооны нэрээс үүссэн байдал мөн монгол гаралтай овгийн нэр болохыг давхар батлам.

Дулиасэл. Баянтүмэнд тохиолдсон. Хэсэгтооны -сэл гэдэг жинхэнэ хамниган дагавар болох тул, гарцаагүй чухам хамниган овог ажам. Эл -сэл дагавар нь хамниганд төрөл манж хэлнээ даруй -са, -сэ хэлбэртэй амуу: гүчү+сэ - нөхөд гм.

Дулигаад.

Хэнтэй аймагт Дадал суманд; Дорнод аймагт Цагаан-овоо, Баян-уул сумнаа буй. Хэл зохиолын хүрээлэнгийн шинжилгээний ангийн гишүүн Сумняабаатар бас Цагаан-овоод Дулигад гэж урт эгшиггүй хэлбэрийг тэмдэглэсэн байна. Үүнд урт эгшгийн тэмдгийг талбихыг мартсан ч байж болно, мөн эрийн эгшигтэй хэлбэр ч байж болно.

Дунээкир.

Хэнтэйн Дадалд.

Дөрийцэгэд.

Хэнтэйн Дадалд.

Залтууд.

Дорнод аймгийн Дашбалбар, Цагаан-овоо, Баяндун сумнаа.

Залайр.

Дорнод аймгийн Баяндун суманд, бас Дашбалбар суманд буй. Эрээнд Жалайр хэмээн дуудан буй нь кирил үсгийн ж үсгээр тэмдэглэдэг шүргэх гийгүүлэгч биш, хамжин шүргэх гийгүүлэгч бөгөөд кирил нийтийн үсэгт хэлний шинжлэлийн боловсролтон бүхний дж хэмээн орос, украин, белорус, болгар зэргийн кирил үсэгт улс бүхнээ хошоод үсгээр эл хос гийгүүлэгчийг тэмдэглэдэг одоо цагийн нийтийн зарчмаар бол Джалайр болно. Нөгөө Залайр гэдэг нь бас л хамжин шүргэх цэ тул, даруй Дзалайр хэмээн дуудах тул, дан шүргэх гийгүүлэгч авианы З бус бөгөөд, харин буриад аялгуунд Залайр гэж дан шүргэх э гийгүүлэгчийн байдалтай. Тэр нутаг хавийн халхчуудын аман аялгуунаа эл овгийн нэрийн эхний хамжин шүргэх гийгүүлэгчийг мөн хамжин шүргэх ДЗ-ээр дуудахаас бус, дан шүргэх З гийгүүлэгчээр үл дуудах тул, Дзалайр, Залайр, Джалайр, Жалайр гэж хамжин шүргэх, дан шүргэх хоёр тус тус ялгамжаатай байдлаар дуудан буйг хэлний шинжлэлийн бичигт эс ялган дурдвал, шинжилгээ бус болно.

Эл овгийн нэр нь даруй бидний сайн мэдэх монгол овгийн нэр тул, хамниган дотор эрт нэгэн үед тэр Жалайр – Залайр овгийн төлөөлөгчид оролцсон нь үүгээр

гөрчлөгдөн буй. Ар Өвөр монгол Жалайрын өдгөөгийн аман аялгуунаас хамниган Жалайрын аман аялгуу баахан өөр байна.

Замал.

Хэнтэйн Дадал сумнаа буй. Энэ овгийн эхний гийгүүлэгч нь жинхэнэ кирил үсгийн э дүрсээр тэмдэглэдэг дан шүргэх гийгүүлэгч биш, хамжин шүргэх дэ - латин галигаар dz гэж тэмдэглэдэг авиа. Төр хавийн буриад аман аялгуунаа харин дан шүргэх 3 гийгүүлэгчийн байдалтай дуулах нь даруй Замал болно. Халхчуул, хэл аялгуунд нь дан шүргэх э авиа огт байхгүй тул, буриад аялгуунаа Замал гэдгийг хамниганы нэгэн адил хамжин шүргэх ДЗ, латинаар галиглавал гэдэг гийгүүлэгчийн байдалтай дуудаг байна. Иймэд үүнээ эл ялгааг Замал гэхэд гаргаж болохгүй, дан шүргэдэг гийгүүлэгчийн байдалтай юм байна гэж хэлний шинжлэлтэн уншигчийг теерүүлж болох тул, дан шүргэх гийгүүлэгч, хамжин шүргэх хос гийгүүлэгч хоёрын ялгааг дурдахгүй бол болохгүй байна.

Катакин.

Эл эртний монгол овог, монгол хамниган дунд Хэнтэйд Дадал сумын хамниган дунд, түүний залгаа Норовлин /Норболин/ суманд; Дорнод аймагт Баян-уул, Баянтүмэнд бидэнд дайралдсан үүнд адгийн н гийгүүлэгчийг хэлний урдуурхи байдалтай буюу жинхэнэ кирил үсгийн н гэдгээр тэмдэглэдэг авианы байдалаар дууддаг байна. Албан бичгийн дүрэмд хэлний үзүүрийн н, хэлний хойгуурхи н гэдгийн ялгааг гаргаагүй тул, алин болохы нь эс тайлбарлавал, авианзүйн талаар будлиантай бөгөөд шинжлэх ухааны өгүүлэлд ялгах авианзүйн үзэгдлийг ялгаж чадахгүйн хурэх тул, чингэж ялгавры нь тайлбарлахаас өөр аргагүй байна.

Кимор.

Эл овог Дорнодын Цагаан-овоо сумнаа дайралдсан.

Көндө.

Дэд эрдэмтэн Мишигийн мэдээгээр Хэнтэйн Дадал сум-
наа буй.

Көпцөнүүд.

Дорнод аймгийн Цагаан-овоо суманд буй.

Лүнээкөн

Дорнодын Баян-уулад буй.

Лүнээкир

Хэнтэйн Дадал, Дорнодын Баян-уулад.

Модонгор

Дорнодын Баян-уулад.

Модоргон

Хэнтэйн Норовляя /Норболин/, Дорнодын Баян-уулад.

Мөхөөрчин.

Дорнодын Баян-ууланд.

Намиад

Сэлэнгэ аймагт Ереэгийн хамниган дунд Намиад овог-
тон байдаг гэж 1927 онд төндөхийн өндөр настан өт-
гөс хамниган ярьдаг асан. Төв аймгийн Мөнгөнморьт
суманд бас тэр 1927-30 оны мэдээгээр Намиад овог
хамниган дунд бий гэдэг мэдээ буй. Түүнээс хойш
дөч шахам жил өнгөрт буй тул, одоо гучаад настай
хамниган хун, албан бичигт эцгийн нэрээс өөр хэнхэ-
нэ овогоо хэрэглэхгүй болсон улмаас эрт язгуурин
Намиад овгоо бараг мэдэхгүйд хүрч буй бололтой.

Дорнод аймагт Баян-уулын Намиад дотор бас
Хар Шар гэж ялган хэлэлцнэм бөгөөд Цагаан-овоо
сумнаа мөн эл Хар Шар хэмээн ялган нэрлэх зүйл
бийн дээр хамниган Намиад хэл аялгуугаа мөдөх
цөөн хэдэн өтгөс өмгөс бий. Чухам хүү хамниган хө-
лөө баригчдын шувтрага нь тэд хэд болж байгаа бо-
лой. Хамниган хэл аялгууны судлалд сонин чухал
болох тэдний аман аялгуунаас тэмдэглэсэн зүйлийг
хойно гаргана. Тэдгээр хамниган үг аялгууг бид
1963 оны шинжээний ангиар гвахдаа дуухураагурын
хальсанд тэмдэглэж, нөхөөд сэргийн хамниган дууг
бас тэмдэглэн авсны үг эгшгийг эл дэвтрийн сүүлд
мөн хавсаргав.

Эл Намиад овгийн хун, дотроо бас Шар Намиад-
Шира Намиад, Хар Намиад - Кара Намиад хэмээн
ялгадаг нь сонин бөгөөд, сонин нь юундаа байна?гэ-

вэл, угсаатны зүйч, угсаатны судлалч хүнд содох үзэг
дэж, цаашид нь нарийвчлан монголын түүх болон, Мон-
гол оронд маяай эрнээс цаад үеэс шахуу үзэгдээд
одоо хүртэл угсаатны нэрнээ тийн хүү Хар Шар гэж
ялгадаг уламжлалын учир утгатай холбогдол бүхуйн
хувил сонин байгаа нь, жишээлбэл, Хөвсгөлийн монгол-
чууд дунд Хиргис овог байдаг нь, дотроо Хар Хиргис,
Шар Хиргис гэж байдаг байна. Тагнын цаанаас эрт-
ний Хиргис нөмрөн бууж ирсэний нь бид түүхийн үүд-
нээс мэднэ. Тэдний нэг хэсэг нь Хөвсгөл аймагт мян-
ган илүү жилийн дотор оршсоор, одоо монгол болсон
боловч, Хиргис гэдэг нэр нь овог болсоныг бид мэд-
нэ. Одоо Хиргисийг Зөвлөлт улсын Холбооны нэгэн
гишүүн улс гэдгийг бид мэднэм, бөгөөд орос хэлнээ
Киргиз гэдэг бол, өөрсдөө бие Кыргыз, монголчууд
Хиргис гэсээр ирсэн үүнд Зөвлөлтийн Хиргис улсын
дунд одоо хүртэл Кара Кыргыз, Сары Кыргыз гэж
Шар хар хэмээн ялгадаг ёс зуршил их л эртнийх
болох нь дамжиггүй. Хамниган дотор бас Хар Шар На-
миад гэж хар шараар ялгадаг нь мөн л эл дээр эрт-
ний уламжлал явсаар иржээ. Юу гэсэн утгатай уламж-
лал вэ? гэж мянган илүү жилийн турш түүх бид
хэлний болон бичгийн баримтаар хөөн үзэх нэгэн со-
нин сэдэв байгааг энд дурдан монголын хойчийн эр-
дэмт үеийхэнд захису.

Эл Намиад овог, монгол хамниган дотор Сэлэн-
гийн Ерөө, Төв аймгийн Мөнгөнморьт сум, Хэнтийн Да-
дал, Мөрөн, Дорнод аймгийн Цагаан-овоо, Баян-уул
зэргийн дөрвөөд аймгийн хэд хэдэн суманд тохиолд-
догсоор үзвэл, тархан дэлгэр хамниган овог байж, дээр
цагт нилээд хүч ихтэй овог байсныг гэрчлэж байнам.
Эл Нэфтэн буюу Нэлтэн овог, Дорнод аймагт буйн
сураг дэд эрдэмтэн Мишиг гаргасан боловч, тухам
аль суманд буйг хараахан эс тодруулжээ.

Онхонг

Дорнод аймгийн Дашбалбар, Баяндун сумнаа буй.

Өрлүүд

Эртний алдарт монгол овог Өрлүүдийн төлөөлөгчид нь бас хамниган цундаас гарч ирэн, Дорнодын Баян-уул сумнаа буй.

Пөөнгийн.

Сэлэнгэ аймгийн Ереөгөөр байгаа хамнигадын нэгэн хэсэг нь даруй энэ Пөөнгийн овогтон болно. Бас Төв аймгийн Мөнгөнморьт сумын хамнигадын нэгэн хэсэг нь Пөөнгийн овогтон.

Сартуул

Дорнод аймгийн Баян-уул, Цагаан-овоо, Хэнтэй Далаал буй. Хамниган цунд сартуул овог байгаа нь бас л гагнаас орж ирсэн болсохоос, уугал хамниган овог бус. Цээр цагт ямархан нэгэн хөл нуудлийн учир хамниган цунд орж, хамниган болсон ажээ. Зүүшнээ Баргад бас Сартуул гэдэг овог байдаг нь, Завхан аймгийн Сартуул, тэнцээс тасарч хойшоо гарсан, одооны Зөвлөлт-ийн Буриад нутгийн Сартуул, эл цөм нэгэн холбогдол явдлаас ингэж цацран түгсэн болно. Хамниган цундахи Сартуул овогтон дотор бас нийлбэр олон овог оролцдог нь эртний нэгэн бужигнаан хөлийн дуурнаг заан гэрчлэж байгаа бөгөөд хамниган Сартуул дотор:

Бамбадайн Сартуул, Дорнод Баян-уул;

Бамбачаан Сартуул, Дорнод Баян-уул;

Бааханид Сартуул, Дорнод Баян-уул;

Гуриг Сартуул, Дорнод Баян-уул, Цагаан-овоо;

Гуринка Сартуул, Хэнтэй Далаал;

Гачинха Сартуул, Дорнод Баян-уул;

Кэпцэнүүд Сартуул, Дорнод Цагаан-овоо;

Махан Сартуул, Хэнтэй Далаал; Завханы Сартуулд мөн бий.

Модоргон Сартуул, Хэнтэй Далаал;

Хатагийн Сартуул, Дорнод аймаг, Баян-уулад, Хэнтэй Далаал;

Шинжээг Сартуул, Дорнод аймаг Баян-уулад бий.

Уунд хамниган дотор Сартуул, Сартуул дотор нь мон-

голын түүх судрын баримтаар нэр нь тодорхой гардаг. Хатагин гэдэг монгол овог гардаг нь, түүхийн нэгэн цагт их л хутгалдаан гарсан явдлын гэрч үзэгдэн буй хэрэг. Угсаатны зүйн судлагаа өргөжөөд ирэхэд, судар түүх, соёлын түүхэнд сонин үзэгдэл баримт үлэмж гарах байнам. Үүнд одоо хамниган угсаатан огт байдаггүй Хөвсгөл аймгийн нутагт тэндэх монголчуудын дунд хамниган яс гэдэг байдгийн мэдээ бий. Тэр даруй Сэлэнгэ мөрөн, Дэлгэр мөрөн гэдэг нэртэй болсон газар хүртэл эрт оршиж байсан хамниган ясны үлдэгдэл болох нь, манай зуун аймгаар монголчууд дунд Зүрчид овог гэж эртний Зүрчдийн үлдэл байгаатай ажил зүйл болно.

Саардуул

Хэнтэй аймагт Дадал сум, Норовлин /Норболин/ сум, Дорнод аймагт Баян-уулац бий. Нэг хэсэг Саардуул нь биеэ Буянт Саардуул дотроо бас ялган хэлэлцдэг уламжлалтай.

Сонгоол

Дорнод аймаг Нагаан-овоод, Зарим нэг нь бас Чонгоол-лир хэмээмүү.

Сартуул

Хэнтэйд Дадал, Дорнодод Баян-уулнаа буй. С гийгуулэгч нь зарим хамниган аялгуунаа л болдогийн үзэгдэл.

Сартуул

Дорнод аймаг Нагаан-овоо сумнаа буй. Сартуул овгийн нэгэн зүйл авианзүйн хувилбар.

Нолоон

Дорнодын Нагаан-овоо сумнаа буй. Кирил үсэгт л үгүй тул, жинхэнэ овгоо хэрэглэх цагт төвөний шүргэх л авианг с гэдэг үүдэн шүд хавийн шүргэх авианы үсгээр орлол, солоон гэж бичих болох бизээ.

Тийвэргэ

Дорнод аймгийн Нагаан-овоо сумнаа буй.

Тоошил

Хэнтэйн Дадалд буй.

Тугчин

Дорнод аймгийн Дашбалбар, Баян-уул, Булган, Нагаан-овоо суманд буй. Эл овог бас хамниган байдаггүй Завхан Илжгэн, мөн Дорнод Халхын монголчууд дунд буй.

- Увачаан Баянтүмэнд буй. Ховорхон овгийн нэр хэмээмүү.
- Улаад Хөнтэй аймаг Дадалд, Дорнод аймаг Цагаан-овоод буй.
- Улиангай Хөнтэйи Дадалд буй.
- Улианхан Баянтүмэнд цөөн Улианхан буй.
- Унзал Дорнодын Дашбалбарт буй. Чухам дуудалгаараа шүргэх э биш, хамжин шүргэх хос гийгүүлэгч дж-ээр дуудах ажээ.
- Урианхан Дорнод аймгийн Цагаан-овоо сумнаа буй.
- Уринга Дорнодын Баян-уул суманд буй. 'ури^к' ха гэж дуудах ину буй, эхэндээ амисгалын түрилттэй. Гури^кна - Гу-рин^к ха гэдэг овгийн нэгэн хувилбар дуудалга буюу заа.
- Узөөн Хөнтэйи Дадал, Баян-адарга, Дорнодын Дашбалбар, Баян дун, Цагаан-овоо, Баян-уулад бий. Узөөн, Өзөөн, Уд-зөөн, Өдзөөн гэж эхний эгшгийг ү - ө -гөөр, э гий-гүүлэгчийг дан шүргэх э, хамжин шүргэх дз-ээр дуудах ану буй. Эд овгийн нэр, бас Барга, Халхад тохиолддог бөгөөд Эрээний үзөөн овогтон, биеэ Үзөөн Жалайр / Джалайр гэж хамжин шүргэх дж гийгүүлэгчээр дуудан/ нэрлэх ажээ. Жадайр гэдэг эртний монголоовог, Ар Өвөр Монгол, жич Дуицад Азийн зэрэг газар одоо гэрчлээстэй байгаа нь, монгол хамниган дунд бас тэр монгол овог кутгалдан оролцсон байжээ.
- Ухэрдээ Дорнод аймгийн Баяндун, Дашбалбар хоёр суманд дайралдсан.
- Халбид Дорнодын Баянтүмэн, Цагаан-овоод буй. Дэд эрдэмтэн Мишигийн сурвалжилгаар Дорнодын хамниган дунд Халбид буй гэсэн нь, даруй энэ овог болно. Бас Халбин - гууд хэмээх ину буй.
- Халзангууд Хөнтэй аймаг Дадал сум. Дэд эрдэмтэн Мишиг мөн эл овгийг Дадалд буйг анх тэмдэглэжээ.
- Хангид Хөнтэй аймаг Дадал суманд буй. Эл овог, уг нь хамниган бус, Өвөр Монголд Хангин гэдэг овог буй нь эртний Канглы гэдгийн өнцөг сунжирч, орчин үед Хангин болж ирсэн амуу. Байгалийн хойт биеийн буриад дунд

эл эртний Хангин - Кангин овгийн хүн буй бөгөөд өдгөө монгол хамниган дунд эл овгийн нэр гарч ирсэн ажээ.

Хатакин

Даруй Катакин гэдгийн авианзүйн нэгэн хувилбар. Хэнтэйд Дадалд, Дорнод аймагт Баян-уул, Дашбалбарт буй. Мөн Баяндунд эл овгийн хамниган буй.

Хөшүүр

Дорнод аймгийн Баян-уулад.

Хуланга

Дэд эрдэмтэн Мишиг, Хэнтэйн Дадал суманд эл овог буйг магадлан тэмдэглээд, Дорнод аймагт мөн овгийн хүн байдгийг дурджээ. Сүм хараахан заасангүй.

Хуурган

Дорнод аймаг Баян-уулад буй.

Хуучид

Хэнтэй аймгийн Дадал сумнаа буй. Уг нь эл овог бол, Өвөр монголын Хуучид, хамниган дунд оролцсон ажам.

Цахар

Дорнод Дашбалбарт буй бөгөөд мөн Өвөр монголын Цахар гэдэг аймаг монголчуудын нэр нь хамниган дунд овог болж орсон нь, Лигдан хааны цэрэг манжид царгдсан туухэн явдалтай холбогдолтой байж магад бөгөөд Хар хөлт Цахар, Цагаан хөлт Цахар гэж бас ялгадаг байсан мэдээ буй. Америкийн ниднан овогтондунд Хар хөлт Шошоон гэх зэргээр ялгадаг Хар хөлт гэдэг нэр сонин бөгөөд хэрхэн хамниган дунд чингэж овог дотор ялгадаг ёс гарсны учрыг бид хараахан нягтлан сураглаж олон магадлаж чадсангүй.

Цоохор

Дашбалбар сумнаа буй.

Цөмцөгэд

Дорнод аймгийн Баян-уулад буй хамниган овог.

Чипчинууд

Дорнод аймгийн Цагаан-овоо сумнаа буй. Хэнтэйн Дадал суманд мөн овгийн хамниган хүн, Шишшин хэмээн дуудамой. Ч гэдэг хамжин шүргэх тш гийгүүдэгч нь буриад аялгууны нөлөөгөөр дан шүргэх ш гийгүүдэгч болж ирсэн байна. Мөн Дорнод аймгийн Эрээнд Шишшин овогт хамниган буй.

Шарга азарга

Хэнтэй аймгийн Дадал сумнаа эл Шарга азарга овогтон буй. Дорнод аймагт Баян-уулад бас буй. Өтгөс нь овгоо бас Шаргадирга хэмээх дуудах агу тохнолдмой. Түүний азарга гэдэг нь эртний аджирга гэдгийн нэн эртний хэлбэр нь хамниган аялгуунаа манай үед хүртэл уламжигасан.

- Шимжээг Дорнод аймгийн Баян-уул сумнаа буй.
- Шимшигийг Дорнодын Эрээнд буй.
- Ширгадауул Хэнтэй аймаг Дадал сумнаа буй энэ овог, даруй Шарга адуул гэсэн хоёр уг нийлэн бүтсэн нэр. Монгол хэлний шинжлэлтэн хүнд сонирхолтой байж болно.
- Шуулэнкин Хэнтэй аймаг Дадал сумнаа буй. Дорнод аймгийн Баян-түмэнд ганц нэгэн эл овгийн хүмүүс байсан.
- Шээнкигир Хэнтэй Дадал суманд буй.
- Эрээгэн Мөн Хэнтэйн Дадал сумнаа буй. Эл овог, Барга цууд буйн мэдээ баримт биднээ буй.

Хамниган угсаатны хүн амын тоо асар олонгүй, сайндвал хошоод гурваад мянган хүнээс хэтрэхгүй атал, ийм цөөн угсаатан дотор дал гаруй овог байгаа нь, бидний сураглан магадлаж бүрэн гүйцэд тэмдэглэж амжаагүй овог бас энэ цэсэнд ороогүй хоцорсон байж болох бөгөөд эдгээр олон овог, зарим нь жинхэнэ хамниган, зарим нь эртний уугал монгол овог байгаа нь хамниган угсаатны бүрэлдэхүүнд хамниган бус, монгол угсаатан бас хутгалдан оролцсон өнгөрсөн түүхийн гэрч болно.

Хамниган өтгөсийн аман цомог тэмдэглэн цуглуулбал сонин зүйл байж болох үүнд цухас дурдвал, Тугчин, Гүнээкин овогт өтгөсийн үгээр болбаас, арван гурван наснаас жаран нас хүртэл дээр цагт цэрэг эрийн албатай байж, Чингисийн үед туг барих цэргийн хүмүүс, Тугчин хэмээн буслаасаа онцгой туг сахиу уурэгтэй байснаар овгийн нэр болж, хожим туг үгүй болсон чиг, Тугчин нэр нь үр саданд нь овог болж үлдсэн. Гүнээкин гэдэг бол, их цэргийн нуман жагсаалд гүнд нь явдаг байртайн учир Гүнээкин гэж нэртэй байснаар тэр нь даруй овог болж, одоо хүртэл үр садан нь биеэ Гүнээкин гэдэг өвгөд эцгэсийн домогтой гэдэг байнам.

Гуринка овогтон бол, агт мориныхаа гүрэний цус ханан сорж өл залгаснаар гуринка гэдэг нэртэй болж, тэдний үр угсаа нь гуринка овог болж ирсэн аман домогтой хэмээх ажээ.

Эдгээр аман домогт эрт дээр цагт болж байсан түүхэн явдлын цуурай цуурай нь тусгагдан уламжилж ирсэн байдал үзэгдэх бөгөөд зарим овгийн өтгөс өөрсдийн дээдсийг бусад нутгаас дайн хөлийн улмаас хүрч ирсэн дуртгалыг хадгалах ажээ.

Аман уламжлалд бас Таван хамниган, Найман хамниган, Арван таван хамниган гэх зэргээр хуваан хөлөлдөх ину буй бөгөөд чухам Таван хамниган, Арван таван хамниган гэдэг нь тоочвол юу болохыг мартаж, хуучид өтгөсийн чингэж хөлөлддэг үг бий асан гэдэг үг уламжлал байнам.


Туук судрын хүн, нуудэлчний судлалын хүнд эдгээр хамниганыг домог нь заллан шинжлэхэд сонирхолтой болох буй заа.

3.МОНГОЛ ХАМНИГАНЫ УТГА СОЁЛЫН УЧИР

Монгол хамниганы эдийн боловсролын дурсгал зүйлийг хараахан угсаатнызүйн үүднээс пуглуулж завдаагүй тул, манай улсын музей болон хамниган нутагладаг аймаг орны музейд эр энэ тухайн пуглуулга үгүй тул, өвгөд настан хүний дурдатгал яриа зэргээс хувцас хунар, сав-саа -лийн зүйлийг буууруулах тухайлахаас өөр юмгүй болжээ. Чингэвч, орос зэргийн хэлнээ угсаатны зүйч эрдэмтний тэмдэглэлийн дотроос тууж үзвэл, тойм төлөвийг мэдэж болох байнам.

Утга соёлын талаар судлан тэмдэглэсэн зүйл бараг байхгүй. Хуучин данс бичигт алба оноосон, отог амын хөрөнгө байдаасан буюу отгийн дарга тохоосон төдийхнөөс өөр юм гарахгүй. Судлагаа эхэлсэн цагт монгол хамниган, жинхэнэ уугал хамниган хөлөөрөө хөлөлдөх нь бараг цөөн тооны өндөр настны төдийхөн үлдэж, хойч үеийнхэн нь монгол хэл аялгуунаа орж, амаар хөлөлддэг зүйл нь, айл зэргэлдээ монголчуудтайгаа адил болжээ.

Монгол хамниганы эртний шүтлэгийн зүйл нь, бөө мөргөлтэй аж, түүний үлдэг нь уламжилж ирсэн ор мөр төдийтэй. Ан гөрөө хийхдээ уйлс урагштай болохын тухайд дагаж баримтладаг байсан хуучид өвгөдийн ёсны үлдэцийн нь сураглан судлавал, Сибирийн[†] хамниган зэргийн

[†] Сибир гэж нэрлэдэг орны эл нэр нь Сибери байсныг монгол хуудам бичиг гэрчлэн үзүүлж: , эртний түрэгүүдийн хааны цолонд нь Шибир хан гэж эл Сибери гэдэг нэрийн с гийгүүлэгчийн дараахи эгшгийн нөлөөгөөр тэр с нь ш болсон үзэгдлийг түрэгүүд хэлний гэрч үзүүлэн буйг 1987 онд Москвад гарсан Л.Н.Гумилевын Древние тюрки - эртний түрэг гэсэн номд түрэг хааны нэрнээ дурдсан байна. Орчин үеийн монгол хэлнээ шивир гэдэг нь эртнээс уламжлалтай бөгөөд, Сибир буюу Сибирь гэж орос хэлнээ эл эртний монгол нэрийн хоёрдугаар үед нь өргөлттэй дуудлаг орос дуудалгын зарчмыг даган дууддаг нэрийг Сибир гэж хоёрдугаар үед огт өргөлт буюу уртатгалгүйгээр дуудах, эсвэл одоо-

угсаатны дунд дээр цагт баавгай етгийг тайлдаг ёс мөн нэгэн адил байсны үлдэц нь баавгай агнаад, өвчин хөндөхийн өмнө хэрэглэж байсан ёс, эер зүйлийн анд явж байтал, санамсаргүй баавгайтай дайралдвал, ул халдахыг айлтган учирлах зэргийн ёс байснаас мэдэж болно.

Хамниган анчны дунд баавгай, буга зэргийн тураг ан агнахад цээрлэх зүйл, дагаж баримтлах ёс зэргийн зүйл байгаа нь, тэдгээр зүйл, хамниган түмний эртний утга соёлын уламжлал байгааг гэрчлэнэм бөгөөд, түүнтэй төстэй зүйл, дан ганц хамниганд ч бус, бусад олон улс угсаатанд байсныг угсаатны – зүй болов судлалын утга зохиолоос үзэж болно.⁺

Мөрөн сумын етгөс хамнигад, XIX зууны үеийн Сонин удган зэргийн хамниган сүрхий удган байсны дуртгалыг аман уламжлалаар хадгалжээ. Хөвчийн жожом гүнгийн хамниган дунд манай зууны эхээр нэртэй сүртэй бөө удган байсныг аман уламжлал, етгөс хамниганы үгэнд дурдан хэлэлцсээр буй нь, тэмдэглэж авбал, жожом хойно хэрэгтэй сонин аман зохиолын зүйл болох тул, үүнийг орон нутгаа судлагсад анзаарбал таарна. Зах нийлсэн Сибирийн /Шивирийн/ олон угсаатны энэ мэт аман уламжлал домгийг зөрлөлтийн аман зохиол, ардын билиггүй, угсаатны зүй судлагч эрдэмтэн болон сонирхогч идэвхтэн сэхээтний тэмдэглэнцүлүүлж байгаатай нь манай нутгийн етгөс дундаас тэмдэглэж авсан зүйлтэй хожим харшуулан судлахад олдошгүй сонин баримт болж, нэн дээр

гийн монгол хэлний дуудалгазүйн ёсоор Шивир гэж монгол хэлнийхээ зүй-тогтоолы нь баримтлан дуудах нь монгол үгээр өгүүлэгчдийн дуудалганы нийлэх учиртай байна. Англи, орос зэргийн хэлнээ тэдгээр хэлний өөр өөрийн дуудалгазүй байдагтай яг нэгэн адил, монгол хэлнээ монгол хэлний дуудалгазүй байгаа нь, амид түмний амид хэл тул, аргагүй хэрэг.

+ Энэ тухай гүрж түмний эртний заншлын уламжлал тухай Вирсаладзэ Елена гэдэг хүний Грузинский охотничий эпос – Гүржийн ангуучны тууль зүйл гэдэг өгүүлэлийг үзэж болно. Орос хэлээр бичсэн нь *Europe et Hungaria, Congresus ethnographicus in Hungaria, Akademiai Kiado Budapest, 1965.* гэдэг номын 345-354. талд үзэж болно. Будапешт хотноо 1965 онд Мажар академийн хэвлэл нийтлэжээ. Мөн өгүүлэлийн төгсгөлд тухайн сөцөвт холбогдох ном зохиол орос хэлээр буйг заан тодорхойлсоныг манай угсаатны зүйч хүн үзвэл сонин бөгөөд, тэр сэдвээс санаа авч, монгол нутагтаа сурвалжлаваас болох сэдэв бийг дурдалтай.


эртний үеэс олон угсаатан ястан эон олон, харилцан утга соёлын хэлхээтэй байсан ул мөрийг сэргээн судлаж, нээн шинжлэхэд маш эрхэм зүйл болно.

Монгол хамниган, олон зуун жилийн турш айл ээргэлдээ монгол-чууцтай түмэн харилцаатайн учир, хамниган бөөгийн шүтлэгийн зүйл нь эртний монгол-түрэгийн бөөгийн шүтлэгийн зүйлтэй бас маш холбогдолтой бөгөөд, монгол бөөгийн шүтлэгийн ёс заншил нь эргээд хамниганд нелөө тусгал учруулсан зүйл цөөнгүй үзэгдэж, улс түмний утга соёлын судлалтан эрдэмтэнд, угсаатны судлалын эрдэмтэнд сонин болохын дээр, зарим асуудал сэдвийг шийдвэрлэхэд учир утгы нь олох онис болж мэдэх зүйл бий.

Эртний монголчуудын харын шашин гэдэг бөөгийн ёсны олон үлдцээс, исгийгээр үнэг дүрслээд, нялх хуухдийн сахиул болгодог ёс буйг олон улсын эрдэмтэн, тэр тухай бага сага мэдээ нийтлэсэн зүйлээс мэдсэн боловч, уг гарал учры нь нягтлаж судласан зүйл хараахан үгүй билээ. Энэ тухайн бодлоо, монголчуудад гэрээ хийлээс бодовч, мал маллахыг гол болгосноор их удсан улс тул, эртний шүтлэгийн зүйл ан гэрээ гол болох үеийн уламж ёсоор хуухдаа сахиулыг үзвээр дүрсэлдэг байсан байж болох юм. Чингэхэд хожуу хойно мялтай болсон бөгөөд эртнээс нааш ой хөвчөөр ан гэрээ хийсээр ярсан хамниган угсаатан мөн хуухдийн сахиул нь үнэг байгааг угсаатны зүйл хүн сонирховол учиртай байж магадгүй. Үүнд Хэнтэй аймгийн Мөрөн сумын өдгөө хамнигад, хуухдийн сахиул гэж исгийгээр тее хиртэй үнэг хайдаг байгаа нь, монголчууд мөнтийн зүйл хэрэглэдэг байсан боловч, хамниганы тэр "үнэгэн сахиул" гэдгийн нэг өөрмилц нь, үнэг унасан хүний байдалтай хайчладаг бөгөөд хэлбэр байдал нь, эртний хад чулуунд цохилон хусаж буюу зосоор дүрслэсэн амитны сүт дүрсийн тэрх байдалтай маш төслүү нь сонирхолтойн дээр эртний уламжлалын заалт мөн. Энд тэр хамниганы "үнэгэн сахиулын" дүрсийг тоймловол ийм болно: /Зураг үз/

Хэнтэй Мөрөн сумын хамниган өдгөө Боролзойн Дугар агснаас энэ тухай асуун сургаланаас, чухам гарал учрыг үл мэднэ. Хуучдын үгнээ үнэг унасан тэр хүнийг Буувэй баатар гэдэг юм гэсэн билээ. Монголын аман домогт үлэмж гардаг Буувэй баатар гэдгийн тухай домог яриа, Хэнтэй, сөөгийн хамнигад ардын дууд, бас Хөвсгөл аймгийн цар-

хад дунд арвин буй тул, өргөн хэмжээний нутагт домог аман туухэнд орсон тэр баатар, нөлдөрөм их нэртэй, алдар их цолтой байсан учир, хамниган домогт орохоор барахгүй, баатар сайн эр тул, хуухдийн амь нас батлахад бас ач холбогдолтой гэж, үнэгэн сахиултай нэр холбосон ёс ч байж болно. Эрт дээр цагийн хамниганы уламжлалд үнэг унасан нэгэн баатар дүрсэж, нялхсын сахиул болгодог байсныг хожим Бүүвэй баатарын нэртэй холбох болсон ч байж болно. Угсаатны судлалын хэмжээгээр, бусад зүг нутгийн ястан угсаатны элчтэй төстэй зүйлийн судлагааг харшуулбал сонин байж болно.



Шарын шашин гэдэг Зунхааны шашин монгол газар дэлгэрэхэд, монгол хамниганы дунд бас тэр ном ёс нэгэн адил дэлгэрч, манай энэ зуун гарч ирэхэд, монгол хамниган бараг бүгдээрээ шахуу Зунхааны шашинтай болчихсон байна. Чингэвч, аман домог уламжлал, бөө удганы дуудалгыг үзвэл, тийн хүү Зунхааны шашинд орохдоо, хоёр шүтлэгийн нилээд их тэмцэл хийсэн байдал үзэгдэн, хамниган бөөгийн дуудалганд, мөн өтгөсгийн аман уламжлалд монгол хамниган лам нар, хамниган бөө удгантай сүрхий их тэмцэл хийсний дууриа нь тодорхой мэдэгдэж,

Доиндог гэлэн зууштай,
Долоон лам л хүнэстэй,
Балдан гавж л зууштай,
Балмад банди л хүнэстэй

гэх ээргийн дуудалгатай хамниган онгод буйгаас эл тэмцлийн байдал харагдах алам.

Дээхэн үеийн хамниган бөө удган нь хамниган хэлээр дуудалаа дуудаж, хожмоо онгодоо орж ирлээ гэж хамниганаар дуудахад нь суулцагсад хамниган хэлэндээ тааруухан болсон учраас онгодын хамниганаар хэлэх үгийг нь монгол үг болгон, наадуулдаа хэлж өгдөг тусгай хэлмэрч өвгөц эмгэд бий болж ирсэн нь, түрэг духалар хэлтэй дархад бөө удганы буухад, монгол үгээр хэлмэрчлэж өгдөг хэлмэрч Хөвсгөлд байсантай адил үзэгдэл болно.

Сая дээр иш татсан хамниган бөөгийн монгол үгтэй дуудалга бол,

монголоор дуудалга: тамалгаа дууддаг болсон хожуу цагийн хамниган бөөгийн дуудалгын нэгэн хэсэг бөгөөд Дондог галан, Балдан гавж гэж хамниган бөө удгантай тэмцэл хийж байсан тухай үеийн түүхэн хүний нэрийг дурдан заасан байна.

Эртний бөөгийн шүтлэгийн үлдэгдэл бас тэнгэр дуугарахад хамниганы Дагаанхан овогт хүн,

- Би Дагаанхан хүн энд байна гэж гэр дотроос өндөр дуугаар хангиран дууддаг байсан байна. Хамниган дунд Дагаанхан овогтон хүн байсан газар тэнгэр ниргэдэггүй гэж үздэг байсан учир, бороотой үеэр айлд буусан Дагаанхан овгийн хүнийг явуулах дургүй, бороо өнгөртөл хоноулах өнжүүлэх дуртай байсан гэж Дагаанхан овогтон байдаг нутгийн өвгөцүүд хэлэлцдэг байнам. Монголчууд дунд бас, хамниганы энэ ёстой ажил үзэгдэл байсныг угсаатны зүйн бичиг зохиолд тэмдэглэсэн зүйл буйн дээр бидний цуглуулсан материалаар үзвэл, тэнгэрийн дуунд ээл болдог хэд хэдэн овог буй. Хамниган дунд бидний олохоор Дагаанхан овог ийм байсан бөгөөд цаашид нь бас түрэг угсаатанд ийм үзэгдэл ёс байгааг судлахад эд хамниган-монголын эртний заншил бас сонин болох ажээ.

Сэцэн хан аймгийн хамниган Цэнхэрийн голын эхээр Даянт гэд. газар хамниган лам нар хурал хурдаг нэг дугантай байсан байна. Тэр дугангийн нэр нь Шадублин гэдэг нэртэй байжээ. Хорь гучин лам нартай. Бас нэг хэсэг лам нар нь Брайбун хийд буюу аман дуудалганд Бэрэвэн хийд гэж алдаршсан хүрээнд суудаг байжээ. Даянтын тэр хамниган хурал нь анх модон гэртэй байснаа сүүлдээ дөрвөлжин модон дугантай болсон нь, пөм хамниган дархдуулын бүтээсэн модон барилга байжээ. Сахиусанд нь хар гөрөөс /баавгай/ чоно хоёрын чихмэл байсан нь, тун чадамгай хийсэн чихмэл байсан гэж үзэгсэд хэлэлцдэг бөгөөд Боролзойн Дугар агсан өтгөсийн соноссоноор бол, хамниган отгийн Балбар дарга гэдэг хүн, галзуу чоно алаад, Даянтынхаа хуралд чихмэл болгож өргөсөн гэдэг. Тэр Балбар дарга гэдэг нь 1904 оны үес нас барсан хүн, даруй жар гаруй жилийн өмнөх хэрэг болно.

Хамниганы Даянтын тэр хурлыг Сэцэн ханы Бэр лам Балдан гэдэг гэгч байгуулсан гэж Дугар өтгөсийн ярьсан үгнээ буйг дээрхи хамниган бөөгийн дуудалганд гардаг Балдан гавж гэдэг байж болох нь ма-

гадгүй хэрэг.

Сэцэн ханы хүрээнд ханиад томуу өвчин гарсанд ханы хамнига - наас Даадий Хоной гэдэг тэргүүлэгчтэй хоёр өрх айлыг лам нар золигт гаргаж орхисон. Тэдний үр сад нь олширсоор тавиад өрх айл болсон гэж төрөл садан болдог одоо хүртэл мартаагүй хэлэлцэж байдаг гэж Борол-зойн Дугар гэдэг хамниган өтгөсний домог үг нь зарим нутгийн хамниган хун, Даадий Хоной гэдэг нэрийг Доной Хоной болгон сунжруулан хэлэлцэх болсон байна.

Золигт гарсан тэр хамниган айлын үр угсааны улс, цээр цагт хэл заншил өөртэй угсаатны хувид хавчигдаж, албаар золигт гарсан хуний удам гэдгээсээ ичиж зовох болж, хамниган гаралтайгаа нуух болсон нь, хэлээ мартахын нэгэн нөхцөл болсон байх учиртай юм гэж Дугар өтгөсний ярьсан нь ортой болно.

Монгол хамниганы их төлөв нь одоо хамниган хэлээ мартаж, гагц хуу яраас цээш насны цөөн хэдэн хүн, уугал хамниган хэлээ мэдэх төлий бөгөөд өдөр дутмын аж амьдралд хамниган үгээрээ хэлэлцэхгүй, гагц хуу бусад хуний дэргэд мэдэгдэхгүй гэсэн юмаа хэлэх төдийд хэрэглэх болсон хэдхэн өвгөд хөгшид бий тэднээр хамниган хэлний шувтрага нь дуусахад хүрч байгаа үүнд, 1983 оны шинжээний анги, түүнээс өмнө дөчин хэдэн оны үес цуглуулж тэмдэглэсэн хамниган үг ярианы зүйлийг энэ дэвтэрт жинхэнэ хамниган хэлний гэрч баримт болгон дараачийн зүйлд гаргалаа.

Монгол хамниганы нэг хэсэг нь бас, дундад эртний монгол хэлний нэгэн аялгуугаар хэлэлцдгээ орчин тойрны монголчуудаас тэр үг аялгуу нь өөр болох учир, "хамниган" хэл маань гэж боддог болсон ану буй. Монгол хэлний түүхэнд чухал болох тэр аман аялгуу нь хамниган хэлнээс монгол хэдэнд хэдийд орсон нь гэрчлэх бөгөөд тэр гухайн үеийн монгол аман хэл аялгууны сонин гэрч болох болно. Одоо тэр "хамниган" хэмээх дундад эртний монгол хэл аялгуугаар хэлэлцэгч өвгөд хөгшидийн үе нь мултарт, хойчийн үр хүүхэд нь орчин тойрныхоо монголчуудын одоогийн хэл аялгуунд орон гүйцэж, ялангуяа сургуулийн насанд хүрмэгц, улс нийтийн сургуулийн газар монгол багачуудын хамт лотуур байранд суун суралцах болж, цэргийн насанд тэнхжээсэд цэргийн албанаа монгол хэл бичигтэй болох зэргээр, нутаг жалгын аман аял-

гууны ялгамжаа нь жигдрэм тогтож байгаа нийт Монгол Ард Улсын олон ард нийгмээрээ хэлэлцдэг орчин үеийн монгол хэлэнд орж байгаа тул, ахмад үеийн өтгөс настны хэл аялгуу, хойч үеийн залуусын хэл аялгуу нь харилцан өвөрлөж, аман зохиолын зүйлд өтгөсний хэлэлцдэг үлгэр домог нь, жинхэнэ хамниган хэлээ мэддэг хүн ч гэсэн, түүнээ ярихдаа нийтээр хэлэлцдэг болсон монгол үгнээ оруулан хэлэлцэх болж байгаа хэрэг.

Нарийн ажиглавал, хамниганы эл утга соёлын нэгэн хэсэг нь болох элдэв үлгэр домог, дуу оньсого тэргүүтэн нь монголжиж, монгол утга соёлтой авалцан нийлж буйн дотор, зарим сэдэв байдал нь уг хамниган угсаатны байдал шинж мэдэгдэх зүйл бас буй ину, орон нутгийн хамниган зохиолын чанартай байнам.

Одоо монголын хамниган, нутаг усныхаа монгол ах дүүгийн нэгэн адил янз бүрийн дуу зохион дуулж байдаг боловч, хамниган хэлний үг оролцохгүй, тухайн нутгийн нэгэн монгол аман аялгууны үгээр зохиож, гагц хуу таталганд нь баахан өөр зүйл үзэгдэх төдий ахам.

Эл учир байдлыг байцаавал, жинхэнэ хамниган хэл нь монголын хамнигад дунд бараг одоо ч гэсэн, түүхийн хүртээл болж, тэр хэлээ мэдэвч, өдөр дутмынхаа аж төрөх элдэвт үл хэрэглэн, онцгой шаардал гарвал нэг хэдэн үг солих төдий өндөр настан цөөн хүнийг үл оролцуулбал, чихинд соностох хэлний үүрэг гүйцэтгэхээ бараг байж байгаа болно. Тиймийн тул, одоо байгаа үлдэц үгийн зүйлийг тэмдэглэж авах нь, шинжлэх ухааны үүднээс хамниган манжийн бусад ойр төрөл хэл аялгуутай нь харшуулан судлаж, өнгөрсөн түүхэн тухайн үед хамниган хэл ямар байсны нь шинжлэхэд хэрэгтэй тул, энд тэдгээр өтгөсөөс тэмдэглэсэн монгол хамниган хэлний үгсийн зүйлийг дараачийн бөлөгт гаргалаа.

4. МОНГОЛ ХАМНИГАНЫ ХАМНИГАН БУЮУ ЭВЕНКИ ХЭЛ

Монгол хамниганы дунд жинхэнэ хамниган хэлээ төсөөлдөг өтгөс настан хүн сайн бол тавнаас хэтрэхгүй. Залгаж сурах хойч үеийн хүн үгүй тул, жил ирэх тусам хамниган үгээ мэдэгчид цөөрч, төсөөлдөг өвгөд эмгэд дотроос өдөр дутам хэрэглэхгүй болсон хамниган хэлнийхээ үгийг мартагсад надад олон тохиолдож, ийм үгийг хамниганаар юу гэдэг

вэ? гэхэд, мартаж орхисон. Саваанд орж өхгүй байна. Тавиад жараад жилийн өмнө манай ав эжийн хэлэлцэж байхад, хамниганаар нэрлэдэг л юмсан гэгчид олон дайралдсан. Чингэвч, манай баруун аймаг Увсад Тарналан сумнаа буй хотонг бодвол, эх хэлээ дутуу хагад боловч мэдэсхийж, ойр зуурын юм ярьж орхидог хүн арай тасраагүй. Үүнд ажиглавал, хамниган хэлнээ бас нутгийн аялгуу байсан байдал үзэгдэн, зарим өвгөдийн хэлнээ с гийгуулэгчтэй уг нь өөр нэг өвгөдийн үгнээ төвөнгийн шүргэх h болдог үзэгдэл дайралдаж байсан. Чингэвч, харилцан бие биеэ мэдэлцээд байдаг байнам бөгөөд хамниган хэлээ мэдэгчид нь, эвэнки хэл гэж хамниган хэлээ нэрлэдэг нь, монголын дундад эртний хэлний байдал бүхүй аялгуугаар хэлэлцэгсдээс түүгээрээ ялгаж, жинхэнэ хамниган хэлээ эвэнки хэл гэдгээрээ монгол үгтэй "хамниган" гэж нэрлэдэг хэлээсээ салгаж нэрлэдэг байна.

Монгол хамниганы эл эвэнки хэмээх хамниган хэлний авназүйн тухай бичихэд, хэвлэлд хараахан нарийвчлан галиглах үсэг үгүйн учир, тэр байдлыг бодолцон, тоймлосон кирил үсгийн галиг хэрэглэхээс өөр аргагүй тул, ялангуяа эгшгийн зүйл дотор бүдүүвчлэсхийн тэмдэглэлээ.

Эгшгийн тоймыг энд дурдвал, байдал ийм буюу:

а эгшиг нь хамниган хэлнээ монгол хэлний а гэдэг эгшигтэй дүйнэ; тара гэж хамниганаар тэр гэдэг үгэнд ордог а болно. Урт а бас бий. Туунийг дээр нь тэмдэг талбин тэмдэглэв. Эл тэмдэг латин үсэг бүхүй чех мажар үсэгт урт эгшгийн тэмдэг бөгөөд зөвлөлтийн орос-гадаад, гадаад-орос хэлний толийн зэрэг зүйлд өргөлт заан тэмдэглэдэг нь, даруй монгол хэлнээ урт эгшигтэй дүйх учир, мука гэж гурил, мука гэж зовлон, замок гэж цоож, замок гэж шалтгээн хэмээн дуудалгаар утга илгаруулах байдал нь, даруй, муука, мукаа, замоок, замоок гэж бичсөнтэй адил бөгөөд гагц хүү нэг эгшгийг хоёр үсгээр тэмдэглэхгүйн ашиг буйн дээр, соёлт улсын бичигт өөр улсын үг үсгийг өөрийн хэрэглэдэг үсгээр буулган тэмдэглэх хэрэгцээ монгол бидэнд бусад улсын нэгэн адил тэмдэглэх хэрэгцээ гарахад, урт эгшгийг хоёр үсгээр тэмдэглэтэл, тэр хоёр үсэг нь тус тус дуудах эгшиг тохиолдоод, урт эгшиг болоогүй зүйл ч тохиолдож болох нь,

жишээлбэл, мажаар хэл бичигт манай кирилээр буулгавал виссаад гэж тэмдэглэх үгнээ виссаа гэж аа нь урт эгшиг биш виссаад гэж бүтсэн үг тул, аа гэдгийг урт эгшиг гэж болохгүй. Мөн виссаадит гэж а нь ерийн а, нөгөө нь урт а буй үүнээ ааа гэж бичихэд аата юм уу, атаа юм уу гэдгийг мэдэхийн аргагүй болно. Гэтэл, тэр урт а эгшгийг тэмдгээр ялгах зарчим хэрэглэвэл, даруй виссаад, виссаадлит гэхэд аль нь урт эгшиг, аль нь ерийн эгшиг болох нь дороо ялгаатай болох талаар, урт эгшгийг давхар үсгээр тэмдэглэдэг будуун аргаас нарийн ялгамжаатай болох учир, тэр илүү боловсон бөгөөд олон улс нийтэд тархсан аргы нь үүнээ хэрэглэлээ. Монгол кирил үсэгт ч хойшид эл нийтийн журам хэрэглэвэл, наад зах нь ном хэвлэлд үй түмэн илүү давхар үсэг бараг үг бүрид хэрэглэж, цаас илүү зарцуулах, өрөгч, хянагчийн илүү ажлыг хэмнэх зэргийн эдийн засгийн хувид хэмнэгдэлтэй боловсон арга болохыг бодоод үзэхэд тодорхой буй заа. Энэ тухай цухас дурдвал, манай улсын хэвлэлээс 1964 онд гаргасан ганцхан номын зүйлд, сонин сэтгүүлийг үл оролцуулан бодуулж үзэхэд, 122 хэвлэлийн хуудас аа, ээ, ий, оо, өө, уу, үү гэх зэргийн урт эгшгийн давхар үсэг хэвлэгдсэн бөгөөд мөн онд монголын зохиолчдын хорооноос бүх зохиолчдын тэр жилийн хэвлэлд өгсөн зохиол нь 120 хэвлэлийн хуудасны хэмжээтэй байсантай зүйрлэн үзэхэд, урт эгшгийг давхар үсгээр бичихийн эдийн засгийн хувид ашиг багатай тал нь үүгээр мэдэгдэж байгаа бөгөөд цаашид ч хэвлэл улам өсөх бүр, мөн адил хувиар өсөн нэмэгдэх нь мэдээж.

Хос эгшгийн эхний а нь жинхэнэ "цэвэр" а эгшгээс баахан ондоо байдалтай боловч, монгол хос эгшгийг ер жирийн бичигт ай хэмээн бичдэгдүгээ нэгэн дүйцэл болгож, буцуувчлэн мөн л а-гаар тэмдэглэн, айл аймаг гэж бичдэгийн нэгэн адил ай хэмээн тэмдэглэлээ. Чингэвч, хэлний шинжлэлийн хүн, ай биш гэдгийг юун андах аж. Монгол хэлнээ аа гэж тэмдэглэвэл тэр ай арай үнэн байдалд ойртох болой. Энд жишээлбэл, монголчуудын бөөгийн ёсноо Давай омгон гэж нэг

онгон байсны нэр нь, орос хэлнээ өгөөч гэдгийг давай хэмээн бичдэгтэй үсэг адил боловч, тэр Давай гэдэг монгол нэр, өгөөч гэдэг давай гэсэн орос үгийн адгийн -ай нь шал өмнөө байгааг энэ хоёр хэлний аялгуу баахан төсөөлөгч хэн ч гэсэн чихээр ялган таних бий. Хамниган хэлний эл -ай хэмээн будуувчлэн тэмдэглэж байгаа хос эгшиг бол, монгол хэлний -ай эгшгийн байдалд арай нлүү ойролцоо бөгөөд mid-front-wide ө-д ойртосхийвч, түүнээс арай агуу байдалтай эгшиг анам. Нарийн тэмдэглэхэд түүнээ нэгэн галиг үсэг оноон бичиж болохоор барахгүй, даруй ёстой боловч, боцоод бодоод - бодын шир дерев: хэвлэлд үсэг нь байхгүй тул, эх бичигт ямар ч нарийн үсэг хэрэглэсний хэрэг алга! Эл хамниган хос эгшгийн дэд нь чухамдаа -й гэдэг гийгүүлэгч бус, ө-п ойролцоо эгшиг тул, уртаар татаж болно. Тэр учраас -ай гэж тэмдэглэх нь болзлом юм болохоос биш, утаа арай эгшиг + гийгүүлэгч -й биш юм.

э эгшиг, монгол хэлний э эгшгээс баахан уруулшсан байдлаар соносголын хувид баахан ялгамжаатай. Уртыг дээр нь "удаан" гэж дээр дурдсан тэмдгээр үзүүлэв. Эмэгэл гэж монгол эмээл гэснийг хамниган хэлнээ дээд эртний хэлбэрээр нь дуудах ажээ.

ө гэдэг эгшиг, ерийн бөгөөд баахан уйтан урдүүрхи эгшиг. И эгшигтэй зарим байдлалд сэлгэх үзэгдэл бий.

6 урт эгшиг авиа. Баахан хойгуурхи тул, өмнө нь орсон гийгүүлэгч тагнайших байдалтай болдог байгаа нь бөга - бь-ёга гэх мэт. Эл уг, манж хэлнээ бичигт нь бийа гэж бичээд биа гэж дууддаг монголоор сар гэсэн уг даруй мөн.

и эгшиг, монгол хэлний и эгшигтэй ойролцоо. Бас урт и эгшиг буйг дээр нь удаан талбин, уртын байдлыг үзүүлэв.

о эгшиг, монгол хэлнээ буй о эгшигтэй төстэй. Урт хэлбэр нь баахан уудам. Уртыг мөн удаан гэдэг тэмдэг хэрэглэн тэмдэглэв.

ө үсгээр монгол хэлнээ буй ө-тэй нилээд төслуу эгшгийг тэмдэглэв. Урт хэлбэрийн дээр удаан гэдэг тэмдэг талбин

үзүүлэв. Монгол хэлнээ буй урт ө эгшигтэй ойролцуу. у гэдэг кирил үсгээр хамниган хэлний уруулшсан эгшгийг тэмдэглэв. Чингэхдээ, кирил үсгийн у үсгийг зөвлөлтийн эвенки зэргийн бүх хамниган аялгуутан : манай, эвенки, эвен зэргийн угсаатан, мөн орос, болгар зэргийн улсын бичиг үсэгт манай одоо у гэж тэмдэглэн буй үсгээр тэмдэглэдэг авнаг тэмдэглэдэг учир, тэр нийтийн кирил үсгийн зарчим ёс хэрэглэж, монгол хамниганы high-out back-wide-round эл эгшигт тухам хүү олон улсын зуршил ёсоор жинхэнэ кирил үсэгт оноон зохиосон үсгийг нь хэрэглэн тэмдэглэв: манай кирил үсэгт у үсгийг нь у-гээр содин тэмдэглэж байгаа тул, монгол үзэгч энэ тухайн учрыг мэдэж, нийтийн олон улсын кирил үсгийн дэлхий даяар хэрэглэдэг байдлаар нь тэмдэглэн хэрэглэснийг тэр ёсоор нь зөвөөр дуудан ухаармуу. Монгол хамниганы эвенки хэлнээ нэгэн зүйлийг үүнд тэмдэглэвээс зохиох нь, эл у эгшиг нь монголчуудын эр эм эгшиг бүхүй гэж ялгадаг үгнээ аль нэг нь ч оролцож, монгол хэлний ажил *аа аа* гэж байхгүй нь, монгол хэлнээс баахан түүгээрээ илгавартай үзэгдэх ажээ. Үүнд эл у эгшиг бол, баахан хойгуурх х гийгүүлэгчийн дараа орох үес, тэргийгүүлэгчийн бүтэх газрын байдалд эрхтний ажиллагаа татаглан, баахан хойшлуу болдог байнам. Чингэвч, монгол хэлний ажил у - у хэмээн эр эм эгшгийн ялгаа бүрдсэн зүйл үгүй бөгөөд эр эм эгшиг зохиох ёс нь монгол хэлний ажил нарийн үгүй, а э хоёр эгшгийн тухайд зохиолдох байдал үзэгдэхээс бнш, бусад зарим зүйнд эгшиг зохиох үзэгдэл ажиглагдахгүй мэт байдалтай.

Эл у эгшиг бас хос эгшиг бүтээлцэх ину буйг кирил үсэгт уй гэж хос эгшгийг тэмдэглэдэг заншлыг даган тэмдэглэв. Чухамлавал, хоёрдугаар эгшиг нь гийгүүлэгч -й бус бөгөөд бас үе бүтээгч тул, уртаар татахад хоёрдугаар эгшиг нь уй хэмээх хос эгшигт урт байдалтай болном.

Уруулшсан эгшгээс хамниган хэлнээ о эгшиг бас хос эгшиг бүтээхэд оролцон буйг мөн кирил үсэгт ой гэж тэм-

дэглэдэг зуршлаар ой хэмээн тэмдэглэв. Үүнээ мөн хоёду - гаар эгшиг нь -й гийгүүлэгч бус бөгөөд уртаар татан дуудахад хамниган хэлнээ монгол хэлний нэгэн адил хоёдугаар эгшиг нь урт болдог байнам. Эл хос эгшгийг ой, уй гэж бичдэг журам нь, уг кирил үсгийг зохицуулан анх зохиосон хэлнэл нь таарах бөгөөд журам болж ирсэн хэрэг. Монгол хэлнээ ой гэдэг үгийг уртаар татахад ооооой гэхгүй, даруй үе бүтээгч дэд эгшгийг нь оээээээ хэмээн уртаар татах ёсон буй ину даруй хамниган хэлнээ нэгэн адил буй. Слав хэлтэнд, жишээлбэл, орос хэлнээ ой гэдгийг уртаар татахад, үе бүтээгч тэргүүн эгшгийг нь оооой хэмээн татах тул, эл слав хэлнээ ой, уй гэж бичих нь зүйн хэрэг.

Бас цөөвтөрхөн тохиолдох боловч, уо гэсэн буюу эхэнд нь буй у нь арай огцомдуу учраас жижиг үсгээр тэтгэн Уо гэж тэмдэглэж болох нэгэн хос эгшиг тохиолдомой. Дэд эгшиг нь урт бөгөөд үе бүтээгч хувь нь болох тул, сэтгэлийн хөдөлгөөнийг нэвтрүүлэх үгнээ түүнийг ямагт уртаар дуудах ажам.

Монгол хамниган хэлний эгшгийн тойм товчоо нь энэ бөгөөд өдгөө гийгүүлэгчийн зүйлийг кирил үсгийн тухай тухайн гийгүүлэгчид дүйсэн үсгийг хэрэглэсэн тул, тусгайлан онцын тайлбар үл хэрэгсэх болно. Гагц хуу зарим нэг авиан тухай ганц нэгэн ажиглалт хавсаргах нь зүйтэй мэт санагдлаа.

Кирил үсгийн дэс дараагаар тэмдэглэвэл, монгол хамниганы хэлнээ буй гийгүүлэгчийн зүйл ийм буюу:

б, в, г, д, дж, дэ, /жэ, /к, л, м, н, нг, п, р, с, т, ф, х, h, ц, ч, ш болно.

Уунд в гийгүүлэгч бол, хоёр уруулын шүргэх гийгүүлэгч болно. Түүний дуугүй эсэргүүцэл авиа нь даруй ф болно. Түүнчлэн дуутай б гийгүүлэгчийн дуугүй эсэргүүцэл гийгүүлэгч нь даруй п болно. Заримдаа п - ф хоёр харилцан сэлгэх байдал үзэгдэм:

Файенкэн - Лейенкэн гэж нэгэн хамниган овгийг заримдаа Пэтэй, заримдаа Фэтэй дуудах ажам.


Хамниган хэлнээ хамжин шүргэх дж гийгуулэгч буйн зэр-
гээгээр зарим аман аялгуунаа бас дан шүргэх ж гийгуу-
лэгч ч тохиолдох үүнд, хамжин шүргэх, дан шүргэх хэмээн
эрс тас ялгаатай бөгөөд хэлний шинжлэлд бүтэц байдлаар нь
тусгайлан нэгий нь хамжин шүргэх /дж/ нөгөөгий нь дан
шүргэх /ж/ гэж ялгаж, сүүлчийнхий нь ж үсгээр тэмдэглэх
гэж кирил үсэг бий болоход түүнээ эл үсгийг оноосон бай-
тал, тэрийг ялгах хэмжээнд хүрээгүй шатны боловсролтой-
гоор хэлний шинжлэлд холбогдолтой бичиг зохиол хорьдугаар
зууны сүүлийн үеэ бичиж болохгүй нь мэдээж бөгөөд хамни-
ган аялгуунаа нэг заримд нь хамжин шүргэх дж байтал, за-
рим нэг аялгуунд нь нутаг зэргэлдээ бурнад аялгууны нө-
лөөгөөр хамжин шүргэх хос гийгуулэгчийн хамжих гийгуу -
лэгч нь үгүй болж, дан шүргэх нь үлдсэн ину буйг тэр хуу
байгаа байдлаар нь ялган салгаж үзүүлэх ёстой болно. Хэрэв
ялгахгүй, хамжин шүргэх нь ч ж, дан шүргэх нь ч ж гэж
тэмдэглэх юм бол, алин болохы нь үзэгч хүн мэдэх аргагүй
бөгөөд нарийвчлан үзэж, дүгнэлт хийхэд шал буруу гаргалга
хийхэд хүрүүлэх зүйл болно.


Монгол хамниганы хэлнээ бас хамжин шүргэх дэ гийгуу
лэгч бий. Тэр нь хамжин шүргэх дж гийгуулэгчийг дан шүр-
гэх гийгуулэгч ж болсон аман аялгуунаа мөн хамжих гийгуу
лэгч д хэсгээ гээж, э болсон ину буй.

Хамниган хэлний к гийгуулэгч нь монгол хэлнээ ойрад
монголын аялгуунаа эм үгнээ буй к гийгуулэгчтэй дуудалга
ойролцоо бөгөөд ялгаатай нь гэвэл, а,о бүхүй үгнээ мөн нэ-
гэн адил орж, кадум, кола, кайа гэх мэтийн үг нь монгол
хэлнээс орсон *эм, дэ, да, дэ* үг мэтэд оролцон буй.

Кирил үсэгт н тэмдгээр хэлний урдуурхи н гийгуулэг-
чийг тэмдэглэдэг учиртай тул, кирил үсгээр хамниганы бич-
гийн хэлний зөв бичих ёсонд хэлний урдуурхи н гийгуулэг-
чийг Зөвлөлт улсын хамниган угсаатан бүгдийн бичигт нэ-
гэн мөр журам болгон хэрэглэж, кирил үсгээр бичсэн шинж-
лэл судлалын зүйлд мөн тэр кирил үсгийн журмыг баримтла-

лаг тул, монгол хамниганы хэлнээ хэлний урдуурхи н гийгүүлэгчийг нийтийн ёсоор н хэмээн тэмдэглэлээ.

Монгол хамниганы хэлнээ хэлний хойгуурхи н гийгүү - лэгч буйг хэлний урдуурхи н-лүгээ хутган будлиж огт болох- гуй, биеэ даасан авиалбар царуй мөний тул, зөвлөлтийн олон хамниган хэлнээ эл хэлний хойгуурхи н гийгүүлэгчийг нг хэмээн хамниган нанайн зэрэг бичгийн хэлнээ хэрэглэдэг журам нь, хэлний шинжлэлийн эрдэмтэн хүн, монгол хамниганы аман аялгууны тухай сонирхон үзэх судлал шинжлэлийн бичигт тийм хоёр өөр бөгөөд биеэ даасан авиалбар тул, үгийн утга ялгаж өгдөг үүрэгтэйг будлин хутгаж үл болох учир, тааж унших бичиг биш, танин ялгаж судлах шинжлэлийн фүйл уунд хэлний хойгуурх н гийгүүлэгчийг латин үсэгтэг монгол хулам үсэгт мөн , кирил үсэгт нг гэж бичдэг олон улс нийтийн зуршил байдлыг хэвлэлд маань ч гэсэн үсэг нь олдох тул хэрэглэж, хэлний хойгуурхи эл гийгүүлэгчийг нг хэмээн тэмдэглэлээ: тунгма гм.

Зөвлөлтөд нганасан гэдэг угсаатан буйн нэр нь даруй энэ гийгүүлэгчээр эхэлсэн нэр, мэдэхгүй хүн нг гэж нэгэн гийгүүлэгчийн нийлбэр үсэг гэж мэдэхгүй нь нг гэж хоёр тус тус дуудах ану байх боловч, ёсоор нь бол хэлний хойгуурхи нэгэн гийгүүлэгчийг шинжлэлийн үүднээс н боловч, г гийгүүлэгчийг өгүүлэдэглүгээ байр нэгтэй хэмээн заасан заалт бөгөөд монгол хулам үсэг, мөн манж үсэгт эл учрыг тодорхой сайн мэддэг байсны гэрч нь  гэж олон улсын нэгэн адил арга хэрэглэн тэмдэглэсэн байдлаас илэрхий бөгөөд монгол хэлнээ эл хэлний хойгуурхи гийгүүлэгчийн суулд нь эгшиг орвол, өгүүлэхийн эрхтний байдлаар тэр гнь соностон өгүүлэгдэж, зайсанг - зайсангийн гэх мэт болдог учир, эл монгол үгийг орос бичгийн хэлнээ монголын тухай бичсэн эрдэмтний зохиолд зайсанг гэж бичээд орос хэлний тийн ялгалын зүйлд зайсанги, зайсангов, гэх зэргээр бичдэг журам буйг эдгээр шинжлэлийн бичгийг үзсэн хэн хүн юун андах ажээ.

Нанайн зэрэг хамниган угсаатны орчин үеийн кирил үсгийн бичгийн хэлнээ эл хэлний хойгуурхи нг гийгүүлэгчийг үгийн үнэмлэхүй эхэн болон үеийн адагт нг гэж бичдэг дүрэм тогтоосон нь, нанай хэлнээ гарыг даруй нгала, дансыг даруй дангса гэх зэргээр бичин буй бөгөөд монгол хамниганы хэлнээ эл гийгүүлэгч авив, үеийн эхэнд орж, дараа нь эгшиг орох байдал нь тэднээ төрөл болох Хар мөрний нанай хэлнийхтэй нэгэн адил, гарыг мөн нгала хэмээн нэрлэв. Ялгамжаатай болох нь, монгол хамниганы хэлнээ монгол үгийн зүйл орсон нь арай илүүтэй бөгөөд тэдгээр монгол үгнээ г гийгүүлэгч нь дараа нь орох эгшигтэйгээ г+ эгшиг хэмээн дуудах удаа бас байж болно. Учир иймэд нг гэж нэгэн гийгүүлэгч тул н+г хэмээн салгадаггүйг зааж эгшиг залгахын өмнө 'тэмдэг талбин нг'ала = гар, тунгма - тав хэмээн бичиж болох авч, нэг газар нг', нэг газар нг гэж бичсэвээс, зөвлөлтийн нанайн зэрэг хамниган хэлтний хэл аялгуунаа манай хамниганы хэлнээ буй эл хэлний хойгуурхтай яг ижил гийгүүлэгчийг тэдгээр төрөл хэл аялгууны бичгийн хэлэнд бичдэгтэй нь нэгэн мөр журам болгож дан нг хэмээн бичлээ. Үзэгсэд, түүнийг хэлний хойгуурхи н хэмээн хэлний шинжлэлийн учир утгыг мэдвээс, зөв дуудхыг юун андах ажээ.

Зарим хамниган аман аялгуунаа с гийгүүлэгчийн оронд төвөнгийн шүргэх h орох аву буй, Сибирийн хамниган аялгууны тийм гийгүүлэгч буй үзэгдэлтэй нийцэх бөгөөд к гийгүүлэгчийг к хэмээн өгүүлэх ину бас тохиолдоно.

Монгол хамниганы аман аялгуунаа зарим гийгүүлэгч тагнайших үзэгдэл буй үүнд тийм гийгүүлэгчийг тэмдэглэхдээ аль л болохоор хялбарчилж, тусгай тэмдэг хэрэглэлгүйгээр, кирил үсэгт буй тэмдгийг хэрэглэсү гэж тагнайшихын тэмдэг ь нэгэнт кирил үсэгт байгааг тийм газар хэрэглэлээ. Тэр тэмдгийг оросоор "мягкий знак" гэж нэрлэдэг нь чухамдаа даруй тагнайшихын тэмдэг гэсэн утгатай болно. Манай "үсгийн дүрэмд" түүний учир утгыг нягтлаж

ухаараагүй дээрээс огт тагнайшихгүй газар "хэлье" гэх зэргээр бичүүлж байгаа нь, "хэль" хэмээн тагнайшсан үзэгдэл монгол хэлнээ огт байхгүйг монгол хэлний тухай шинжлэн судласан бүх жинхэнэ эрдэмтний зохиолд илэрхий бөгөөд монгол хэлний авианзүйг танин мэдэх болох тусмаа тэр учрыг таних хүн манайханд ч мөдхөн бий болох буй заа. Орос хэлний бичиг зохиолд ойрноос бас ь тэмдгийг "разделительный знак" гэж орос хэл судлах гадаадын хүнд зориулсан ном дэвтэрт бичих болж, гадаадын хүнд зориулсан ярианы дэвтэр зэргийн наад зэргийн зүйлд хүртэл францаар *signe de séparation*, германаар *Trennungszeichen* гэж тайлбарлан нэрлэдэг болсон нь⁺ ларуй монголоор "салгах тэмдэг" гэсэн утгатай бөгөөд, хуучин нийт орос хэлнээ заншсан нэр нь "твердый знак" гэж байсныг манайхан⁺ хатуугийн тэмдэг гэж махчлаад, ер нийтдээ тэр тэмдэг бол, урдах үсгийг бичигт дараах үсгээс салган дууд, хойт үсэгтэй нь холбон залгаж дуудахгүй, салгаж дуудах учрыг заасан тэмдэг гэдгийг таниагүйн учраас "явъя" гэж бичих дүрэм гарсан нь, эртний монгол хэл, дундад үеийн монгол хэл, шинэ үеийн монгол хэлнээ чингэж яв гэдгээс нь я гэдгийг салган дуудаж байсан удаа үгүй, гагц хуу ь тэмдгийн учир утгыг олоогүйн байдал, ь гэдэг тэмдгийг въехал, въезд, подъезд гэх зэргээр орчин үеийн оросын бичгийн хэлнээ эв бичихдээ хэрэглэдэг учры нь мэдэх хүн бүхэнд илэрхий биз ээ. Энэ хуу ь хэмээх салган дуудах байдлыг заасан салгах тэмдгийг зарим газар тэр хуу жинхэнэ утгаар нь хэрэглэж, нгала - нгъала гэх мэтэд хэлний хойгуурхи н гийгүүлэгчийн г тэмдэг үсгийг дараачийн гийгүүлэгчтэй га гэх зэргээр залган дуудахгүй, салган дууд гэсэн газар хэрэглэв. Ь - ь тэмдгийн үнэн учир утгы нь танин мэдэх

+ Краткий разговорник на шести языках. Издательство Прогресс. Москва.

явдал, манай одооны кирил үсгийн зөв бичих зүй зарчмы нь боловсоруулах явдалд ч хөтдөө хэрэгтэй тул, хэлний шинжлэлийн анхны мэдэгдэхүүнтэй болж эхлэж байгаа хүнээс үүсгэн эл тэмдгийн учрыг мэдэх нь хэрэгтэй болж байгаа шуу!

Монгол хамниган хэл аялгууны эгшиг гийгүүлэгчийн тойм будуувч нь дээр өгүүлсэн байдалтай бөгөөд монгол хэлнээс хамниган хэлэнд орсон үгийн зүйлд а эгшиг эхний үед нь буй үгнээ дараачийн үеийн у эгшиг тун чиг тодхон сооногж буй: самур, намур, кадум, нагачу - нагачу гм. Мөн эхний үед э эгшиг бүхүй үгнээ дараачийн үеийн у эгшиг тун тод өгүүлэх нь : нөкүн - мо *нө* кирилээр түүнийг галиглавал даруй нөкүн - нөкюн.

Ингэж өгүүлэгч хамниган өггөс өрөөс монгол худам бичиг үсэг үл мэдэхийн дээр, манай эцэг өвөг, элэнцэгийн аман аялгуунд яг л ийм байсан. Нутаг усны монгол ах дүүнэр, манай ингэж хэлэлцдгийг танай хамниган аялгуунд л ийм байцаг гэж хэлэлцдэг. Монголоор самар, хамниганаар самур гэдэг юм гэж бид боддог. Монголоор эмээл, хамниганаар эмэгээл, монголоор азарга, хамниганаар адирга, аджирга-гэдэг нь ойролцоо боловч ялгаатай мэт хэмээн өгүүлэлдэх ажээ.

Үүгээр үзвээс, хамниган хэлнээ эмэгээл, адирга гэх мэт үг нь монгол бичгээс хамниган аман хэл аялгуунд орсон ану огт бус, дээр эрт цагт хамнигас монгол хэлэнд орж эхлэх үеийн монгол хэлний эртний дуудалга нь даруй мөн болно. Энэ талаар хамниган хэлний орчин үеийн гэрч баримт нь, монгол худам үсгээр *нүн* гэж бичдэг маань, нэн дээр цагт, монгол хэлний цөөл эртний үед чингэж өгүүлдэг байсныг монгол худам үсгийн бичих журам нь гэрчлэн үлдээж, аман хэл аялгуунд аванзүйн еөрчлөл гарсаар эгшиг +т+ эгшиг нь урт эгшиг болж ирсэн аваас, эгшиг + г + эгшиг бүхүйг урт эгшиг болоогүй тэр хэвээр нь дуудаж байсан цагт хамниган хэлнээ тэлгээр монгол үг орж, одоо хуртэл уугал эртнийхээ хэлбэрийг хамниган хэл аялгуунаа хадгалсаар ирсэнзүйл болж байнам. Үүнд пурдах нь, хамниган угсаатан, Монгол Ард Улс, Зөвлөлт Холбоот Улс, Дундад Ард Улсын нутагт тархан оршиж буй үүнээ Зөвлөлт Холбоот Улсын умарт хязгаар Туруханскийн хавиар, одооны манай монгол хамнигантай лавдуу манж Дайчин улсын үеэс харилцаагүй нь ил боловч, эртнээс нааш ой хөвч зэргийн газар ан гөрөө хийж хөрмөл

аячин угсааны байдалтай байсан хамнигадуудын хэлнээ эрт дээр цагт таван хошуу малтай, тал хээр газар нуун оршиж, хэрмэл гөрөөчний байдлаас хэдийн ангижирсан улс асан монголчуудын хэлнээс нүүдэлчний соёлын нэр томьёо орсон нь, монгол хэлний дээд их эртний байдлыг хадгалсаар ирж, эмгэгэл, морин, тэмэгээн, адирга - аджирга, үрке гэж гөрөхийн өрхө гэх мэт уг өр хамниган аймаг оршин буй нутаг даяар түгж, алс умар зүг, якуд нутаг, Турухан хязгаар, урагшилбал Хар мөрөн Хянганаар нутагтай хамниганд нэгэн адил түгэн дэлгэрсэн байнам. Ийм өргөн нутаг дэвсгэрт түгсэн хамниган аялгуунаа эртний монгол уг байгаа нь, монгол хэлний түүхнээ маш сонирхолтой болно.

Монгол хамниганы аман аялгуунд эвенки хамниган хэлээс гадна, дундад эртний үеийн монгол хэл аялгууны байдал манай үе хүртэл уламжлан ирсэнийг монгол хэлний түүх судлагсад сонирхон үзэх нь аргагүй бөгөөд энэ дэвтэрт тэмдэглэн оруулсан уг тэмдэглэлийг хэлж өгсөн өтгөсийн нэгэн хэсэг нь нас элэгдэж, хэвлэлээс гартал нь бас нэг хэсэг нь үе мултрах тул, хэдүй бүрэн бус боловч, эл тэмдэглэл, хэлний түүхчин хүнд хэрэгтэй болом заа.

В.ХАМНИГАН ЭВЕНКИ ХЭЛНИЙ УТСИЙН ЗҮЙЛ

Монгол хамниганы жинхэнэ хамниган үгээрээ хэлэлцдэг уг ярианы зүйлээс нэгэн хэдэн уг, бага сага ярианы зүйлийг тэмдэглэж авсанаа энд жагсаан үзүүлээ. Дэвтрийн суулц эл бүх үгний бүгд хэлхээг цагаан толгойн дэс дараад оруулж, монгол дүйцэл үгийн хамт хавсаргав.

а. Тооны уг:

- 1 - эмун - эмун, үүнээ манжийн эму гэдэгтэй тун ойр.
- 2 - джур, манжийн джуэ гэдэгтэй джу - язгуур нэгтэй.
- 3 - илан, манжаар мөн даруй, илан амуу.
- 4 - цегин, манжаар пуйни гэдэглүгээ харшуулмуу.
- 5 - тунгма, манжаар сунджа гэдэгт т - с гийгүүлэгч сэлгэдэг зүй бүхүй үүнээ тунг- сун- нэгэн язгуур сурвалж үзэгдэх ахам.
- 6 - нунгун /нунгун/, манжийн нингун гэдэгтэй харшуулмуу.
- 7 - напан, манжаар мөн надан.
- 8 - джапкун, манжаар джакун.

- 9 - йегин, манжаар уйун. Үүнд й - г хоёр гийгуулэгч монгол хамниган хэлнээ сэлгэдэг зүйтогтоол бүхүй монгол хамниган манж хоёрын хэлнээ гарал төрөл нэг үг язгуур үлэмж буй нь наад зах нь энэ хэцэн тооны үгнээс илэт үзэгдэм.
- 10 - джа́н, манжаар джуан /джуван/.
- 11 - джа́н эмун /джан эмун/. Манжаар джуан эму.
- 12 - джа́н джу́р. Манжаар джуан джуэ.
- 13 - джа́н илан. Манжаар джуан илан.
- 14 - джа́н дэгин. Манжаар джуан дуйин.
- 15 - джа́н тунгма. Манжаар тофохон. Энэ тухайд манж нар шинэ үг зохиожээ. Түүний учрыг европын манжич эрдэмтэн тайлбарласан зүйл бий.
- 20 - ори́н. Манжаар мен ори́н.
- 21 - ори́н эмун.
- 30 - гутин. Манжаар гусин.
- 32 - гутин джу́р.
- 40 - дэ́гиннье. Манжаар дэхи.
- 43 - дэ́гиннье влан.
- 80 - тунгма́нье. Манжаар сусай болно.
- 54 - тунгма́нье дэгин.
- 60 - нунгуннье́ /нунгуннье́/, Манжаар вшиджу.
- 68 - нунгуннье́ тунгма.
- 70 - на́даннье. Манжаар наданджу.
- 76 - на́даннье нунгун.
- 80 - джа́пкуннье. Манжаар джакунджу.
- 87 - джа́пкуннье на́дан.
- 90 - йегиннье. Манжаар уйунджу.
- 100 - нама́джи. Манжаар тангу.
- 101 - нама́джи эмун.

+ Энэ ө үсгийг манайхны йэ гэж ухаардаг боловч, театр, метр, депутат, редактор, чехословак гэх мэтийгээ тйэатр, мйэтр, дйэпутат, рйэдактор, чйэхословак гэж дууддаггүйн жишээгээс чухамдаа йэ бус бөгөөд орос хэлний петрушка, петух гэх зэргийг бас пйэтрушка, пйэтух, гэдэггүйг бодолтой.

- 200 - джур намаджи. Манжаар джуэ тангу /бичигтээ джуэ тангу/
- 202 - джур намаджи джур.
- 300 - илан намаджи. Манжаар илан тангу.
- 303 - илан намаджи илан.
- 400 - дегин намаджи. Манжаар дуйин тангу.
- 404 - дегин намаджи дегин.
- 500 - тунгма намаджи, тунгман намаджи. Манжаар сунджа тангу.
- 506 - тунгман намаджи тунгма.
- 600 - нунгун намаджи. Манжаар нингун тангу.
- 606 - нунгун намаджи нунгун.
- 700 - надан намаджи. Манжаар надан тангу.
- 707 - надан намаджи надан.
- 800 - джапкун намаджи. Манжаар джапкун тангу.
- 808 - джапкун намаджи джапкун.
- 900 - йегин намаджи. Манжаар уйун тангу.

1000 - мингга, мингган. Манжаар мөн минган гэж монгол хэлнээс хамниган манжид оржээ. Язгуур нь даруй мин /минг/ бөгөөд бүх түрэг хэлтэнд мянгыг мин /минг/ хэмээх тул, алтайн хэлнээ нийт дундын тооны уг ахам.

10.000 - джан мингга. Манжаар түмөн гэж монгол тооны нэр авсан байнам. Хамниганд ер жирийн хэрэгцээнд нь мянга гэдэг тоо нь даруй тооны мухарт тулсан их тоо тул, монголтой адил арван арванаар дэвшүүлэн мянга, түм, бум, сая гэх зэргээр нэрлэх тогтолцоо үгүйн учир европ хэлнийхтэй адил арван мянга, зуун мянга гэж хэрэв нэрлэх хэрэгцээ гарвал аргалдаг байна. Манай орчуулагч нарын хэлэнд мөн түүнтэй адил, түмийг арван мянга гэдэг нь архивын бичиг баримт хөөвөл саяхнаас десять тысяч гэдгийг махцлан орчуулж байгаа хэрэг. Монгол тооны арваар ахиулан жаран оронтой тоо буйг О.Намнандоржийн бичсэн "Гайхамшигт тоо"

гэдэг товхимлоос үзэн сонирхож, монгол хэлэнд тооны нэр даруй жаран орон бүхүй тоог тэмдэглэдэг тогтолцоотойг мэдэж болно.

Эмунду гэж нэгэнд, нэгд; джурцу гэж хоёрт; иланду гэж гурванд, гурвад; дегинду гэж дөрвөнд, дөрвөд; тунгмаду гэж таванд, тавд;

Эмүндэки гэж нэгдүгээр, нэгдэх гэсэн утгатай тооны уг болдог нь, -дэ+ки гэж монгол дагавар хэрэглэн, джурдэки гэж хоёрдугаар, илан-даки гэж гутгаар, гуравдугаар, дэгиндэки гэж дөтгөөр, дөрөвдүгээр гэх мэт бөгөөд нунгундэки бсгин оринду гэж зургадугаар сарын хоринд гэсэн уг болно.

Б.Хун,хун бусын зүйл:

баргу - барга монгол, Барга нутаг.


баргусал - баргацуул.

бунггекэ - четгөр. Буңггекел - четгөд, бунггекесел - четгөрүүд.

гурун - улс, гүрэн.

евенгки - хамниган. Евенгкисел - хамнигад.

идакон - удган гэсэн уг.

хятад - нангиад хятад гэсэн уг. Мо  кирилээр галиглавал хятад гэсэнтэй дүйнэ. Зарим өтгөс бас никан, никасал гэдэг хэмээдэг нь даруй манжийн никан гэж нангиадыг нэрлэдэг уг ажээ.

лама - монгол хэлнээс орсон төвд лама буюу түүнийг монголчловол "дээд эх" - бла-ма гэж төвдөөр бичдэг уг. Эх гэсэн ма гэдэг угийн эгшгийг хасаж лам гэж "үсгийн дүрэмд" бичдэг нь, эгшгээр төгссөн нэрийг гийгуулэгчээр төгссөн уг болгож, эхийн "ма" гэдгийг ганц "м" болгож, утгагүй болгочих - сон хэлбэр. Зарим өвгөцүүл бас "фугдурн" гэж нэрлэдэг асан хэмээмуу.

луота - орос гэсэн уг. Луочасан гэж оросууд хэмээсэн хэлбэр.


монггол, зарим өтгөс бас монгго гэдэг асан хэмээмуу. Монгол гэсэн уг. Монгголсал, монгосал гэдэг хэлбэр даруй монголчууд, монголууд гэсэн болно.

саман - бөө гэсэн уг. Самасал - бөөчүүл гэсэн хэлбэр.

атиркан саман - идакон гэдгийг бас ингэж нэрлэдэг нь эм бөө гэсэн болно.

самандаку - бөөлөх гэсэн уг.

себеки - онгон гэсэн уг.

читкур - мо  кирилээр галиглавал чидкур гэсэн угийн хэлбэр хамниган хэлнээ буй бөгөөд бас читкул гэдэг нь даруй

мо *мо* буюу.
енпүри - богд, сахнуу.

В. Хуний шийн зүйл:

амён, амьён, ама - ав, эцэг. Манжаар ама, Кастрены тэмдэглэсэн зүйлд ама, ама.

өнён, онё - эх гэсэн нэр. Манжаар өнийе гэж бичдэг энё гэж дууддаг-
тай хамниган өл нэр дүйж байгаа хэрэг.

акён, ака - мо *кирилээр* галиглавал ак-а, үсгийн дүрмээр одоо
адгийн эгшгийг хасаж, гийгүүлэгчээр төгссөн нэрийн
айд шилжүүлэн "ах" гэж бичдэг маань. Кастрены тэм-
дэглэлд ака, акин гэж тэмдэглэжээ.

экин - эгч; манжаар ейун, Кастрены хамниган аялгуунд еке гэжээ.

некун, некун - дуу, охин дуу гэсэн үг. Мо. *кирилээр* галиглавал
некун гэж боол, шивэгчин гэсэн үгтэй дүйнэм бөгөөд
манжаар неху гэж шивэгчин гэсэн үг, неку гэвэл найз
гэсэнтэй харшуулж үзвэл, монгол хэлнээ *си* *кирилээр*
галиглавал неку некун гэсэн үгний түүхтэй
согийн холбогдол тодрон үзэгдэж, манж-хамниган-мон-
гол хэл-түүхийн харилцааны үүднээс шинжиж үзвэл со-
нин түүхтэй үг болно.

атилкан - эмгэн; Кастрены тэмдэглэлд атиркан.

етилкен - өвгөн; Кастраны тэмдэглэлд етиркен.

сагди - хөгшин, өвгөн, өндөр настай; сагди етилкен - хөгшин өвгөн,
етгес. Хамниганы сагди - манж сагда.

ачи - мо. *зарим* хамниган аялгуунаа бас ати гэдэг нь эртний мон-
гол хэлний хэлбэр хадгалсан ажам.

нагачу - мо *кирилээр* галиглавал нагачу, одооны нагаца, кярил
үсгийн дүрэмд адгийн эгшгийг хасаж, эгшгээр төгссөн
нэрийг гийгүүлэгчээр төгссөн нэрийн зүйлд "оруулжээ".

джиге, джье, дьиге, джье, дье - мо *кирилээр* галиглавал джиге,
одоо манай ээ гэдэг (Зээ гэдгийн э нь чухамдаа хам-
жин шүргэх дэ шүү дээ!)

куда - мо *кирилээр* галиглан буулгавал куда, одоо худа, "үсгийн
дүрмээр адгийн эгшгийг хасаж, гийгүүлэгчээр төгссөн

нэрийн айд "оруулжээ".

кудагуй - мо *қудай* кирилээр галиглаж, эртний монгол дуудалгыг үзүүлбэл, даруй кудагуй, одооны аман аялгуунд худа - гуй, худугуй, одооны үсгийн дүрмээр худгуй.

кунга - хүүхэд.

кунга^л, кунгасал - олон хүүхэд.

кукьен - бэр гэсэн үг.

Кукин - мөн бэр гэж монгол хамниганы зарим аман аялгуунд буй инуде- руй Кастрены тэмдэглэсэн хамниган аялгууна кукин гэсэнтэй явцав нийлэлцэн буй.

кадум - даруй мо *қадум* кирилээр галиглавал кадум, латин галигаар тэмдэглэвэл qadum гэсэн монгол үгний эртний хэл- бэр хамниганд хадгалагджээ. Орчин үед хадам хэмээн бид дууддаг үг.

кадум ен^бен - даруй хадам эх мөн. Зарим монгол хамниган аялгуунаа кадум ен^бе хэмээж, эхийг ен^бе хэмээмүү. Тэр нь ман- жаар эхийг ен^бе /бичигт енийе/ гэдэгтэй дүйнэ.

кадум амь^бен - хадам эцэг. Зарим монгол хамниганы аман аялгуунаа кадум ама хэмээж, эцгийг ама гэдэг нь Кастрены тэм- дэглэл, мөн манж хэлнээ эцгийг ама гэдэгтэй дүйнэ.

омолги - хуу, хөвүүн.

h уна^джи - охин гэсэн үг.

h уна^д - зарим монгол хамниганы аман аялгуунаа h уна^джи гэдэг үгийг hуна^д гэдэг нь, Кастрены тэмдэглэсэн хамниган аял- гууныхтай нийлэх ажээ.

сагди - хөгшин. Манжийн сагда гэдэгтэй дүйнэ.

сагди эн^бен - хөгшин эх, хөгшин нжий, эмээ гэсэн үг.

сагди ен^бе - мөн зарим аман аялгуунаа хөгшин эхийгээ ингэж нэрлэдэг байна.

сагди амь^бен - хөгшин ав хэмээн өвгийг дуудах эс бас бий.

сагди ама - мөн сагди амь^бен гэдгийг ингэж дуудах аман аялгуу мон- гол хамниганд байгаа нь манж хэлбэрт нилээд ойр.

кунга^кар /кунг^акар/ - багацуул, хүүхэд.

кунгасал /кунг^асал/ - олон багацуул.

абага - монгол *ᠠᠪᠠᠭᠠ*, орчин үед авга гэдэг монгол үг.

нагачу - монгол бичигт *ᠨᠠᠭᠠᠴᠤ* кирилээр буулгавал даруй нагачу, ордос аман аялгуунаа нагачи, манай энэ зүг нагача, адгийн огцом эгшгий нь "үсгийн дүрэмд" хасан, гийгуулэгчээр төгсгөсөн нэр "болгодогт" нагац.

нагачу абага - нагац авга. Мо *ᠨᠠᠭᠠᠴᠤ ᠠᠪᠠᠭᠠ* нагачу абаг-а.

г. Биений заах нэр:

минье бейе - би, миний бие гэсэг үг. Кастрен би гэж тэмдэглэсэн байна.

Монгол хамниганы зарим аман аялгуунаа мөн би гэдэг ч бий.

ши - чи гэсэн хоёдугаар биенийг заах нэр. Манж бичигт ся гэж бичээд, ши хэмээн лууддаг аму.

шинье - чиний.

шинье бейе - чи, чиний бие гэсэн үг.

ере - энэ гэсэн үг. Манжаар мөн ере гэдэг бөгөөд хамниган-манж-монгол хэлнээ эл заах үгийн язгуур нь даруй е- /э-/

ене бейе - ойрхи хүнийг энэ хүн хэмээн заах үг.

тара - монголоор тэр гэсэн үг.

тара бейе - тэр хүн гэж энэ хүн гэснээс арай холшиг байгааг заах үг.

таранье - тэрний, түүний гэсэн үг. Эр эм эгшиг, монгол хэлний адил яг зохицдоггүйн жишээ үүнээ ил үзэгдэм.

бу - монголоор бид гэсэн үг. Бу джур - бид хоёр, бу илан - бид гурав, бу дегин гэж бид дөрөв гэх зэргээр хэрэглэнэ.

су - та, та нар гэсэн үг. Манжаар даруй сүе гэсэнтэй дүйнэ.

эрил - эд, эдгээр.

тарил - тэд, тэдгээр.

бейе - хүн.

ни - хэн.

негги бейе - негги бейел олон хүн.

тара негги бейел - тэр олон хүн.

хури - хүүхэд.

хурил, хурисил хүүхдүүд.

д. Биений эрхтэн:

амига /амигъя/ - ам.

ангкан - суга.

анцан - хацар.

беггил - хоёр хөл. Өмүн-беггил - Нэг хөл, өрөөсөн хөл.

бексе - бөгс.

горгакта - сахал. Кастрен гургакта гэж тэмдэглэсэн байна.

гъеле - үс.

далу - дал. Монгол хамниганы хэлнээ үүний нэр нь мо гэдгийн эртний
дуудалгыг давхар гэрчлэн амуу.



цели - толгой.

цзеги - эруу.

укта - шуд. Миддендорфын тэмдэглэлд икта, Герштфелдийн тэмдэглэсэнд
укта хэмээжээ. Монгол хамниганы хэлнээ эхний эгшигт
уртатгалтай ажээ.

инье - хэл. Миддендорф инни гэж, Кастрен инги /ингьи/ гэжээ.

йеса - нуд. Майжаар йаса, Кастрен йса, эса гэжээ.

кимусу - хумс. Монгол хамниганы хэлбэр нь  гэдэгтэй нэг бөгөөд бас кимусун гэдэг ину буй, царуй  гэсэн
үгний эртний дуудалга нь монгол хамниганы хэлнээ манай үе хүртэл уламжилжээ.

кемеке - хоолой.

мотохо - эмийн нууц.

нала - гар. Бас нгала хэмээмүү.


некъён - хүзүү.

нурикте - толгойн үс.


онгокто /онгъокто/- хамар.

согдондо - нуруу.

һенгнен - өвдөг. Кастрены тэмдэглэсэн хамниган аялгуунаа согдондо,
согдонда.


толугай - мо  кирилээр галиглавал толугай гэсэнтэй дүйнэ, толгой.

унакан - хуруу.

хургуон - хуруу. Мо  галиглавал хуругун гэдэг үг хамниган
хэлнээ эрт цагт оржээ.

хөмөн, хэмэн - һөмөн - манж фөмөн, монголоор уруул гэсэн үг.


шен - чих, манжаар шен.

пами - чами - мо  - чаби гэсний б нь м болсон хэлбэр - цавь.

цэджи - цөджи - цээж.

е.Хувцас хунарын зүйл:

лбен - малгай.

дэкэл - ууж. Уг нь мо  дегел гэсэн нь хамниганд дэкэл болсон ажээ.

коколда,хоколда,кокалда - бээлэй.

оймусу - оймс. Зарим аялгуунд нь оймуһу.


омал - бүс.

сун - дээл.

һалган - ул.

Һерки - өмд, зарим аялгуунд хеки гэж хэлий хойгуурхи шургэх гийгүүлэгчтэй.

унта - гутал. Чухамдаа сөөхий, бойтог гутлын нэр. Орос хэлнээ унты гэж сөөхийн нэр болон хамниган хэлиээс оржээ.

хакчи, ^кханчуй, канчуй - мо  - кирилээр галиглавал канчу - канчуй гэсэн уг хамниган хэлиээ оржээ. Одоо бид канчуй гэдэг.

^кхорбё - хормой.

чигевчи - чихивч.

ж.Гэр орон, сав хэрэгсэл:

ага - аяга.

годоли - голули - сум, годли.

дамга - тамха.

дзоук - гэр орон.


дъар - ганс.


икэ, ^ки хё - тэгсөө.


кадър - казаар.

калан,калал - тогоо. Калалми тэнкел - тогоо тавь.

кайти,кайчи - хайч.

китуга,утга,ирту - мо  кирилээр галиглавал китуг-а,

 ирту гэсэн угс, хамниган хэлиээ орсон ажам.

коряган - хороо.Мо  кирилээр галиглавал коряган гэсэн уг.

намурджэ - намаржаа. Мо *ᠨᠠᠮᠤᠷᠳᠢᠵᠡ* кирилээр галиглавал намурджий-а.

нидур - нүдүүр.

нимэр - айл гэсэн үг.

ор - уур нүдүүрийн уур.

өркө - үүд гэсэн үг. Мо *ᠣᠷᠭᠡ* кирилээр буулгавал өрүкө гэсэн үг. Яз-

гуур нь өрү- гэж ухах малтахын утга бүхүй бөгөөд -ке дагавар нь тэгдэг юм, тэгсэн юм гэсэн утгатай дагавар тул өрү+кө гэж ухмал гэсэн утгатай нэр болж, эртний монголчуудын орон сууц нь, малтай болохоос өмнөх хэрмэл гөрөөчний үес ухмал нүхэн гэр байсныг өрүкө гэдэг нэр гэрчлэн буй нь хамниган хэлнээ үүд хаалгын нэр болон үлдэж ирсэн нь, өрүкө гэдгийн нэг утга нь, дороос нь утаа өөдөө гардаг, дээрээс нь шатаар хүн ордог байсныг зааж буй.

тога - гал.

тугасал - өвөлжөө.

токо - тохом.

ургунгки - шанага.

учи - хутга.

уурга - мо *ᠤᠭᠤᠷᠭᠠ* кирилээр галиглавал утург-а гэсэн үг, оцоо уурга

болон эртний угу нь уу болсон учир уур+га болж, хамниган хэлнээ харин эртний хэлбэр хадгалагджээ. Орос хэлнээ утурга гэдэг монгол уг укрюк гэсэн хэлбэртэй - гээр орсон буй.

хуо - буу гэсэн үг. Монгол буу, хамниган хуо - цөм нангиад пао гэсэн нэр үг сунжирч, хамниган хэлнээ уруулын дуугүй Пгий-гүүлэгч нь хэлний хойгуурхи шүргэх Х болж, монгол хэлнээ уруулын дуутай Б болж ирсэн байнам.

эмэгэл - эмээл.

чарсуу - цаас.

чалсуу - мөн цаарсыг чалсуу гэгчид буй.

царсуу - цаарс, цаас гэсэн үг.

3. Тэнгэр, цаг зүгийн зүйл:

Алтан гада - Алтан гадас од.

амарила - хойт зүг, хойшоо.

амила - хойно, хойш. Манжийн амалатай дүйнэ.

аньнгани - он. Манжийн аниа - аньатай дүйнэ. Хамниган өтгөс бас ань-
гани джил гэж хоршин хэрэглэх ину, царуй монголоор
он жил гэсэнтэй утга адил.

баронта - баруунтээ гэсэн монгол үг хэлэлгийн хамниган хэлбэр.

бэга - сар. Манжийн биа гэсэнтэй дүйнэ.

бокта - мөндөр.

боло - намар. Манжийн болори гэсэнтэй гарал нэг. Зарим өтгөс хамни-
ган бас болори намур гэж хэлэлцэм. /Дорнодын Цагаан-
овоо сумын Жаргал өвгөн/

боно - буоно - бас мөндөр гэсэн үг. Манжийн боно гэж мөндөр гэсэн-
тэй дүйж үзэхэд монголоор мөндөр гэсний мөн язгуур нь
даруй бөн аж, үгийн эхний б - м сэлгэдэг зүйтогтоолоор
бөн+дө+р - мөн+дө+р болж ирсэн үүний бөн- язгуур, хам-
ниган манжийн бон-лугаа учир холбогдол буйг дурдалтай.

буга - тэнгэр. Буга түрөр - тэнгэр дуугарах гэсэн үг.

джугани - зун.

джулеле - урд зүг.

дзунта - дзун дзукту - зүүн зүгт, зүүнтээ.

долбо - шөнө - сөнн.

долбони - бас шөнийг ийн хүү нэрлэнэ.

иманда - цас.

имандаран - цас орж байна. Бас иманнаран гэж дуудах ану буй.

инэнги /инэнгги/ - өдөр гэсэн үг. Манжаар инэнгги гэж бичин, дуудалга
нь мөн манай хамнигантай ойр төс ажээ.

кабур - хавар.

көкөри нангна - тэнгэр.

нелки - хавар. Зарим өтгөсийн аялгуунаа нэлки. /э нь уруулшсан/

нолун - од. Бас од гэдэг нь нилээд газар хэлэлцэх болж байнам.

ошникта - од. Тун цөөхөн өтгөс, энэ ошникта гэдгийг мэдэх бөгөөд, кан
ошникта гэж нэг од эрт дээр цагт бий гэдэг асан гэх бо-
ловч, ямар одон болохыг заан тодорхойлж эс чадав.

туга - өвөл.

туксирен - уултэж байна, уултэй болж байна.

удунджан - бороо орно, хуршина, бороошино.

удунджаран - бороо орно.

шибон - нар.

шикун - мөн нар гэсэн үг.

и.Газрын зүйл:

бира - гол. Манж хэлнээ мөн бира хэмээдэгтэй нийлэх үг.

дунда - газар гэсэн үг.

цаола - чулуу.

йанг - нүхтэн хад, малцайм хад, ян уул гэдэг үгнээ эл йанг гэдэг хамниган үг Хэнтэй хан уулын хавийн монголчуудын хэлнээ оржээ. Орос Сибирийн аман аялгуунаа голц гэдэгтэй дүйнэ.

ламу - далай, тэнгис гэсэн үг.

му - ус.

ниток - нутаг гэсэн монгол үг.

нор, нуор - даруй нуур гэсэн үг.

норан - уул.

Туру - газар шороо. Тоос тоорог гэдгийн өнцөг нь хамниган хэлнээ сунжраад явж байгаа болно: мо *рухана* тогураг.

к.Аягуус амьтаны зүйл:

абдо - мал.


адирга - азарга /"үсгийн дүрэмд" азараг/. Монгол хамниганы хэлнээ адирга гэдэг нь монгол худам үсгээр *адир* кирилээр галиглавал аджирг-а гэдэг хэлбэрээс нэн эртний хэлбэр нь хапгалагдан үлдэж, манай үе хүртэл уламжилж ирсэн болно.

адогон - адуу гэсэн үг. Эртний монгол адугун гэдгийн уламжлаж монгол хамниган хэлнээ уламжлан иржээ. Догшин адууг доксин адогон, зарим хамниган аялгуунаа дошкин адогон хэмээх муу.

адун - адууг бас зарим хамниган аялгуунаа - голцуу хуучин аялгуу хадгалагсдын дараачийн үеийн хүмүүс ийн хуу дуудам.


бирау - зарим аялгуунаа боров гэж бярууг нэрлэм,


ботага - ботго гэсэн үг.

бугура - зарим өтгөс бурыг ийн хүү нэрлэдэг асан. Одоо хойч үе "буу-
ра" гэдэг боллоо хэмээмүү. Манжийн үеийн монгол толь
бичигт буур-а гэж бичдэг боловч, зарим хуучин хулсан
үзгийн ном сударт  -кирилээр буулгавал бу-
гур-а хэмээн бичсэн хэлбэр нь дээр эртний хэлбэр байс-
ныг монгол хамниган өтгөсийн аман аялгууны уламжлал
гэрчлэм.


бука - бух.

галдангара - шар шувуу.

гакай - гахай. Хамниган хэлбэр нь монгол худам үсгээр  гэж
тэмдэглэсэн эртний дуудалгыг маш тодорхой гэрчлэж
байна.

гёку - гуу, уунд монгол худам үсгээр  гегүү гэж тэмдэглэдэг
хэлбэртэй хамниганы гёку гэдгийг харшуулж үзэхэд со-
нин байна: г - к сэлгэдэг зүй тогтоол, жич тэргүүн үед
өргөлт байсан учир гегүү нь гёку болсон зэргийн байдал
үзэгдэм.


гишце - гөрөөс гэсэн үг.

гунджи - гунж гэсэн үг. Мо  кирилээр галиглавал гунджи гэ-
сэн хэлбэр хамниган аялгуунаа байна.

гуске - чоно.

дага - даага гэсэн үг.


пегі - шувуу.

джерген, джегерен - зээр. Мо  уунд джерген гэдэг хэлбэр нь
гийгуулэгч тогторсон үзэгдэл болно.

дзумбура - зурам гэсэн үг. Сибирийн орос аялгуунаа джумбуран гэдэг
нэр даруй эл дзумбуратай холбогдолтой болно.

денджи - даруй денж мөн.


өргөл - эр үхэр.


иласун, зарим аялгуунаа иланун, хар батгана, ялаа. Үүнэ мо 
гэдэгтэй харшуулбаас илагасун нь хамниган аялгуунаа
иласун болсон бөгөөд урт эгшинг бий болсон үес хамниган

хэлнээ орсон хэлбэр болно. Чингэхдээ тэргүүн бус үеийн уруулшсан эгшиг тэр хэвээрээ маш тод үлджээ.

инакин - нохой. Манжаар индахун гэдэгтэй язгуур нэгтэй. Зарим хамниган аялгуунаа к нь х болж, инахин хэмээн дуудах ану бас буй.


инге - даруй ингэ мөн.

имаган - ямаа. Хамниган хэлбэр нь монголоор , кирилээр буулгавал имаган гэж байсан үед хамниган хэлнээ монгол хэлнээс орсон байдлыг гэрчлэн буй хэрэг.

кара гөрөсун - баавгай. Мо , кирилээр буулгавал кар-а гөрөгөсун гэдэг хэлбэрийн -үгө нь урт ө болсон үеийн уг.


качикан - мөн нохой гэсэн уг. Зарим аялгуунаа гачиган хэмээмүү.


кирэ - даруй хэрээ. Зарим аялгуунаа керё ч хэмээмүү.

кирса - хярс. Мо , кирилээр буулгавал кирса гэсэн угийн хэлбэр нь монгол хамниган аялгуунаа тэр хэвээрээ ажам.

коньён - ^кконьён - даруй хонь гэсэн уг.

курене - хүрэнэ гэдэг ам.

курикан - хурга. Мо , гэж х - г хоёрын алинаар ч дуудаж болно гэж г хэмээн заасан цэггүй бичдэг хулсан үзгийн судрын бичилигийн байдал заан буй нь, монгол хамниган хэлнээ малын нэрийн зүйл голцуу монгол хэлнээс эрт дээр цагт авсан тул, монгол худам үсэгт гэрчлээстэй дээд эртний хэлбэр нь монгол хамниганы хэл аялгуунд бичгээс ороогүй, эртний монгол аман аялгуунаас орсон тул, монгол үсгийн бичилигийг аман уламжлалаар батлан гэрчилж байгаагийн хувьд тун сонин үзэгдэл болно. Курикан гэж хамниган аялгуунаа буй нь -га- гэдэг бөлөг авианы -г- гийгуулэгчийг бас к хэмээн дууддаг байсныг гэрчлэн буй.

куца - хуц ухнын хуц. Зарим хамниган аялгуунд бас куча хэмээх ину буй даруй мо , кирилээр буулгавал куча гэдэгтэй нийлэх ажээ.

кхун - ^кхун - даруй хун шувуу.

морин - зарим аман аялгуунд нь мурин гэж дуудах ину үзэгдэм.

ниакин - даруй нохой гэсэн уг. Инакин гэдэг хэлбэр буйг үзвэл, хам-

ниган хэлнээ эхний н- бүхүй үгнээ бас ни- бүхүй хэлбэртэй сэлгэдэг үзэгдэл нь монгол худам үсэгт имаган - нимаган *ᠨᠢᠮᠠᠭᠠᠨ* гэж байдаг, мөн зарим монгол хэл аялгуунаа ямааг нимаан гэдэг үзэгдэлтэй нэгэн ижил авианзүйн үзэгдэл ажээ.

нонгокан - унага гэсэн үг.

сар - цар - швр /үхэр/. Ойрад аялгуунаа бас цар гэдэгтэй адил хэлбэр хамниган аялгуунаа байгаа болно.

сулаки - үнэг.

нукер, зарим аман аялгуунаа нукер гэж үхэр гэдгийн нэр нь, эртний монгол хэлний хэлбэр нь монгол хамниганы аялгуунаа байгаа нь, монгол худам бичигт эхний *h* гэдэг төвөнгийн шүргэх гийгүүлэгчийг тэмдэглэдэггүй хэлбэрээс эртний байдал нь хамниган хэлнээ үлджээ.

тарбакан - тарвага.

тэмэгэн - тэмээ. Монгол хамниганы хэлнээ буй энэ үгийн хэлбэр нь бас маш дээр цагт, тэмэгэн гэж монголчуудын хэлж байсан үед орсон хэлбэр бөгөөд зөвлөлтийн нутагт буй хамниган хэлнээ бас эл эртний хэлбэртэй байгаа нь тэмдэглээс - тэй дотроос өнгөрсөн зууны сүүлээр Турухан хязгаарын хамниганаас тэмдэглэсэн үгийн зүйл Польшийн Шинжлэх ухааны академид Котвач профессорын материалд буйг дурдаж болно. Монгол хамниганы аман аялгуунаа э нь уруулшсан байдалтай өгүүлэх ажээ.

туксаки - чандага.

тутуксан - тугал гэсэн үг.

укуна + ухна гэсэн үг. Мо *Ухна* кирилээр буулгавал укун-а гэдэг үгийн эртний дуудлага нь хамниган хэлнээ үлджээ.

унукуце - ишиг.

харацанг - тогруу шувуу гэсэн нэр. Бас харанчан хэмээмүү.

хуймекекте - шумуул, бургуус гэсэн үг.

чирукай - цурхай загас. Мо *Чирхуй* кирилээр буулгавал чирукай гэсэнтэй яг дүйх ажам. Монгол хэлнээс хамниган хэлнээ оржээ.

чөгчөгөй - чөгцгий бялзуухай. Мо *Чөгчөгөй*, кирилээр буулгавал чөг-
чөгөй гэдэгтэй ит дүйж байгаа нь, дээр эрт цагт монгол
хамниганы хэлэнд ороод, тэр хэлбэр нь хэвээрээ манай
үед уламжилжээ. Гэтэл, энэ зүгийн монгол аялгуунаа эрт-
ний чөгчөгөй гэдэг хэлбэр нь авианзүйн сунжралын зүй-
тогтоолоор чөгцөгий болж ирсэн нь кирил үсгийн дүрэмд
"чөгцгий" гэж -гиг- гурван гийгүүлэгч бөөгнүүлэн дав-
харлуулж бичүүлдэг нь монгол хэлний үеийн тогтолцоо -
ноо тийн хуу гурваад гийгүүлэгч давхарлан хурах зүй-
тогтоол үгүйг монгол хэлний авианзүй судласан бүх дэл-
хийн монголч эрдэмтний шинжлэл судлалаас илэрхий.

к. Адгуус амьтаны зүс бяддарын зүйл:

багцарий - цагаан.

бөкун - бөх.

гирамн - будуун.

гирамда - яс.

гудиге - гүзээ. Мо *Гудиге* кирилээр буулгавал даруй гүджиге. Мон-
гол хамниганы хэлнээ буй эл үгийн хэлбэр нь джи нь ди
байсан бүр эртний үеийн хэлбэр хадгалжээ.

джалан - үе.

имукса - өөх.

каливун, зарим аялгуунаа калиун - халиун.

коннорин - хар.

конггур - конгор. Мо *Конггур* кирилээр галиглавал конггур гэдэг хэл-
бэр нь монгол хамниганы хэлнээ уламжилжээ.

көшө - хөх.

нонда - арьс шир гэсэн үг.

нонеми - нарийн.

нем - им. Монгол худам үсэгт тэмдэглэдэггүй эхний *h* гийгүүлэгч нь
монгол хамниганы хэлнээ уламжилж ирсэн нь, монгол хэл-
нээс дээр цагт орсон үгийн байдлыг хадгалжээ.

нокур суол - охор суул. Нокур гэдэг нь даруй эртний монгол хэлний но-
кур, монгол худам үсэгт *h* гийгүүлэгчгүйгээр *Уанс*
кирилээр галиглавал скур гэж дууддаг болсон үед тэмдэг-

лэсэн аваас, хамниган хэлнээ тэр үеэс бүр эртний хэл -
бэр манай үед уламжлан иржээ.

булак^{ан} - улаан гэсэн нэр. Бас л монгол хамниганы хэлнээ монгол худам
үсэгт тэмдэглэгдээгүй эртний байдал уламжлан иржээ.
Энэ булак^{ан} гэдгээс бас булама гэдэг хэлбэр уламж-
ласан ану монгол хамниганы хэлнээ буй.

сирга - шарга гэсэн үг. Мо ^{сирга} кирилээр галиглавал сирг-а гэдэг
хэлбэр нь манай хамниганы аман аялгуунаа уламжлан
иржээ.

суол - суул гэсэн үг. Охор суулийг нокур суол гэдгийг дээр өгүүлсэн
билээ.

ногдонго - их, том гэсэн үг.

турай - даруй туурай гэсэн үг.

укуи - суу гэсэн үг.

улдэ - мах гэсэн үг. Бас улдэ гэгчид буй.

умукта - өнцөг гэсэн үг.

чокур - цоохор гэсэн үг.

шангарин - цагаан гэсэн нэр. Манжаар шаньяан гэдэгтэй язгуур нэгтэй.

д. Ургамалын зүйл:

бургасун - зарим аман аялгуунаа бас бурга^нху - бургас мод.

гүдиг^гэлдигене - гүэээлэгэнэ. Өтгөс Жаргал, энэ жимсийн нэрийг бага -
даа эмэг эхээсээ соноссон. Одооны багацуул ондоогоор
нэрлэдэг байх гээд, байдлы нь хэлсэн нь гүэээлэгэнээс
зайлахгүй ажээ. (Жаргал өтгөс, Дорнодын Цагаан-овоо
сумын хүн).

иректа - хар мод, шинэс, харгай ч гэдэг модны нэр.

кайласун - даруй хайлс мод.


кусун - хус мод. Зарим аман аялгуунаа куйун, хуйун гэдэг хэлбэр дай-
ралдсан. Мо ^{кусун} гэдгийг кирилээр галиглавал да-
руй кусун болох нь хамниган аялгуунаа эртний дуудалга
нь уламжлан иржээ.

мангисун - мангир.

мо - мод гэсэн үг. Манжаар мен мо гэдэгтэй дүйнэ.

мойл - зарим өтгөс^{ийн} амна мойил гэж дуудах ану буй.


напти, зарим аялгууна лапти - лапчи, бас напчи даруй навч.


нарасун, зарим аялгууна нараһун - нарс мод. Мо  гэдгийн
кирилээр галиглавал нарасун болох нь етгөс хамниганы
аялгуунаа эртний дуудалгын байдал тод томруун үзэгдэм.

орокта - өвс гэсэн үг.


оропта - мөн өвс гэсэн үг. Хамниган аялгуунаа орокта - оропта гэж гий-
гуулэгч к-г авиа п - б авнатай үеийн адагт сэлгэдэг
үзэгдэл буйг гэрчлэм бөгөөд монгол хэлнээ мөн ийм зүйл
буй нь дэвш - дэгж гэдэгт үзэгдэн буй. Гагц хуу одооны
"үсгийн дүрэм" гэж хятад хэлнээс орчуулсан нэр томъёо
бүхүй "дүрэмд" б гийгуулэгчийн нэгэн хувилбарыг "в"
хэмээн үзсэн учир нь, б гийгуулэгч бол, хоёр эгшгийн
дунд орохдоо, өгүүлэхийн эрхтний ажиллагаа шуурхайн
учир, хоёр уруул хамхиж завдахгүй учир, шүргэн өгүүлэх
хувилбар авиа болдог байна: Байна! Хаа вайна! гэх мэт.
Энэ учрыг мэдээгүйн зэрэг байдал, "үсгийн дүрэмд" нэн
үлэмж бий тул, ижил үзэгдлийг өөр өөрөөр бичих явдал
үүсэн, нүдэнд тодорхой үзэгдэх зүйлийг бүрхэгдүүлэх яв-
дал цөөнгүй.

темисун, зарим аялгуунаа тебисун, тебинун гэх ину цөм төмс гэсэн үг.

Мо  кирилээр галиглаж үзвэл төмүсүн гэдэг
үгнээ те нь тө- байж, -м- дагавар нь -бу- -би-
хувилбартай байсны гэрч нь монгол хамниган аялгуунаа
эртний бөгөөд монгол хулам үсэг бичигт гэрчлэгдээгүй
хэлбэрээс үзэгдэн, Байгалын хойт биеийн зарим буриад
аман аялгуунаа тибэһэн гэсэн хэлбэр байгаатай нийлэн,
эртний хэлбэрийг үзүүлэн буй.

тугучек - хожиул мод гэсэн үг. Хуучин хулсан үзгийн сударт эл хэлбэр
 хэмээн тохиолддог нь, кирилээр галиглан буул-
гаваас даруй тугучек хэмээсэн болой. Тэр хэлбэр, өдгөө
монгол хамниганы аман аялгууны нэгэн хэсэгт уламжла -
саар иржээ.

улир - өлир - өрш гэдэг жимс. Даруй ээрлэг алимын нэр болно. Мо


 кирилээр буулгавал өлир гэдгийн хэлбэр нь мон-


гол хамниганы аман аялгууны зүйл уламжилжээ.

м.Төмөрлигийн зүйл:


Алтан - даруй монгол хэлнээс орсон нэр. Алтанхан овгийн бэрээд урд нь алтан гэдэг нэрийг цээрлэн бэрлэхдээ алтыг humane мөгөн гэдэг байсан ажээ.

джес - джет - даруй зэс гэсэн үг.

корголджи - хар тугалга, хорголж гэдгийн нэр, мо  кирилээр буулгаж үзвэл коргулджи гэсэнлүгээ хамниган нэрийн хэл бэр маш ойр.

кулэр - кулер : даруй хүрэл гэсэн үг. Мо  кирилээр буулгавал кулер гэдэг хэлбэр нь өтгөс хамниганы аман аялгуунаа уламжилжээ.

мөгөн - мөнгө гэдэг эрднийн төмөрлигийн нэр.

селе - төмөр гэсэн үг. Селенге гэж төмөрт гэсэн нэр бөгөөд манай Селэнгэ гэдэг маань даруй эртний хамниган овогтны өгсөн нэр болно. Тэрчлэн хамниганаар селеме гэдэг нэр бол, төмөр юм, төмөр зэвсэг гэсэн нэр бөгөөд монгол хэлнээ эрт дээр цагт орсон нь, мо  кирилээр галиглаж үзвэл селе-е, одоо бид е авиаг э гэж авсанаар бол, селэ-мэ байх учиртай нь сэлэ-мэ гэж төмөр юм /зэвсэг/ гэж бүтсэн нэр болно. Үүнд дагавар, үндэс язгуур гэж ухаа - раагүйгээр зохиосон "зы фа" гэсэн үсгийн дүрэмд эл -ма, -мэ гэсэн дагаврын эгшгийг хасаж зэрэмдэглэсэн нь, жинхэнэ хэлний шинжлэх ухааны үүднээс бол, чингэж хагас зэрэмдэг болгох ёсгүй зүйл байгаа юм. Монгол хэлний зөв бичих зүй гэдгийг шинжлэх ухааны үүднээс боловсруулахад үнэн мөн байдлы нь босгох учиртай болно.

Монгол хамниган хэлний үгийн сангаас энэ дээр дурдсан хэдэн арван үгийг монгол толийн уламжлалаар зүйл хуваан үзэхэд, төрөл ойр үгсийг нэгэн дор бөөгнүүлэн үзүүлбэл зүгээр бол уу гэж ийнхүү зүйл хуваан жагсааж бичлээ. Нарийвчлаж монгол хамниганы одоогийн өтгө - сийн мөдөх үг бүрийг нь нэгэд нэгэнгүй бүртгэн тэмдэглэж заавдсангүй.

Чингэвч, бусад улс нутгийн хамниган хэл аялгуутай харшуулж үзэхэд, монгол хамниганы язгуур хамниган өвөнх хэл аялгуу нь бусад хамниган

аймгийн алинтай нь ойр төрөл болохыг эцгээр угийн байдлаас нягтлан таниж болох болов уу хэмээн үзнэ.

6.МОНГОЛ ХАМНИГАНЫ ЭВЕНКИ ХЭЛНИЙ ХЭЛБЭЭРЗҮЙН ЗАРИМ ЗҮЙЛЭЭС

Монгол хамниган бол тус улсын Увс аймгийн Тариалан суманд нутаглан буй түрэг угсаат хотонг бодвол, хэлний хувид угсийн сан болон хэлзүйн талаар нилээд юм хадгалсан байдал илэрхий байна. Хотонгууд, манай зууны эхэн үед хэлээ мэддэг, араб угсийн бичиг мэддэг хүнтэй байсан үндэстэн⁺ байсан бол, 1937 оноос хойш араб бичиг үсэг мэддэг хүн үгүй болохын дээр, хотон угээ мэддэг өтгөс өвгөд ч ховордсоор, одоо гурваад мянган хотон дунд гагц хуу хэдэн уншилгын зэрэг хэдхэн зүйлийг пээжээр мэдэх хоёр гуравхан хүний төдий үлдээд, хотон угээрээ хэлэлцэн чадах хүн үгүй болж, ганц нэг, хоорондоо холбоогүй салангид үг дутуу хагас мэдэх тав зургаан хүний төдий үлдсэн байвал, монгол

+ Үндэстэн гэдэг монгол нэртомьёо бол орос хэлнээ национальность гэсэн нэртомьёотой утга дүйх бөгөөд, монгол хэлээр нийтлэн мөн орос хэлээс орчуулан буй ном зохиол, сонин хэвлэлийн мэдээнээ манай энд болон Зөвлөлт улсын хэвлэлд монголд зориулан монгол хэлээр хэвлэн гаргаж байсан бүх зүйлд Совет Национальностей гэдгийг Үндэстний Зөвлөл гэж түүний тухай мэдээ монгол хэлээр анх бий болсон цагаас эхлэн хэрэглэсээр иржээ. Үүнд зарим нэгэн хүн, нация – национальность хоёрын ялгамжааг ухаараагүй учраас, тэр хоёр харилцан ялгаатайг хутгаж, хоёулы нь "үндэстэн" гэж боддог ану буй боловч, боловсролт сөхөөтөн хүн болон эрдэм шинжилгээний зохиолд эд ялгаврыг баримтлах нь ёс тул, нация гэдэг улс үндэстэн, национальность гэдэг үндэстэн гэдгийг зөвөөр хэрэглэх ёстой: та ямар үндэстэн бэ? гэдэг асуултыг орос хэлнээ буулгах юм бол, даруй вы какой национальнoсти? гэхээс, вы какой нации гэж боловсролтой хүн хэлдэггүйгээс үндэстэн гэдэг угийг орос зэргийн бусад хэлнээ национальность гэдгээс өөр утга таарахгүй нь илэрхий. Бас зарим хүн, ястан гэдгийг национальность гэж ухаардаг нь түмэн ташаа болохыг энд чухас дурдалтай. Монгол түрэг нийт яс гэдэгт хан харц гэж ялгадаг нь, хар ястан, цагаан ястан, хан ястан, харц ястан гэдэг уламжлал буй нь үндэстэнд хамаагүй, нийгэмлэгийн гарлын ялгаа тодотдох нэр байсан байна. Тэр учраас, хан ястан, цагаан ястан гэдгийг ханская национальность, белая национальность гэсэнтэй яг адил болж, шал буруу ташаа ухааралт болох нь үүнээс илэрхий байна. Яс гэдэг нь орос хэлээр происхождение, род гэсэн утгатай бөгөөд, хан ястан гэдгийг царского рода, ханского рода, благородного происхождения гэж орчуулдаг бөгөөд орос хэлнээ монгол-түрэг хэлнээс ал яс гэдэг нэр дээр цагт нэвтрэн орж, хувисгал хуртэл орос хэл бичигт черная кость, белая кость гэж хэрэглэдэг байсан нь монгол хэлнээ хар ястан, цагаан ястан гэдэгтэй утга санаа эгээ нэгэн байсан байнам.

хамниган дунд, хүн амын хувид хотонгоос нэг их илүүгүй боловч, жинхэнэ хамниган эвенки үгээрээ ойр зуурынхаа тулга тойрсон ярианы зүйлийг бүрэн гүйцэд залгуулж орхидог өтгөс хорь гучаадын ээрэг лавдуу байгаагийн дээр, монгол хэлний дээд- дундад эртний аялгуугаар, түүнээ хамниган аялгуу хэмээн ухааран хэлэлцэгчид хэдэн арваар буй үүнд, жинхэнэ хамниган хэлний үгий нь нэгэд нэгэнгүй энэ хир хараахан тэмдэглэж гүйцээгээгүй боловч, тэмдэглэж авсан тус тус уг, бас уг хөлбөн өгүүлбэр болгосон зүйлийг нягтлаж үзвэл, монгол хамниганы жинхэнэ хамниган буюу эвенки хэлний гол байдал, хэлзүйн гол шинж байдал нь илэрхий болж, чанагшид нягтлавал, дэлхий дээр буй хамниган үндэстний олон бөлгийн алинтай нь ойр шадар болохыг мэдэж болох баримт байгаа нь порхиос тодорхой үзэгдэх бий.

А.Хамниган эвенки хэлний нэр үгийн тооны ай

Монгол хамниганы жинхэнэ хамниган хэлнээ нэрийн зүйлд тооны ай буй нь, монгол хэлний нэрийн айтай төстэй үзэгдэнэ. Үүнд европ хэлнээ хамниган хэлнээ ганцтоо, олонтоо гэж хоёр зүйлийн тооны ай бий гэж бичсэн судлал шинжлэлийн бичиг зохиолд гардаг нь, европ хэлнээ буй айн үүднээс үзсэн байнам гэж хэлж болно. Гэтэл, хамниган үгнээ ганцтооны ай бүхүй үг гэдгий нь үзвээд, олень, тунгус гэж ганц ширхэг буга буюу ганц ширхэг хамниган хүнийг нэрлэсэн нэр биш, орон гэдэг бөгөөд монгол хэлнээ мөн ор гөрөөс гэж хамниган хэлнээс орсон нэгэн зүйл бугын нэр болохоос, цорийн ганц ширхэг гөрөөсний нэр, ганц ширхэг хамниган хүн гэж үзэхийн нөхцөлгүй, даруй ор гөрөөс нийтийн нэр, хамниган нийтийн нэр болж байгаа нь монгол хэлнээ төрөлтоо гэдэг ай буй-лугаа ав адил байнам. Тэр учраас, нэрийн зүйл цөм, язгуур ганц үгээр бүтсэн нэр байна уу, язгуурын сүүлд нь дагавар залган нэр болгосон байна уу, цөм, тэр төрлийн нэр бүхүй юмыг бүтдий нь хамран заасан нэр болно: монго гэж ганц ширхэг монгол хүн биш, луоча гэж ганц ширхэг орос хүн гэсэн биш, монгол хүн бүтдийг монго, орос хүн бүтдийг луоча гэдэг байна.

Төрлөөр нь нэрлэх нэрийн айгаас харин -сал, -сөл /сөл/ дагавар залгаж, монгол хэлний адил нэр төрлийн зүйлээс нэгэн хэсгий нь салган заасан нэр болгодог байнам. Үүнд нарийн ажвал, тэр -сал-сөл дагавар нь манж хэлний -са-, сә- дагавар дээр бас -л гэдэг дагавар зал-

гасан нийлбэр дагавар байгаа бололтой.

Төрөлтооны айн нэрийн жишээ нь: морин, эмэгэл, бөйе, адирга гэх мэт бөгөөд хэсэгтооны айд оруулахдаа морисал, эмэгэлсэл, бөйөсөл, адиргасал гэж морид, эмээлүүд, хүмүүс, азаргас гэсэн утгатай нэр болгоно.

Үүнд, нягтлан үзвэл, хамниган хэлний -сал, сел дагаврын -л нь монгол хэлнээ бас гэрчлээстэй дагавар бөгөөд энэ тухайд хамниган-монгол дагавар байна: мо *мори* кирилээр галиглавал аргасун, мо *мори* кирилээр буулгавал нарасун, мо *морисал* кирилээр буулгавал годусун, тэр нь -цу- -су- хоёр нь ижилшээд ирэхэд ойрад-монгол аялгууны госун-огцомхон өгүүлбэл госон - госн болж монгол бичгийн баримтаар үзэхэд, эл төрөлтооны нэрийн зүйлд -су-, -су- *су* дагавар нь төрлөөрөө нэг юм гэж заасан утгатай дагавар учир, хэсэгтооны айд оруулахад -су-, -су- дагавар утгаараа илүүдэх учир хасагдаж, аргасун гэдгээс аргад гэсэн хэсэгтооны айт нэр, нарасун гэдгээс нарад годусун гэдгээс *госун* монгол хэлнээ у - о сэлгэдэг бөгөөд зарим байдалд угийн дунд -д- гийгүүлэгч нь дуугүй т болдог авианзүйн зүйтогтоолтой тул, годусун -готол гэж зарим аялгуунд угийн о өгшиг нь о хэвээрээ, зарим аялгуунд о нь у болж гутун болж ирсэн байнам.

Мөн эл -л гэдэг хэсэгтооны айн дагавар монгол, хоргод гэдэг нилээд олон нэрийн зүйлд монгол хэлнээ үзэгдэн буй үүнд манж, хамниган, нангиад зэргийн олон улс угсаатны хэлэнд дээр эрт цагт монго, мэнгү гэж орсон байдлаас монгол гэж суулд болсон буюу нэршин алдаршсан нэр болно. Хоргод гэдэг нэрийн зэргэцээгээр монгол бичигт коргосун, одооны манай хэлнээ эртний к гийгүүлэгч цөм шүргэх х болсон учир коргосун гэж дуудах бөгөөд ойрад аялгуунаа коргосон - хоргон гэж одоо хүртэл нэрлэсээр буй хэлбэртэй харшуулж үзэхэд, хоргод, аргад, монгод гэдгийн -л нь даруй хэсэгтооны утга бүхүй нь тодронхон илэрч, тэр -л нь хамниган хэлний -сал гэдэг нийлбэр дагавар -л даруй мөн болсоос зайлахгүй бололтой.

Ери гэж энэ, тари гэж тэр гэдэг заах нэрийн зүйлд ерид гэж эдгээр бую эд /эдэ! / тарид гэж тэдгээр, тэд /тэдэ! / гэсэн утгатай болгодог, мөн бөйе гэж хун гэдгээс бөйөд гэж хүмүүс гэсэн утгатай болгодог үүнд -д гэдэг дагавар, хамниган хэлнээ дангаараа бас хэсэгтооны айн үзүүлэгч болж ордог байна.

Б.Хамниган хэлний нэрийн тийн ялгалын зүйл

Хамниган аялгууны учир Кастрен гэдэг фин эрдэмтний 1886 онд нийтлэгдсэн шинжлэл Rundzuge einer tungusischen Sprachen-гэдэгт өгүүлсэн хамниган аялгууны хэлбэрсудлалын зүйл нь монгол хамниганы эвэнх хэлтнээс бидний ажин тэмдэглэж авсан үгсийн хэлбэр байдалтай нилээд ойролцуу бөгөөд манай тэмдэглэлд буй цөөвөр үг өгүүлбэрийн зүйлтэй харшуулж үзвэл, тийн ялгалын хэлбэр нь Кастрены тэмдэглэлтэй их л ойролцоо болох уунд хэдэн жишээ дурдваас:

Төрөл тооны ай:

Хэсэгтооны ай:

мó - мод

Nom.	мó	мол
Gen.	мóнга	мóлнга
Dat.	мóгу	мóлгу
Acc.	мóва	мóлва
Abl.	мóдук	мóлдук
Instr.	мóджи	мóлджи
Comit.	мóнун	мóлнун
Prosec.	мóли	мóлдули

кадум - хадам

Nom.	кадум	кадумил
Gen.	кадумяги	кадумиялги
Dat.	кадумгу	кадумилгу
Acc.	кадумма	кадумилва
Abl.	кадумдук	кадумилдук
Instr.	кадумджи	кадумилджи
Comit.	кадумнун	кадумиялнун
Prosec.	кадумдули	кадумиялдули

орон - ор гөрөөс

Nom.	орон	орор
Gen.	оронги	орориги
Dat.	оронду	орорду
Acc.	оронва	орорва
Abl.	орондук	орордук

Instr.	оронджи	орорджи
Comit.	оронун	орорун
Prosec.	орондули	орорли

Бие заах нэрийн зүйлээс

Төрөлтооны ай:

Хэсэг тооны ай:

би - би

Nom.	би
Gen.	минги
Dat.	минду
Acc.	минөвө
Abl.	миндук
Instr.	минджи
Comit.	минун
Prosec.	миндули

бу
мунги
мунду
мунөвө
мундук
мунджи
мунун
мундули

си - чи

Nom.	си
Gen.	синги
Dat.	синду
Acc.	синөвө
Abl.	синдук
Instr.	синджи
Comin.	синун
Prosec.	синдули

су
сунги
сунду
сунөвө
сундук
сунджи
сунун
сундули

ери - энө

Nom.	ери
Gen.	еринги
Dat.	еду
Acc.	ервө, еривө
Abl.	едук
Instr.	ерджи
Comit.	еринун
Prosec.	ерли

ерил
ерилиги
ерилду
ерилвө
ерилдук
ерилджи
ерилнун
ерилдули

Европын хэлний шинжээчин, энэтхэг-европ хэлнээ ганцтоо, олон-тоо гэж нэрийн хоёр ай байдаг хэмээн герег-латин хэлний зүйн нэртөмь-

ёо буйг хамниган-монгол зэргийн алтайн хэлнээ хэрэглэсээр иржээ. Үүнд, чингэж хэрэглэх нь тэдгээрийн бичиж буй хэлнээ зөв байж ч магад:морь гэхэд тэдгээр европ хэлний цийлэнхид нь: нэгэн зүйл амьтан гэж сэтгэлд орохын хамт, бас тэр нэгэн зүйл амьтан нь ганц ширхэг юм байна гэж сэтгэлд нь алгасалгүй төрөх нэгэн зүйл сэтгэгдэхүүн буй нь бараг голлож, ямар нэгэн нэр соносонгуут, урдаар нэг ширхэг тийм юм байна гэж ухаардаг учир ганцтоо гэдэг ай байх нь тэдгээр хэлний байдалд аргагүй хэрэг. Түүний хажуугаар европ хэлний олонхид нь бас нэрийн хүйс гэж зэргэнэл нэгэн сэтгэгдэл төрөгдөн, уг холбон найруулахад тэр нэрийн хүйслээ холбогдох зүйл, хамниган хэлэнд үзэгдэхгүй бөгөөд нэр өгсөн зүйл нь, тэр төрлийн юмыг ер нийтээр нь багтаан анхаарахын хувил мөнгөл хэлний төрөлтооны айлугаа санаа адил. Нэрийн зүйлд бас дагавар залгаж, тэр төрлийн юмны нэг хэсэг гэсэн утга үзүүлдэг нь, монгол хэлний хэсэгтооны дагаврын утга санаатай ив ижил зүйл болно. Европ хэлзүйчин, түүнийг олонтооны дагавар гэж үзэж ирсэн нь, өөрсдийн сурсан ухааралтаар тэдгээрийн өөрсдийн хэлнээ байдаг айн нэрийг эуун хэрэглэж ирсэн нну бөгөөд, нарийвчлаваас, олонтоо бус, хэсэгтооны айг үзүүлсэн дагавар байдаг байнам.

В. Хамниган хэлний үйл үгийн цаглах байдлаас:

Үйл үгийн зүйлд аман ярианы үгнээс тэмдэглэсэн хэлбэр хараа - хан бүрэн гүйцэггүй боловч, бусад хамниган хэлний хэлбэр байдалтай харшуулан үзвээс, энд бүртгэн тэмдэглэж авч амжаагүй хэлбэр нь тэдгээрээс олдох цөхцөлтэй бөгөөд өнгөрсөн зууны суул, энэ хорьдугаар зууны эхээр хэлэлцэж байсан манай хамниган эвенки хэлээр хэлэлцэж байсан үес ямар байдал хэлбэртэй байсныг андашгүй төсөөлж болох байна.

Үйл үгийн зүйлээс энд тэмдэглэсэн хэлбэрийг үзүүлэх үүнээ би - байна гэсэн үйл үгийн хэлбэрийг гурван биеэр ялган үзүүлбээс:

Олоо цагийн байдал:

1. Бисим - би байна.

1. Бисиф бид байна.

2. Бисинди

2. Бисис

3. Бисин

3. Биси, /уртаар татвар/бисе!

Өнгөрсөн цагийн төлөв:

1. Бицёв

1. Бицёвун.

2.бицэс

2.бицэсун.

3.бица

3.бицэл.

Ирээдүй цагийн төлөв;

1.Бидэигөф

1.Бидэигевун

2.бидэигэс

2.бидэигэсун

3.Бидэигөн

3.Бидэигөл

Болдзох төлөв;

1.Бисимдээ

1.Бисимдээ

2.бисиндидээ

2.бисисундээ

3.бисиндээ

3.бисидээ

Тушаах төлөв:

бикөл?

Өнгөрсөн цагийн төлөв дотор бас -нки дагавартай хэлбэр буй нь өнгөрсөн цагийг үзүүлэхийн хамт бас ахин дахин болдог байдлыг үзүү - лэх утга бүхүй хэлбэр байна. Монголоор би морь уургалдаг гэсэн санааг эл хэлбэр гурван биеэр үзүүлэхдээ:

1.Би морин укургаланкив

2.Бу морин угургаланкив.

2.си морин укургаланкис

2.си морин укургаланки.

3.Эри /тари/бөйе морин укургаланки.

3.Эрил /тарил/морин укургалан-
ки.

Өөр нэгэн үйл үгийн цаглах байдлаас энд уг тэмдэглэл дотроос сийрүүлэн үзүүлбээс; тукса - гэж гүй гэсэн үйлийн үндэснээс:

Одоо цагийн төлөв:

1.Би туксам

1.Бу туксам

2.си туксандэ

2.су туксаран

3.тара бөйе туксаран

3.тарил туксара.

Үүнд тара бөйе гэж тэр хуш гэсэн уг бөгөөд ойрхийг өгуулэх ахуй эрө бөйе туксаран гэх ажээ.

Өнгөрсөн цагийн төлөв;

1.Би туксацов

1.Бу тукцов

2.си туксацас

2.су туксацавун

3.эрил/тарил/туксаца

3.эрил/тарил/туксатуксаран

Ирээдүй цагийн төлөв:

1.Би туксадэов

1.Бу туксадэавун

2.си туксадзас

2.су туксадзасун

3.эре/тара/туксаджан

3.эрил/тарил/туксаджан.

Хүсэх төлөв:

1.Би туксадзам - би гуйх асан

1.Бу туксамца

2.си туксамцас

2.су туксамца

3.эре/тара/ туксамца

3.Эре /тара/ туксамца.

Тушаах төлөв:

туксакал - гуй! Туксакалдуй - гуйгтун! Туксак Гуйг!

Угуйсгэн /хорин/ тушаах төлөв:

Эди туксара! - Буу гуй! Тарил эди туксара! Тэд буу гуйг!

Асуух дагавар: гу? .Монгол хэлнээ одоо уу? гэдгийн эртний бөгөөд дундад үеийн бичиг тэргүүтэнд үзэгддэг *ᠭᠦ, ᠭᠦ* даруй хамниган хэлнээ гу хэлбэрээр байж байгаа болно.

7.ХАМНИГАН ЭВЕНКИ ХЭЛНИЙ ЯРИАНЫ УГСИЙН ЗУЙЛЭЭС:

- Мөндө! - Та мөндэ уу гэсэн уг.

- Су мөндө ! - Та мөнд ээ!

- Джа,аяа бисинди? Джа, сайн байна уу, та?

- Аяа,аяа! - Сайн сайн! гэсэн уг.

- Джа, эма сонин бисинбе? - За,ямар сонин байна вэ?/ За,сонин юу байна/

- Эма сонин ашин. - Ямар ч сонин угуй./Сонин юм угуй гэсэн уг./

- Ни гербичи бисинде? Хэн нэртэй вэ чи? /Нэр хэн бэ?/

- Сунгни герби кибе? Танай нэр хэн бэ?

- Илебе нитук? - Хаагуур нутагтай вэ?

- Сунгни нитук илабе? - Танай нутуг хаа вэ?

- Аличи бисинде? - Хэний хүртэл байхав?

- Су аличи бисинде? - Та нар хэний хүртэл байхав?

- Сунгни нитукду бейуни бисингу? - Танай нутагт ан бий юу?

- Бисин,хете бейуни бисин! - Бий,олон ан бий!/Элдэв ан бий гэсэн уг./

- Су илеке уменде? - Та хаанаас ирэв?

- Уланбатурдуке умен - Улаанбаатараас ирлээ.

- Эду адира ангадэов? - Энд хэд хонох вэ?

- Дамгайн такал! - Тамхи тат!

- Мэндэ бисичи - Мэндэ байна уу?
- Су мэнде! - Та мэнде уу? Та мэнд ээ!
- Нингэ омонги бисинди? - Хэний хүү вэ чи?
- Ади омонгичи бисинде? - Хэдэн хүүтэй вэ?
- Ади хуначи бисинде? - Хэдэн охинтой вэ?
- Инахин тоймогин гогорон -нда долбо енецебе? - Нохой тоймог хуцав.
- ямар хун ирэв?
- Ирги доменди? - Хаанаас ирэв?
- Ирги сэдзэсбае? - Хаа хүрэхэв?
- Адиби ишиндибе? - Хэд хүрч байна? /Нас хэд хүрч байна? гэсэн үг/.
- Улде дзапкал - Мах ид.Зарим аялгуунаа улде джепкел гэнэм.
- Илекал! - Бос! гэсэн үг.
- Нунгундаки бегин оринду минджи өмөцө - Зургадугаар сарын хоринд
- надтай ирлээ.
- Мориндуки йуча - мориноос буу.
- Моринджи геркукал - мориор яв.
- Моджи сукекал - модоор похь.
- Миндуки өмөкөл - над тийш ир.
- Өгушкя ненекөл - сеергее яв, буцаад яв.
- хоранду йучен - уулаад гарна.
- Би хоран мейүдзөв - би ууланд гарсан.
- Сургулиндү сураджан - сургуульд сурнан.
- Сургулиндү суруца - сургуульд сурсан.
- Евенкиджи сам - Хамниган хэл мэднэ /би/.
- Си евенкиджи сандигу? - Чи хамниган хэл мэдэх уу?
- Тара евенкиджи сарах - Тэр хун хамниган хэл мэднэ.
- Туксирен, улунджан - Уултэй болж байна.Бороо орно.
- Би Чаганьоводу бинкев - Би Чагаан-овоод байдаг вэ.
- Би бейуцел. Би тарбакайн ванкив. Би тарвага алдаг. Гипсейн ванкив. Би бор гереес алдаг. Гускейн ванкив. Чоно алдаг. Джулеле дээргени ванкив.
- Урагшаа эээр алдагав.
- Мунгийн еду иманда ничи көкөцө - Манай эид нас бага орлоо.
- дегги иманда иманда - нас их орлоо.
- Ере аягнани орокта аяаджи ургуца - Энэ жил өвс сайн ургасан.

- Тара бару́н ниме́рсел - Тэр баруун айлуул.
- Ниме́ренгү таду́ - айлын тэнд.
- Морингү таду́ - морины тэнд.
- Улдeду́ нeкeл - улдeлдү нeкeл - махан дээр тавь. Хэсэг маханд очиж тавь.
- Моринду оро́ктойи бүкeл - моринд өвс өг.
- Мориндубан оро́ктойи б'укeл - мориндоо өвс өг.
- Моринги емегелбeн бeрикeл - Мориныхоо эмээл ав.
- Ере а́йа адугу́н - энэ сайн алуу.
- Морин еминнакeл - морь уcла.
- Тeмeгeндү нeнeкeл - тэмээнд оч.
- Кони́нду нeнeкeл - хонинд оч.
- нукурду нeнeкeл - үхэрт оч.
- Би морин укургалангкив - би морь уургаллаг.
- Би морин укургалачо́в - би морь уургалсан.
- Бейе акицe, сун дэакацe - хун ахтай, дээл захтай.
- Төрөлби eдэи са́рйи нинакин - төрлөө мэдэхгүй нохой.
сeлeбe eдэисарe кхурe - төмрөө мэдэхгүй хуурай.
- Бу́дeлeби укхайа́eн - өтлөтөл ухаан орохгүй,
придeлaби силeйe а́eн - үлтэртэл шөл орохгүй.
- Кхулагайчи бейени учи eмope - хулгайч хүний хутга хурц.
- Нинакинджи угеми корбe йа́eн - нохойтой муу хүн - хормойгүй,
но́йонджи угеми согдо́нко йа́eн - ноёнтой муу хүн нуруутгүй.
- Епeсe моринду покто горо - эцсэн моринд газар хол,
бунe бeйeдe шибон горо - үхсэн хүнд нар хол.
зуга́ йлсeн бeйeдe гeрки горо - зугаагүй хүнд нөхөр хол.

Эвeнки үгээр ярьсан холбоо үгийн жишээ:

Урладу eвeнки бeйeлдү са́мaсeл нeгдii бицe. Тари са́мaсeлнii дулиндун
Урда хамниган улст бeөнeр олон байсан. Тэр бeөнeрийн дунд
а́йа са́мaн лицe, eдii са́мaн бицe, атpкaн са́мaн бицe, кунга са́мaн а́eн.
сайн бeе байсан, эр бeе байсан, эм бeе байсан, хүүхэд бeе байгаагүй.
Урладу eвeнки бeйeлдү бунeнкe бицe, ceбeки бицe, лама бицe, буркан
Урд хамниган улст чeтгeр байсан, онгон байсан, лама байсан, бурхан

бице, ердөмүнгө бөйө ацен.

байсан, эрдэмтэй хүн байгаагүй.

Би Долоод омокчи бисим. Өмүн омонгичи бисим. Өмүн дунаджичи бисим.

Би Долоод овогтой буй би. Нэг хүүтэй буй би. Нэг охинтой буй би.

Атиркачи бисим. Надаане дэулчи бисим. Абдуду пуликив. Нимерду кесункив.

Эхнэртэй буй би. Далан хоёртой буй би. Малч явдаг би. Айлаар хэсдэг би.

Моринми өминнамкив. Дээгдүби мүйи өмүнкив. Мойи алдинкив. Дээгдүби
асинкив.

Морио усладаг би. Гэртээ ус апардаг би. Мод павчдаг би. Гэртээ татдаг би.

Көмөн йүнкив. Моринми джаванкив. Емөгөлби токункив. Мордаһа нөнөнкив.

Өглөө босдог би. Морио барьдаг би. Эмээлээ тохдог би. Мордоод явдаг би.

Угушжиби өменкив. Дээгдү инкив.

Буцаад ирдэг би. Гэртээ ордог би.

Энэ өгүүлэлийг үгчлэн орчуулж, найруулгы нь үзүүлэхэд, монгол хэлнээс ондоо нь маш огцом огцом бөгөөд, хоорондоо холбоо нь гагцхүү тухайн үйл явдал дэс дэсээрээ цувран болсон байдлаар нь хэлсэн болохоор хоорондоо холбоотой нь түүгээрээ мэдэгдэхээс биш, монгол хэлнийх лүгээ ажил, урид хожид буюу зэргэцэн болсон, үргэлжилсэн зэргийн байдлыг үзүүлсэн нөхцөл үгийн дагавраар холбож нэгэн бүрэн иж болгосон - гүй амуу. Энэ тухай монгол хэл илүү нарийн бөгөөд баялаг хэлбэртэй нь ном бичгийн маш олон зуун жилийн зузаан уламжлалын дээр түүнээс бүр эртний бөгөөд ардын аман бичгийн хэлний өв уламжлал буйн ач болно.

Монгол хамниган хэлний огцом огцом бөгөөд гагцхүү угсраа угсраагаар цуврасан байдлаар х нэгэн үйл явдлын тухай үг мэдэгдэл гэж ухаатагдахаас биш, тухайн үйл явдлын урид хожид, зэргэцэл үргэлжлэл зэргийн хэлбэрийг үзүүлэн тодорхойлж, явц байдлыг нарийнаар гаргах дагавар зэргийн зүйл бараг хэрэглээгүй нь, шивэрийн -сибирийн/ханты гилиаг зэргийн угсаатны хэлний байдал найруулгатай шат үе ойролцоо санагдам. Үүнд хэцээ болгож, И.И.Мещаниновын өгүүлбэрийн гишүүн жич үгийн ай гэсэн номд хантын нэгэн үлгэрийн хэсгийг орос болгон үгчлэж орчуулсаны нь монгол болгон буулгаж, дээрхи манай хамниганы өгүүлбэрийн байдлыг монгол болгосонтой зэргэцүүлэн үзүүлбээс: Өвгөн байв.

Ганц удган мод буй. Ганц онгон мод буй. Зун байв. Нэг өдөр болов. Өөшөө алав. Загасчлахаар очив. Өөшөө орхив. Загас барив. Эрэг дээр гарав. Тогоо тавив. Гал асаав. Того өлгөв. Өвгөн ирэв. Цагаан сахалт өвгөн. Хөй, юу

хийж байна чи? гэв./Дурдсан номын 131-2 талд буй/.

Хамниган эвенки дуу:

Хамниган эвенки хэл мартагдаж буйн учир, эвенки ардын бичиг Folklore гэж⁺ бас л гээгдэхэд хурч, эдийн боловсролын талаар монголчуудтай ойртож, утга соёлын талаар үлгэр бүжиг дуу тэргүүтэн нь мартагдаж, зарим нь монгол үгээр бууж ирсэн байнам. Сурагласаар эвенки үгээр тавиад жилийн тэртээ дуулж байсан нэгийн зэрэг эвенки дуу олж тэмдэглэсэн түүнийг энд сийрүүлбээс:

Аду́ндокен селёца

Алда дөлкө көйөрбан!

Айлдүкө селёца

Абагай Лепестинка тоймогё!

Эмөгөл кадал хланкхинаран,

Еньён амен түрерөн!

Монгол болговол ийм:

Адуунаас нь шилилээ

Алд дэлтэй хээрийг!

Айлаас нь шилилээ

Авгай Лепестинка тоймогийг!

Эмээл хазаар хангиналаа,

Эжий ав нь загналаа!

гэсэн үгтэй дуу ажээ. Шүлгийн байцлыг үзвэл, эхний дөрвөн шад нэг а эгшгээр толгой холбоотой, төгсгөлийн хоёр шад нь э эгшгээр толгой холбоотой үүнийг томьёолон үзүүлбэл: А - А - А - А; Б - Б гэсэн байцалтай нь монгол шүлэгт байдаг хэлбэрийн нэгэн амуу.

+ Ардын lore гэж билиг хэмээсэн нэр бөгөөд Folklore гэдгийг орос хэлнээ "фольклор" гэж бараг хэвээр нь, гагц хуу өөрийн хэл бичгийн журамд нийцүүлэн хэрэглэвч, хоёр үгээр бүтсэн угсраа нэр тул, олон улс нийтийн тэр зарчмы нь бичгийн боловсон хэлний зөв бичих ёсноо мөн тэр зарчмы нь нэгэн адил журамласан нь монгол хэлний бичгийн боловсон хэлний зөв бичих ёс зүйд мөн нэгэн адил, олон улсын боловсролын шатнаа хүрэгсэд баримтлан журамлах нь даруй боловсролтойн гэрч нь мөнхий тул, орчин үеийн түрэг улс өөрийнхөө хэлээр халкбилгис гээ нийтийн зуршил ёс баримтлан буй зэргийн нэгэн адил, бид ардын-билиг хэмээх учиртай байна.

8.МОНГОЛ ХАМНИГАНЫ ДУНДАД ЭРТНИЙ МОНГОЛ АЯЛГУУНЫ ҮЛДЭЦТЭЙ "ХАМНИГАН АЯЛГУУ"

Ахмад насны хамниганы нэгэн хэсэг нь, орчин хавийн монголчуудаас баахан еер татлагатай аман аялгуугаар хэлэлцдэг байна. Чингээд, нутаг усны монголчууд нь тэр аман аялгуугий нь еер татлага бүхүй аялгуу гэж үзэх тул, хамнигацуул түүнээ "хамниган аялгуу" гэж нэрлэдэг байна. Гэтэл, нарийвчлан үзвээс, тэр нь хамниган аялгуу биш, хамнигацуулын аманц үлдсэн монгол аман аялгууны зүйл байнам. Түүний онцлогийг дурдвал, худам монгол бичгийн зүйлд тэмдэглэдэггүй⁺ бөгөөд Монголын нууц Товчоо, дөрвөлжин үсгийн гэрч бүхүй үгэнд төвөнгийн шүргэх гийгүүлэгч буй нь монгол хамниганы нэгэн хэсгийн "хамниган аялгуунд" үзэгдэн буй үүнээ зарим нэг аялгуунд нь тэр төвөнгийн шүргэх гийгүүлэгч нь наашлаж, хэлний угийн шүргэх х гийгүүлэгч болсон ину бас үзэгдэм. Түүнд бас овог овгоор чингэж ялгарч байгаа зүйл байх мэт санагдах үүнээ, дор жишээ болгон дурдсан зүйлдээ овгийг бас заан тэмдэглэлээ.

а. Эртний h гийгүүлэгч, угийн эхэнд h хэвээрээ буй:

Мо *مورخ* - үкер - хамниган хэлнээ: хүкер, зарим аялгуунаа хүкер, мөн хүкер гэх ину буй. Үүнд э үсгээр түүний байдал дүрс нь е-д төслүү учир, е-д тун ойртсон, уруулшин дуудах е эгшгийг э хэмээн тэмдэглэж, эс уруулшсан жинхэнэ е эгшгээс ялгасныг манай кирил үсгээр одоо монгол хэлний е эгшгийг э хэмээн тэмдэглэдгээс энэ мэтэст ялгахгүй байж болохгүй үүнд

+ Чингэж тэмдэглээгүй нь, худам монгол үсэгт гэрчлээстэй эртний тэр монгол аялгуу болбол, угийн эхний эгшгийн өмнө төвөнгийн шүргэх гийгүүлэгчгүй үгтэй аялгуу байсан болно. Тэр төвөнгийн шүргэн түрэх гийгүүлэгчийн оронд дууны хөвч хамжисхийснийг цаанаас нь гарах хийн түрэлтээр дэлбэлэн гарч, эгшгийн өмнө нэгэн зүйл төвөнгийн дэлбэлэх авиа буй болдог байсан байж магадгүй. Тийм авиа, одоо герман хэл тэргүүтэнд буйг товч дурдаж болно. Монгол хэлний эл төвөнгийн дэлбэлэх авианы тухай миний Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр, авианзүй 110, талд өгүүлсэнийг үзмүү.

хамниган хэлнээ э гэж тэмдэглэсэн зүйлийг е-д тун ойрхон, уруул хумбин дуудах е эгшиг хэмээн ялган тэмдэглэв. Орос хэлнээ кирил үсгийн э гэдгээр манай хэлний е хэмээн монголын судлалын сонгомол зохиолд тэмдэглэдэг эгшгээс нилээд өөрийг оросын эх, эхэ гэдгийн э-г орос хүн яаж дуудлагийг соносо-воос, манай одоо эх эцгийн эх гэж бичдэг эх гэгчийн э нь кирил үсгийн ёсоор нь дуудвал, оросын эх гэдэгтэй адил бөгөөд, чингэж эх гэж дуудахыг монгол хүн соносоод, эх эцгийн эх гэж байна гэж бараг танихгүй өөр эгшиг байгааг мэдэхэд амар-хаан! Монголоор бидний одоо хэлэх гэж бичээд, өгүүлэх хэлэхийн хэл гэж тааж уншдаг маань, жинхэнэ кирил үсгээр ямар дуудалгатайг кирил үсэгт орос хүн үзүүлүүт, шал өмнөө дуудах нь проо мэдэгдэн, э үсгийг, түүний жинхэнэ тэмдэглэх авианаас хаа хамаагүйгээр дуудах болж хэрэглэсэн маань царуй орос хэл өчүүхэн гадарламагц тодорхой мэдэгдэж ирнэ. Учир иймэд, хэлний шинжлэлийн зохиолд өөр хэлний аялгууг кирил үсгээр тэмдэглэхдээ, тухайлбал, хамниган аялгууг тэмдэглэхдээ, орчин үед хамниган хэлнээ э гэдэг кирил үсгийг баахан уруулшсан эгшгийн тэмдэг болгосон түүний нь даган баримтлах нь зүйтэй болно. Эс чингэвэл, оросын петух гэдгийг пэтух гэж бичээд, этгээд гэдгийн э нь пэтух гэдэгт орлог юм аа! гэж суусан - луугаа адил болно!

- мо. *уугалжа* - угулджа - хамниган хэлнээ *хугулджа* /аргали угалз/.
 мо. *оол* - оол - ооль гэдэг зэвсэг - хамниган хэлнээ *ооля*.
 мо. *үмөкей* - үмөкей - хамниган хэлнээ *хүмөкей*.
 мо. *уун* - уун - хамниган хэлнээ хоршоо үгнээ: *хуни* манан, *хуни* туман. Энэ туман гэдэг түрэг гаралтай нэр, дуудал эртний үг үсэгт монгол бичгийн дурсгалд дайралд-
 даг бөгөөд өдгөө орос хэлнээ туман гэдэг хэвээ -

рээ буй нь монгол хамниган хэлнээ һуин туман гэдэг хэлбэр эртний монгол һуин туман гэдэг хоршоо үг явж ирсэн болмой заа.

Мо. *ᠭᠡᠯᠡᠭᠦᠨᠪᠤᠯᠤᠭᠤ* - үлэгүү булугу - хамниган хэлнээ һулү' булу', орчин үеийн монгол аман хэлнээ илүү булуу гэсэн хоршоо үг амуу.

Мо. *ᠣᠳᠤᠨ* - одун - хамниган хэлнээ һодун, зарим аман аялгуунд нь хоцун, бас зарим хамниган одон хэмээмуу.

Мо. *ᠠᠯᠤᠭᠠ* - алука - хамниган һалука, зарим аялгуунаа халука.

Мо. *ᠡᠷᠡᠭᠡᠬᠡᠢ* - ерекей - хамниган һерекей гечекé.

Мо. *ᠡᠬᠡᠨ* - екин - хамниган һекин.

Мо. *ᠠᠯᠠᠭᠠᠨ* - алаган - хамниган һалакан.

Мо. *ᠠᠷᠪᠠᠨ* - арбан - хамниган һарбан, зарим аялгуунаа харван.

Мо. *ᠠᠨᠢᠰᠠᠭᠠ* - аниска - хамниган һаниска, зарим аялгуунаа ханиска, зарим аялгуунаа аниска - анитка.

б. Эртний монгол хэлний хамжсан к гийгүүлэгч хэвээрээ

хамниган аялгууны монгол үгэнд байгаа нь:

Мо. *ᠭᠡᠷᠪᠠᠨ* - катакин - хамниган Катакин. Үүнд гурван үеэр бүтсэн энэ эртний монгол овгийн нэрнээ хамниган аялгуунд аль үе дээр нь өргөлт тусч байна гэдгийг амин соносоход, гурвууланы нь нэгэн адил тэгш дуудан буй тул, тэр үе дээр нь өргөлттэй гэж хэлэхэд маш хэцүү. Адгийн -н гийгүүлэгчийг маш тод соностох хэлний урдуурхи -н гийгүүлэгчээр дуудан өгүүлэх ажээ.

Мо. *ᠴᠠᠷᠠ* - кар-а - хамниган кара.

Мо. *ᠴᠢᠯᠢ* - кили - хамниган кили. Үүнээ адгийн эгшиг маш тодорхой.

Мо. *ᠴᠠᠭᠠ* - кори - хамниган кори.

Мо. *ᠴᠢᠩᠭᠠ* - кони - хамниган кони, конил.

Мо. *ᠴᠠᠨᠠ* - кан-а - хамниган кана.

Мо. *ᠴᠤᠰᠤ* - кусу - хамниган кусу.

Мо. *ᠴᠠᠪᠤᠷ* - кабур - хамниган кабур.

Мо. *ᠴᠠᠮᠨᠢᠭᠠᠨ* - камниган - хамниган камниган.

Мо. *ᠴᠠᠷᠢᠨ* - карин - хамниган карин.

Мо. - куда - хамниган куда.

Мо. - кадум - хамниган кадум.

Мо. - кегер-е - хамниган - кейер.

Угийн дунд орсон эл хамжих гийгуулэгч к мөн хэвээрээ буй:

Мо. - бук-а - хамниган бука.

Мо. - ак-а - хамниган ака.

Мо. - акай - хамниган акай. Эмэгтэй хүнийг акай хэмээмүү.

Мо. - аку - хамниган аку: бага акуду - бага ахад, бага байхад.

Мо. - яагакику - хамниган яаку.

Мо. - джегекей - хамниган дзёке.

Мо. - сүке - хамниган сүке.

Мо. - мөке - хамниган меке, зарим аялгуунаа мөке.

Мо. - чарки - хамниган чарки. Эл чархи гэдэг нэгэн зүйл гутлын нэрэ түрэг хэлтнээ чарук гэдэг нь оросоор "кожаный" лапоть гэж орчуулдаг уг. Ухэхийг хамниган өтгөс бас "чаркиа катаку" гэж асар тоомсорлогүй утгатай зүйлд нэрлэдэг нь, ой хөвчийн гөрөөчин хун, чийгтэй модон дунд елмийгөө ороосон хиа орой тайлаад, өглөө эрт дахин өмсөн явах ангуучин хун, үнээр, тэр чаркиа үхэхдээ л дахин чийгтэй ой цотуур хэрэх хэсэхгүй, гүйцэд нэг хатаах тул, "чаркиа хатаалаа" гэж дахин чийг зуулгахгүй болсон хүнийг хэлдэг байж, насан элэгдэхийг зайлуулан хэлэх үгний нэгэн болжээ.

Мо. - укаган - хамниган укан.

Мо. - караку - хамниган караку.

Мо. - гакай - хамниган гакай.

Мо. - нокай - хамниган нокай.

Мо. - корукай - хамниган корокай, коракай.


В. Эртний монгол хэлний тэргүүн үеийн н хэвээрээ


байгаа нь:


Монгол хэл судлан шинжлэгчид, орчин үеийн монгол хэлтний аман аялгуунд эгшгийн хугарал гарсан үзэгдлийг тэмдэглэн ажсан билээ. Эл үзэгдэл Ар Монгол нутагт нэгэн жигд болж, цөм зуун хувь н эгшгийн


хугарал болон хараахан гүйцээгүй, жигдгүй явсаар ирсэн уунд, кирил үсгийн "шинэ үсгийн дүрэм" хэмээгчид тэр хугарлыг монгол, уг, төвд гаралтай үгнээ "дүрэм" болгоод, орос хэлнээс орсон үгэнд тэр дүрмээ "хүчингүй" үзсэн боловч, үнэн хэрэг дээрээ тийн хуу эгшгийн хугарал гарсан нутагт, монгол төвд уг бол, "эгшгийн хугарал" гарч, орос хэлний уг эгшиг нь "хугардаггүй" онц эрхт биш, яг л нэгэн адил хугарал үздэг: виктрола гэх мэт уг даруй пяктроол, бягтроол, бяхтороол, гермаанаас орос хэлэнд дээр нагт ороод, ойрноос орос хэлбэрээр монгол хэлэнд орж байгаа квитанция гэдгийг пятаанэ гэж хэ гэдэг хоёр гийгуулэгч, монгол хэлний үеийн тогтолцоонд байдаггүйн учир, эхний к нь оргуй хаягдаж, дараагийн в нь и эгшигтэй нийлээд монгол соносон өгүүлэгчийн чихнээ дуугуй гийгуулэгч мэт соностон өгүүлэгдэх болсон нь даруй и эгшгийн хугарлын зүйтогтоол даган кви нь ня болж "пятаанэдах" болжээ. Энэ мэт зүйл бол, монгол хэлнээ, хүн төрөлхтний бусад хүчин чадал төгөлдөр оршин буй хэлний нэгэн адил, харь үгийг хэрэглэх үес өөрийн хэл аялгууны авианзүйн хуулинд оруулдаг чадал зүй нь, ийм улсын үгийг зүйтогтоолдоо өөрөө мэдэн оруулж болно, тийм улсын үгийг аймшиггүй өөртөлж болохгүй гэсэн зүйл байдаггүйтэй нэгэн адил ёс тогтоол бүхүй ажээ.


Монгол хамниганы аман аялгуунд и эгшиг - үгийн эхний үед бараг төлөв хугараагүй хэвээрээ буй уунд хэдэн жишээ үзүүлбээс:


Мо.  - шинаг-а - хамниган шинага.


Мо.  - чирг-а - хамниган чирга.

Мо.  - сидү - хамниган шидү - шидүн.

Мо.  - синесү - хамниган шинесү.

Мо.  - чигта - хамниган чикта.

Мо.  - киджагар - хамниган киджагар, киджар, зарим аялгууна кидзар.

Мо.  - китад - хамниган китад, зарим сартуул хамниган китөд.

Монгол хэлнээ орсон төвд энэтхөг зэргийн нөрийн зүйлд мөн эхний үеийн и эгшиг нь хэвээрээ хамниган хэлнээ маш тод буй: Нима, Нингар, Мидог, Биядурия, Дивангар, Линхува, Бигармиджид, Шираб /төвд Шес-раб, монгол аман аялгуунаа Шарав, Шийрав гм./, миндаг, Мила - Миларайба гм.

Монгол хамниганы эл аялгуунаа тэргүүн бус үеийн эгшиг нь маш

тод өгүүлэгдэх байдал, монгол худам үсгээр бичсэнтэй яв цав нийлж байгаа нь, огт монгол бичиг мэдэхгүй өтгөсийн амнаа хэвээрээ буй:

Мо. *Хамур* - самур - хамниган аялгуунаа самур;

Мо. *Хамур* - памур - хамниган аялгуунаа намур;

Мо. *Хамур* - амур - хамниган аялгуунаа амур;

Мо. *Хамуланг* - амугуланг - хамниган аялгуунаа амугуланг;

Мо. *Хаму* - даку - хамниган аялгуунаа даку гм.

Зарим хамниган аялгуунд с гийгүүлэгч нь төвөнгийн шүргэх *h* болсон үзэгдэл тохиолдон буйг жишээлбэл, монгол хэлний с нь тийм аялгуунаа *h* болсон хэлбэртэй амуу:

Мо. *Илагасун* - илагасун - хамниган аялгуунаа иласун, зарим аман аялгуунаа ила*h*ун;

Мо. *Нарасун* - нарасун - хамниган аялгуунаа нарасун, зарим аялгуунаа нара*h*ун;

Мо. *Кусун* - кусун - хамниган аялгуунаа кусун, зарим аялгуунаа ку*h*ун, ху*h*ун;

Мо. *Төмүсун* - төмүсун - хамниган аялгуунаа төмүсун, зарим аялгуунаа төми*h*ун;

Мо. *Үндүсун* - үндүсун - хамниган үндүсун, зарим аялгуунаа үндү*h*ун гм бөгөөд голцуу Өзөөн овогтон иймэс аялгуутай.

г.Эртний монгол хэлний эгшиг + гийгүүлэгч + эгшиг нь монгол үгээр хэлэлцэгч хамниган аялгуунаа буй:

Мо. *Береге* - береге - хамниган Намиад аялгуунаа береге;

Мо. *Укурга* - укурга - хамниган аялгуунаа укурга;

Мо. *Кураган* - кураган - хамниган аялгуунаа кураган; курикан;

Мо. *Гөрүтесун* - гөрүтесун - хамниган аялгуунаа гөрүтесун;

Мо. *Адогон* - адогон - хамниган - адогон;

Мо. *Имаган* - имаган - хамниган имаган;

Мо. *Дилога* - джилуг-а - хамниган аялгуунаа дилога;

Мо. *Гегуу* - гегуу - хамниган аялгуунаа гегуу;

Мо. *Унакан* - унаг-а - хамниган аялгуунаа унакан, нунгакан;

Мо. *Төмөгөн* - төмөгөн - хамниган аялгуунаа төмөгөн, тэмөгөн;

Мо. *Өмөгөл* - өмөгөл - хамниган аялгуунаа өмөгөл;

Мо. *Адогусун* - адогусун - хамниган зарим аялгуунаа адогон гэдгийг

гээ адугусун гэж адугусуни нанда хэмээн адууны шир
гэхийг тийн хуу нэрлэдэг байна.

д.Эртний монгол хэлний тэргүүн бус үеийн эгшиг нь
маш тод хэвээрээ байгаа нь:

Орчин үеийн Ар монгол аман аялгуунаа тэргүүн бус үеийн эгшиг нь огцомдсон тухай монгол хэл судлагч олон эрдэмтэн цөм судлан тэмдэглэж, орос хэлнээ түүнийг "неясный гласный" гэж бичсэнийг тэр "неясный" гэдэг орос үгийн утганд хэд хэдэн салаа буйг зарим хүмүүс, "балархай" гэж ухааран орчуулж, "балархай эгшиг" гэж бага дунд сургуулийн хэлзүйн бичигт "махчлан" хэрэглэж буй үүнд, орос хэлнээ "неясный" гэж 1-д нүдээр үзэхэд бүдэг, тодгүй үзэгдэхийг нэрлэх нэгэн утга буй. Монголоор алсын юмыг "балархай" үзэгдэж байна гэдэггүй, тодгүй, бүдэг гэдэг амуу. Бас нүдээр үзэх юманд элэгдэх буюу нухагдаж арчигдах зэргийн шалтгаанаас тодгүй болохыг орос хэлнээ "неясный" гэдэг хоёрдугаар утга болно. Тиймийг монголоор даруй "балархай" гэж баларсан, элэгдсэн зэрэг учраас тодрон ялгарч харагдахгүй юмыг балархай гэнэ: балархай үсэг, балархай тамга гэх мэт. Холоос ч харсан, ойртуулаад ч харсан, томруулдаг шилээр ч харсан, будаг бэх нь сайн гараагүй, сийлсэн зорсон нь элэгдэн идэгдэж, үзэхэд тодгүй юмыг балархай гэхээс уг нь балархай бус юмыг "холын уул балархай" гэж хэлдэг журам, монгол хэлний сэтгэхүйд үгүй билээ. Орос хэлнээ "неясный" гэж бас сэтгэл санаанд төрөх зүйлийг тийм гэж орж өхгүй битүүлэг байдал бүхүйг нэрлэх гуравдугаар утга буй. Миний сэтгэлд "балархай" гэж монгол хэлнээ хэлдэг ёсгүй, өөр үгээр тэр гуравдугаар утгыг нэвтрүүлэх болно: сэтгэлд нэг битүүхэн юм ороод байх шиг, тийм гэхийн юмгүй мөртөө, нэг л юм буур туур сэтгэлд төрөөд байх шиг гэх зэргээр хэлэхээс биш, уг нь тов тоц байгаад "балархай" болсон гэж болохгүй юмын нэр болно. Нясный гэдгийн дөрвөдүгээр утга нь, чихнээ соносох чимээ авианы зүйлд сайн дуулдаж өхгүй байдлыг нэрлэдэг нь монголоор "балархай дуулна" гэж болохгүй зүйл; зурсан юм балархай болж болно, юмны дуу чимээг яаж арчиж хусаж, зүлгэж баллаж болдог юм бэ? гэж монгол хэлний сэтгэхүйг алдаагүй хүн, дуу чимээг баллаж, балархай болгох гэдэг орчуулагчийн орчуулгыг гайхах нь зүй ёсны бөгөөд юм боддог хүний шинж. Орос хэлнээ неясный гэдгийн тавдугаар утга нь:

томруунгүй, тодорхой томруунгүй гэж үг найруулга, үг хэллэгийн зүйлд нэгэн дутэгдлыг нэрлэх утга бий. Хэлний шинжлэлд орох хэлнээ эл нэ-ясный гэдэг нэрийг хэрэглэхдээ гагц хүү өгүүлэхүйн эрхтний тухайн ажиллагаанаас өгүүлэх нь огцом гүвд болсон байдлыг заасан утгаар хэрэглэдгийг нүдэнд сайн харагдаж өхгүй, элэгдэж балархай болсон гэдэг юм гэж ухааран орчуулснаар одоо "балархай эгшиг" гэж хэлний шинжлэлийн ямар утгатай байгааг огт бодолгүй хэрэглэдэг дулимхан орчуулгаар шал буруу ухааралт төрүүлжээ.

Энэ дулим орчуулгаар "балархай" гэж огт учры нь таниагүй буруу орчуулсан нэрийн үнэн хүү хэлний шинжлэлийн утгаар тодгүй, огцом хэмээн ухаарах эгшгийн тухай өгүүлэх үүнд, монгол хамниганы эртний буюу дундад эртний монгол аялгуугаар өгүүлэн буй "хамниган" аялгуунд нь тэргүүн бус үеийн эгшиг нь орчин үеийн монгол аялгууны олонхид нилээд огцомдож, тэр учраас зарим аман аялгуунд нилээд тодгүй болж, чухам ямар эгшиг байгаа нь, гол төлөв тэргүүн үеийн эгшгийн байдалтай төслүү болж ирсэн нь, өгүүлэхүйн эрхтний ажиллагааны байдлаас болсон хэрэг аваас, монгол хамниганы "хамниган" монгол аялгуунаа тэдгээр тодгүй огцом эгшиг даруй маш тодхон өгүүлэгдэх бөгөөд, эл аялгуутан хамниган, тэр монгол аялгууг нутаг усны монголчуудын бичигтэн үсэгтнээс сурсан нь хэрхивч бус, эцэг өвгөдөөсөө уламжлан сурч ирсэн хэрэг. Тэд нь бас олон үе дамжсан монгол аялгууг залгамжлаж ирсэн бөгөөд анх дундад эртний аялгуут монголчуудаас соносон сурсан тэр өгүүлэх байлал нь хадгалагдсаар ирсэн хэрэг болно. Иймэд, монгол бичгийн хэл болон аман аялгууны судлал болон түүхнээ орчин үеийн эл дундад эртний монгол хэл аялгууны онцлогийг хадгалсаар ирээд түүнээ "хамниган хэл" гэж нутаг усныхаа одооны монгол ах дүүгээс ялгаатайгаар нь нэрлэж байгаа аялгуу нь тун сонин зүйл болно.

Эл "хамниган" монгол аялгуунаа тэргүүн бус үеийн эгшгийн байлал нь, монгол худам үсгийн зөвбичихзүйд гэрчлээстэй хэлбэрлүгээ ширхгийн зөрөөгүй нийлдэг нь бас сонин гэрч баримт бөгөөд монгол худам үсгийн зөвбичихзүй, эртний болон дундад эртний, мөн орчин үеийн монгол хэл аялгуу судлах эрдэмтэнд сонин гаргалт дүгнэлт хийхэд нь чухал тулгар хэрэглэгдэхүүн болно.

Учир ниймийн тул, энд эл тэргүүн бус үеийн эгшгийн зүйл, монгол

хамниганы "хамниган хэл" гэдэгт нь ямар байгаагийн хэдэн жишээ дурд-
ваас:

- Мо. *ᠳᠠᠯᠤ* -далу - хамниган аялгуунаа далу;
мо. *ᠳᠠᠬᠤ* -даку - хамниган аялгуунаа даку;
мо. *ᠰᠠᠮᠤᠷ* -самур - хамниган аялгуунаа самур;
мо. *ᠠᠮᠤᠷ* -амур - хамниган аялгуунаа амур;
мо. *ᠣᠨᠢᠰᠤᠨ* -онисун - хамниган аялгуунаа онису - онисун;
мо. *ᠳᠠᠪᠴᠢᠷ* -дабкур - хамниган аялгуунаа дабкур;
мо. *ᠱᠠᠩᠭᠤ* -шангу - хамниган аялгуунаа шангу;
мо. *ᠴᠠᠳᠴᠤᠮᠠᠯ* -кадкумал - хамниган аялгуунаа кадкумал - кат-
кумал;
мо. *ᠳᠡᠭᠡᠪᠦᠷ* -дөгөбүр - хамниган аялгуунаа - дээбүр,дэгэлбүр;
мо. *ᠡᠷᠦᠬᠡ* -еруке - хамниган аялгуунаа - эрүке /гагц хүү ут-
га нь монгол хэлний үүд гэсэнтэй дүймөй.Үүний учир
нь бас нэн дээр эртний үед нүхэн гэр:ерү+ке гэж га-
зарт өрж ухсан юм гэдэн үес, тэр өрж ухсан нүхээр
нь доошоо хүн гишгүүртэй мөдөөр дотогшоо орж, до-
роос нь голомтонд нь байгаа утаа дээшээ гардаг
байсан үеийн утга санаа явж байгаа хэрэг.Орчин үе-
ийн монгол хэлнээ өрх гэж газрын өрх, усны өрх гэ-
лэгт тэр эртний "нүх" гэсний утга нь өдгөө хүртэл
уламжилж ирсэн амуу. Нүхэн гэрээс гарсан монгол-
чууд исгий гэрийнхээ дээд орой дээрхийг өрх / гэж,
гэрээсээ гардаг сүвийг үүд гэдэг божж ирсэн аваас,
эрт дээр монгол хэлнээс эруке гэж авсан хамниган,
нүхэн гэрийн өрхийн утаа гардаг, хүн ордог сүвийн
утгаар хэрэглэсээр иржээ.
мо. *ᠬᠣᠪᠪᠠᠭ* -колбаг-а - хамниган аялгуунаа холбага /бөөгийн
холбого гэдэг төмөр/;
мо. *ᠠᠬᠤᠷ* -акур - хамниган аялгуунаа акур;
мо. *ᠨᠠᠮᠤᠭ* -намуг - хамниган аялгуунаа намук;
мо. *ᠴᠠᠪᠲᠠᠰᠤᠨ* -кабтасун - хамниган аялгуунаа кабтасун, кабтасу;
мо. *ᠠᠯᠤᠰ* -алус - хамниган аялгуунаа - алус, алус, кола, алус
кату;

- мо. *кола* - кола - хамниган аялгуунаа - кола;
- мо. *сула* - сула - хамниган аялгуунаа - сула;
- мо. *паруга* - паруга - хамниган аялгуунаа - паруга, зарим аялгуунаа парога;
- мо. *таму* - таму - хамниган аялгуунаа таму;
- мо. *табун* - табун - хамниган аялгуунаа - табун;
- мо. *яабуган* - яабуган - хамниган аялгуунаа яабуган. Үүнээ сүүлийн толь бичиг мэтэст манжийн яафахан гэдгийг цууриан монгол хулам үсгээр гэж бичих болсон боловч, 1389 оны Хуа-йи йи йүй бичигт яабухан, хулсан үзгийн монгол сударт яабуган гэж яабу - гэсэн үндсэнээс гадн хоёр дагавар залган бүтсэн байдлыг мэдэх байсан аваас, сүүлийн тольчингууд, чингэж задлан шинжиж чадахгүй болоод манжийн бичиг үсэгт юул байвал, түүнийг цуурилах болсон ажээ.
- мо. *тутум* - тутум - хамниган аялгуунаа - тутум. Одоо хэвлэлд т - л хоёрыг ялгахгүй бичин будлиж, тутум гэдгийг у-гийн сүүлээр -а бичнэ гэж болзсон ёсоор аваас, тутам байх ёстой атал, утга гарал, үндэс учры нь бодол мэдэлгүй, дутахын дутагддагтай холин хутгаж, дутам гэж бичин буй зүйл олон үзэгдэх боловч, монгол хэлний зөвбичихзүй бий болж, монгол хэлний шинжлэлийн орчин үеийн мэдэц нь монгол хэлнээ бууж ирэн түгэх үес засрах буй заа.
- мо. *насун* - насун - хамниган аялгуунаа насун, насун;
- мо. *чидкур* - чидкур - хамниган аялгуунаа чидкур;
- мо. *эбул* - эбул - хамниган аялгуунаа эбул, эбул;
- мо. *конгтур* - конгтур - хамниган аялгуунаа конгтур;
- мо. *кабур* - кабур - хамниган аялгуунаа кабур ги.

9. "ХАМНИГАН АЯЛГУУ" ГЭДГИЙН ЯРИАНЫ

ЖИШЭЭНЭЭС:

Хэнтийн Өзөн:

Тани нэрэ кэн гэдэг бэ? Та ухури мика идэхү? Идэхү болбала би чинаку асан. Бидани хүнэсэ этэгэд кэлэте гэдэк. Камниган бида эртэ идзагүраса Калка монггол нитукту сүсар ирэсэн гэджи эбүгэд дэдүс кэлэдэк асан. Камниган бида монголоса тасурасан гэхү. Бида монголоса тасурасан улус акулда. Түнэсэ цаши би сураджи үдээгүй. /1956 он. 77-тай Сүрэн./

Өзөн - камнигани омак. Долан омагин камниган би. Тэрэ тэрэ гэджи нарин келеджи мэдэхү үгэ би. Мэдэхү акула келэхү асан би. Улигэр мэдэхү үгэ би. Марта би. Уканду йума оруку үгэ, насунду ларугда би. Дзалу байкуда кэлэлцэдэк асан би. Ода йамарчи йума мэдэхү үгэй, мартаба би. Мэдэхү йума байкула йарику асан би.

- Күкэ, сакара йасан би чи? Энэ илөндү сакар дэокикулда. /1956 он. Жаргал өвгөн./

Хэнтийн Катакин:

Манэ Катакин омак - Галдан Бошуктын босулганду коешан очисан геджи эбүгэд келелцедек асан. Уриду дзүгесе йеке нүдөл дээдөл кисен гедег асан. Мини багаду йеке йума келелцедег асан. Коена керектэ болку геджи санагүй, мартаджи оркиба би. Кен медебе? /1961 он. 79-той Катакин Дулма./

Цепен кан аемагин корин наеман изасак кошу, табун джил болд чулган чуладаг асанджи. Керүлүн Барс котаса дзүкен уриду тугин джиса геджи аемагин джиса өцөгетэ койула нэдүмдүни очивжи сур карбудак асан би. Аемагин да джанжун барун уриду, дзүн тэ джандун будак асан.

Джанджун туг кискөджи, гурбан таласа татаджи уйдак асан. Аемагин йеке нояд, тере ургүлджи куралтае, конин дзүму идэтэ джисаду Чинггис богд йи такиджи, да ниге, джанджун ниге, цепен уанг ниге такина. Далае уанг ниге такина. Санг бөсе ниге такина. Аемагин уанг ниге такина.

Чинггис - шира торган цэлтэ, килинг малагаэтае, тоерад арбан койар батур - талын дзурга дзурга. Корин йесун онду үгэ киджи оркисан. Койар катабчинду койар кун цөцүлгэд дэоксоджи, нигени табакту шира йумбу, нигедуни цаган йумбу барисан койар кун байдаг асан. Нипуген шикү тиму койар шибар кун асан. Баса мюрини шинан дэрэс бариад дэоксосан, джида сэлэмэ бариад дэоксосан кун байдак асан. Шала догур онисута. Кун йлбукуду көдөлджи, йөкө сүртэй байдак асан. Турганлани дзуракта. Йеман талата кулусун бортогата Гесэрин шикшүр төлгэ байдак асан.

Гесэр Чинггис гэджи колбата үгэ баедак асан. Уктамийн кейдин Доччин кубилган Ширгуца кани такидак асан. Гурбан нур гэджи уриду байгагэ асан.

Цөцөн кан аемагин чулган цэун чулапак асан. Ниге йөкө бөс гэр, урту сургак унитэ тиму гэр баридак асан. Дербэн таладан дербэн сэрета, голдан ганджиршик йумата. Чулгани дерак исуги джиса дадак асан.

Арбан дзургатадан абутаган очад 19 онаджи сурту түрүлсэн била би. Дайчинг уангин өрнику мерген айлтагуйн алдар онасан била. Насуйду курэга күкөди өлүг барагаар шагнадак асан. Насуйду курэсэн кун конгур дээрде мориар шагнадак асан. Шанг абкуду минн кормеган бари! гэджи кормөду минн киджи өкчи багсан. Катакин Лувсан, 30 настай. 1963 он.

Хэнтийн Баахашил:

Би Баахашил омуктае би. Камниган кэлэ гэджи минн энэ кэдөджи баёга кэлэ лэ камниган кэлэ гэджи бодокчи би. Бага акуду көкшин абун кэлэ мэдөкү үгөйдэ гайкадаг асан би. Тэрэ ни кучин камниган эвэнки кэлэ гэгчил баелжил дэ, ода бодокуду минн. Ода коету уйин багачул, минн кэлэ мэдөккүе болджи ирбэ.

Минн мэдөкү камниган кэлэр уни, кана, эбулджен, кабурджен, дзусаланг, намурджен, темё, кони, үкэр, нман гэджи кэлэлцэдэг бида. Шиду, чики, аву, эджи гэджи гэдэг бида. Ай читкур, тэрэ мани камниган кэлэ биши, монггал кэлэ болдак баёнагу? Бүйлэсу, моносу, улнэсу, кусу гэджи кэлэлцэдэг мань камниган кэлэгү, баса монггал кэлэ болджи баёнагу? Байан кол гэджи камниган кэлэ болку аби? Монггалар гол, камниганар кол гэд

дэг агу гэджи бододжи йабудак би.

Байан кан гэдэг ула койар нэрэтá гэджи дулабагú та? Байан каны ару таладу Бурканту гэдэг дэун коеш^{нá} карасан ула би. Коету талар ни Киркун, уриду талар ни Балджи, дэун талар ни Бүкун Киркун койар уру-сун нилэсэн ула. Нигэ нэрэни Байан кан, ару таласа Бурканту гэдэг нэрэтá нигэлэ ула. Дэун коету таладан күн йабуку эркэ үгэй адка чилу болосан ула. Чинггис уриду пагту тэндэ коргададжи йабусан гэджи эбүгэд кэлэлцэдэк асан. Тэрэ йамар тукайду коргададжи йабусан кэрэк бэ?

Эбүгэ эцэгйн камниган кэлэ би мэдэку үгэй би. Сананду „олочи“ гэджи ола боеток гэдэг гутули нэрэлэдэг асан. Цаегá „джепкел“ гэдэг мэтү санагдана. Чарки гэджи бесөр үдэджи кидэг гутул ангда саен гэджи кэрэглэдэк асан. Моринду токудак эмэгэл ни оданы эмэгэлэс томо байсан агу гэджи санайду ораджи баена. /Бакашил омогтой Түвдэн, нас 90, 1963 он/.

Хэнтийн Сартуул:

Ука саентае, насутаела улуд йекэ йума мэдэку, йарику асанда. Ми-ни эджин эджин эджи – гурбатки эджи бөрилэкүдэн лэ „калалми топкел“ гэджи того табц; цае йелекел гэджи цай удала; качикан гонгорад гэджи нокае купад; дэкэл гэджи уджиг цэрлэкүдэн кэлэдэк асан. Дзака дзукас сананду ораджи баегани энэ баена. Бага акуда инеджи, йамар кэлэ би гэджи сониркадак асан би.

Камниганар гене гэджи ниге, йарко гэджи койар, багур гэджи гурба, бөдөр гэджи дөрбэ, бута гэджи табу, гадзур гэджи дзурга, ладу гэджи цола, манае гэджи наема, сүйе гэджи йису, бар гэджи арба гэджи толадак асан. Албани монггол күни цэргэдү тэгэджи кэлэлцэдэк асан. Герүгесу арийатани мика арасуни алба тушакуду энэ то кэрэклэджи, кэн кэдүн герүгесу ангнаку тукайду эбүгэд ингэджи толаджи судак асан. /75 настай Дулмажав эмгэн. Сартуул овогтой. 1963 он./

Хэнтэйн Бакшинар:

Бурканту гэдэк уланду күчин булаши олац би. Уктан нигэ ула койар нэрэтá, нигэ орай ни Байан кан, нигэ орай ни Бурканту гэдэк нэрэтá. Дэрэ үйедү йарилцакуду эбүгэд, Буркантуду кори гучин мори уйаку гадзартá, булактá, чулугар кашисан гадзартá, эртэни такилгатá гадзар гэдэ

дэк асан.

Би арбан кэдуйтадэн йабуджи баесан би. Өксүсэр гаркуду отак кидек булак усута талба гадзарт. Кучид эбүгэд Чинггисин баеджи баесан гадзар. Дзугдажи йабад ганцаран суджи байсан гадзар ни йума гаджи кэлэлцэдэк асан. Ухтумин кидэсэ джил бүри тахидак асан. Чинггисин дзакисан дзакиата йекэ такилгата ула гаджи минн багаду эбүгэд кэлэлцэдэк асан.

Баса Будан кани Кипца кан гаджи эбүгэ эцэгин үйедү нэрэлэдэк асан. Одани дзалу үйин күн барук мэдэка байку да.

Буркантин ора кабиду кучин булаши би. Тэрэ йамар улусин булаши гекчи бэ? /Бакшинар овогтой Цэрин. 63-тай. 1963 он./

Хэнтэйн Жалайр Өзөөн:

Танар кэлэни шинджилгегер йабуджи баега улуд йум би? Минн кху цэриктэ йаба. Минн амидуйду цэригэсэ ирөкү болоса гаджи удки дзуркинэсэ күсэджи санаджи йабапак би. Энэ кхугин нирун дэрэ йу бэ? Шибунн басу нналдуба, шулму чинн 1 кхүкэ, энэ чилугар кусаджи орки. Өтүлкүдү кхун аеубтур мартамкай болдок йум баена. Онису мэдэдэкасан би. Мартаджи оркиба би./Жалайр Өзөөний Чимэд эмгэн. 1963 он. 7 сар./

Хэнтэйн Улиангай:

Шадыгаа шахинад, күн иреке гедьн баеһан йум, Төгедьн келедьн баена. Өнгедьн келедьн баена ... гедьил йариһан да. Шира шибо чинн му дугарти баена гедексанлада. Олан адьилтын дарго мань танику йумсан. Ньирү, кел гар йеке өбүддек. Шилдыку санатаесан бида. Оран делки, оба буркан минн кара? /Улиангай Цэрэндорж./

Хэнтэйн Хангид:

Албани неренде обагиг керөглөкөгүй боласар уласанг. Төрөл обара күкенэ уриду кургөдек баесанг. Күгесикге төрөл обара таниджимөдөдек асанг /КХангид Цойжил. 1963 он./

Дорнодын Кэбцэнүүд: Жаргал

Кунг көкширөкүдө керэктэчи йум үгүй боло. Укан му боло. Укан нэгэ орона нэгэ карана. Йакинчи аргагүй. Камниган кэлэрэ кэлэлцөкү

кунгуй, оелгакугуй боло. Би чиги мартаджи байнал би. Көкү манан дотор
йабаналца укән чи. Угакан гэджи курү гэсэн үгэ. Али курүг мартаби. Ку-
чи йэкэтэ көкэ мөнгөн тэнггери ! Өтөлкү гэджи ймэл болдок йум бай-
нада. /Дорнодын Көбцөнүд Жаргал. 1983 он./

Дорнодын Баягийд:

Тани нэрэ кэнг гэдэк бэ? Та үкэри мика идэкү? Идэкү болбала
би чинаку асанг. Бидани күнэсэ этэгэд кэлэтэ гэдэк. Камниганг бида эр-
тэ идзүраса Калка монгол тутукту сусар ирэсэнг гэджи эбүгэд дэлүс
кэлэдэк асанг.

Улигэр-пэцэнг үгэ мэдэккүй би. Күчид, кунг хэкигэ, дэл дзаката
гэлцэдэк асанг. Кунг болку багаса, күлүг болку унаганаса гэдэк асанг.
Опису гэджи бида багада кэлэлцэдэк асанг.

Тэнггэринэсэ тэлэтэ,

Төпкэр модунг курета,

Гадзараса галата,

Ганца модунг курета.

Тэрэ бегинг кэнгэргэ.

Котани конгкор,

Куцани мөргөдөк

Тэрэ ор нидүр койар.

Сөр үгүй тэмэ

Сэлэнгэ давава.

Тэрэ дзам гэчи.

Урү үгүй тэмэ

Өвөсө барава.

Тэрэ түймэр гэчи.

Гери койна

Гэдүнг годунг,

Усу часу кайанг кайанг,

Урак тарки идэнг,

Гэдэргү урү

Унанг унанг.

Тэрэ исэги көкү.

/Дорнодын Баягийд эмгэн Сүрэн. 1947 он./

Энэ товч тэмдэглэлд яг нутгийн монгол аялгуутай бараг адил болсон хэл аялгуутай хамнигацуулын үгнээс оруулаагүй, гагц хуу "хамниган" хэл гэж боддог бөгөөд үнэндээ дундад эртний монгол хэл аялгууны байдлаас сонин зүйл агуулан хадгалсан хэл аялгууны зүйлээс тэмдэглэж жишээ болголоо. Үүнийг ажиг үзэхэд, бас дотроо ялгавартай аман аялгуу байгаа шинжтэй бөгөөд нэг заримд нь уугал хамниган хэл аялгууны байдал, дж гэдэг хамжин шүргэх гийгүүлэгчийг тагнайшсан хамжихды гийгүүлэгчээр луудан, шаадьгаа, гедьн хөдөдн гэх мэтэст үзэгдэн буйгаас ил байна.

Өтгөс хамниганаас асуухад дөчөөд тавиад жилийн өмнө эвенки хамниган хэлээ мэдэгчид нилээд байсан байна. Бас "хамниган" гэдэг эртний монгол хэлний аялгуугаар хэлэлцэгсдийн дунд үлгэр тууль хэлдэг хуурчид хүн ч байж, үлгэрийн зүйлд соносогчид нь тогтмол тогтмол газар бүгдээрээ түрдэг түлэлэгтэй зүйл ч байсан байна. Одоо тэр түрэлгийн зүйлийг мэддэг хүн өтгөсийн дунд бий боловч, үлгэрийн нь хуурчид хэлж чадах хүн үгүй болжээ.

Аман зохиолын зүйлд эвенки хэлээрээ ярьдаг зүйл бараг байхгүй болж одсон боловч, "хамниган" гэдэг эртний монгол аялгуугаар явган үлгэр домог, бөө удганы тухай хэлэлцдэг зүйл мэр сэр байж, мартагдан орхигдохын шинж оржээ. Тийм зүйлийг мэддэг нь өндөр настан өвгөд эмгэцийн төдий л үлдсэн бөгөөд ховорхон болжээ.

х х х

Энэ дэвтрийг бичиж дуустал, хамниган хэлний тухай бичсэн хошоод өгүүлэл олж үзсэн тул, уг сэдэвт холбогдолтойн учир хоёр нэгэн үг хэлсүгэй.

Утга судлалын ухааны дэд эрдэмтэн Л.Мишинг, "Йройские хамниганы" гэдэг өгүүлэл оросоор бичиж, манай Улсын их сургуулийн Эрдэм шинжилгээний сонсгол д.12-т нийтлэсэн нь, Ереөгийн хамниганы хэлнээ уугал хамниган хэлнээс юу үлдсэнийг сурагдан сурвалжлаж,урдах эрдэмтэн, тэднийг хэлээ мартсан гэж ажсаныг давхар нутгаад, ганц нэг үг хэлэлцгийн зүйл үлдсэний нь олж тэмдэглэсэн сонин өгүүлэл бичжээ. Жишээ нь эр хүнийг "ая хогноори", лам хувраг хүнийг "ая фагдаари", эм хүнийг "эрүү хогноори" гэх зэргээр нэрлэдэг байсныг тэмдэглэжээ. "Ая" гэдэг нь хамниганаар "сайн" гэсэн үг. "Хогноори" гэдэг нь солоон хам-

ниганы "хонгнори", Сэцэн хааны хамниганы "коннорин", Баргужины хамниганы "конгномо" гэдэг "хар" гэсэн үг. Тийн хуу, "ая когноори" гэж эр хүнийг "сайн хар" /хүн/, эм хүнийг "муу хар" гэж дээр нагт нэрлэж байсан байнам. Үүнд "эруу" гэдэг үг - "муу" гэсэн үг болно. Лам хүнийг "ая фагдаари" гэж бас "сайн" юмны тоонд оруулан нэрлэж байсан нь, өвгөн хутагтийн үед анх шавь отог нь болж байх үеэ шарын шарын хамниган лунд нэвтэрч, хувраг хүнийг "фагдаари" гэж нэрлэдэг болсон нь, монгол хамниганд зуун зүгийн манж хэл соёлын нөлөөтэй солоон эвенки хэлнээс ерөөгийн хамниган хэлнээ орж ирсэн нэр болцом заа. Чингээд эдгээр Мишигийн олж тэмдэглэсэн хэдэн үлдэн үг хэдэлгийн зүйл, ХУШ зууны үед Намнад Пөөншихи овогтон Брөөд байгааг орос шинжээчний бичигт тодорхойлон буйг давтан магадласан нь Өндөр гэгдэн Занабаза - рын үед жинхэнэ хамниган үгээрээ хэлэлцэж, хамниганд байгаагүй шарын шарын лам хуврагийн тухай ч хамниган-манж гаралтай нэр хэрэг - лэж, зуун зүгийн хамнигантай харилцаа хэлнээ байсны сонин гэрч баримт олсон байна.

Шарлан Ходооц нутгийн хамниганы одоогийн аялгуунд арьс - арас, муу - тай, унь - уния гэх зэргийн ялгаа буйг цухас дурдсан нь, хамниганы аялгууны онцлог биш, тухайн нутгийн монголчуудын аялгуунд тэдгээр хамниганы монгол хэлжиж байх үед байсан ялгаарын гэрч тул, монгол аялгууны түүхнээ сонин үзэгдэл гэж үзэх нь зүйтэй. Булган Хөвсгөлд одоо ч үнийг уния гэдэг аман аялгуу буй билээ.

Мишиг, "...ходотны быдл подданными отока в хошуне Батор ван и шарланцы шабийского отока" гэж бичсэн нь, уг ёсондоо "ходотны составляли оток в хошуне Батор вана а шарланцы шабинский оток ветомаста Великих Шаби үргинского хутукты" гэж монголын тухай орос утга зохиолд хэдийн тогтсон нэрийн зүйлийг нэрэглэн бичвээс дээр байжээ. "Подданные отока" гэхлээр "подданные князя, подданные хана" гэсэн ажил, "оток" гэдгийг "князь, хан" гэсэнтэй нэгэн зэргэмжийн "эзэн ноён" гэсэн нэрийн зүйл болж, хамниганыг захирдаг эзэн нь "оток" байсан гэсэн ухааралтанд орос хэлний найруулгын ёсоор хүргэх үг болгохдоо гэдэгд орлуулах юм болжээ.

Орос бичиг зохиолд их дээрээс ойрадын Галтан Бошогтыг "Галтан Бошокту" гэж өдий төдий олон ном зохиол, нэвтэрхий товч бичиг тэргүү-

тэнд орсон атал, "Галдан Бошгот", чингэсний улмаас "сражался с Галдан Бошготу" гэхийг "сражался с Галдан бошготом" гэхэд хүрсэн нь, собака гэдгийг "собак" гэж бичээд, чингэсний улмаас "собаком" гэж бичсэнтэй адил зүйл болж, тэр нь, эгшгээр төгссөн нэрийн зүйлд эгшгийг хасан бичдэг манай "усгийн дүрэм" туссан тусгал болно: эм+нэ+л+гэ гэдэг мэтийн -гэ цагаарыг зарим үгнээ -г болгож бичдэг улмаас -га, -ге, -го, -гө дөрвөн хувицбарт нэгэн цагаарыг -г гэж гийгуулэгчээр төгссөн бөгөөд шал өмнөө утга бүхүй цагавартай нэгэн хэсэгт адил болгож, -га цагаараас бусад түүний -э, -ө, -э эгшгээр төгссөн хэлбэрийн нь -г-тэй адил болгочихсон улмаас таса+г, хэсэ+г, зориг+г, хориг+г гэх мэттэй ижил болгосон учраас эм+нэ+л+гэ+н+д, хэлэ+л+гэ+н+д гэх мэтийг тасагт, хэсэгт гэсний адил эмнэсэгт, хэллэгт болгоход хүргсэнтэй адил үзэгдэл гарчээ. Бошог гэж зарлиг, виваагирин, иш гасан, утгатай нэрийг үүнээ бошхо - бошго гэдэг хошуу тамгын газар буюу сумын захиргааны урдын цэргийн нэгэн тушаалтай хутгасан байнам. Гэтэл, монгол-европ толь бичиг бүхэнд бошог - бошхо - бошго гэдгийг орчуулахлаа ялгаж, бошхо - бошгыг Лессиягийн монгол-англи толинд ^{Jaša Darg} "капрал-
^{Урууч}сервант" гэж орчуулсан байна. Монгол товч тайлбарт бас бошог - бошхо - бошгын ялгааг тодорхой гаргасан зүйл бий.⁺

Мишгийн өгүүлэлийг үзвэл, Ерөөгийн өгтөс хамниганаас хуучин домог үг, хамниганы хуучин зан заншил мэтийн тухай тэмдэглэл хийх олоохон дээр болмоор бололтой бөгөөд чингэж тэмдэглэвэл шинжлэх эрдэмтэнд сонин зүйл байхыг нээн үзүүлсэн байна. Үүнд Галдан бошогтын үеийн явдлаас өгтөс хамниганы аман уламжлалаар юу манай үе хүртэл залгамжилж ирсэнийг хөөн суралжилбал, мэр сэр юм гарах шинжтэй байнам.

Монголч Н.Поппе хамниган хэлэнд орсон эртний монгол хэлэн үгийн тухай "On some ancient mongolian loan-words in Tungus" гэдэг өгүүлэл Central Asiatic Journal сэтгүүлийн IX.ботийн д.3-д 1908онд нийтлүүлсэн нь, эртний монгол хэлнээ хоёр эгшгийн дунд Г гийгуулэгч

+ Mongolian-English Dictionary compiled by Mattai Halted, John Gombojab Hangin, Serge Kassatkin and Ferdinand D.Lessing, University of California Press, Berkeley and Los Angeles 1960, 122. тал. Я.Цэвэл, Монгол үгийн товч тайлбар толь, Улаанбаатар, 1966, 96.талд үзмүү.

байсан нь хамниган хэлнээ орсон монгол үгнээ үлдсэн баримт: адуут
адуГун, бэрээг бэрэгэ; н эгшигийн өмнө т - д байсан үзэгдэл хамниган
хэлнээ орсон эртний монгол үгнээ буйг: гучин гэдгийг эртний хэлбэрээр
гуТин, азаргыг адирга; ич тэргүүн бус үенйн эгшиг маш тод хэвээрээ
буй: амар гэдгийг амУр, дарга гэдгийг дарУга; тохом гэдгийг тохУм
гэх мөтийн үзэгдлийг судлан бичсэн нь, манай хамниганы нэгэн хэсэг
өтгөсийн эртний монгол хэлний аялгуу хадгалах буй зүйлтэй яг нийцэх
үзэгдлийг хамниган нийтийн хэлнээ монгол үг орсон баримтаас ажиг шин-
жиж бичсэн байна.

Дотоод гадаадын эрдэмтнээс ийн хуу монгол болон хамниган-манж
хэлний судлал шинжлэлийн зүйлд шинэ зүйл нэмэрдэг орж буйг дурдан,
миний энэ зүйл, бас далайд дусаах гэгч нь болоосой хэмээн төгсөсүгэй.

годоли, годули	- сум, годли
горо	- горо
геругэсун	- гереес
гудигэ	- гүзээ
гудигэлдигене	- гүзээлэгэнэ
гунджи	- гунж
гурун	- улс
гуске	- чоно
гутин	- гуч
гутин джур	- гучин хоёр
һалакан	- алаан
һалган	- ул
һалука	- алх
һаниска	- аниска
һарбан	- арван
һим	- им
һодун	- од
һокур	- охор
һоли	- ооль
һоран	- уул
һугулажа	- угалз
һухур	- үхэр
һулакян	- улаан
һулү булү	- илүү булуу
һуни манан, һуни туман	- уни манан
һумекей	- өмхий
һунд	- охин
һури	- хуухэн
һегги	- их, олон
һегд	- олон
һегденге	- их, олон
һекин	- эхэн, толгой
һенгнен	- өвдөг

нєрки	- ємд
нєрєкєй	- эрхий
нєгє	- нєгє
нєгєр	- гєгє
нєгєкєр	- нєгєкєр
-нєкє, -нєкє	- нєгєкєр, -нєгєкєр
нєкє	- нєкє
нєлє	- нєлє
нємгє	- тємхє
нєєлє	- чєлє
нєрєгє	- нєрєгє
нєгєй	- шєвє
нєгєн	- нєрєв
нєгєнєдє	- нєрєвєд, нєрєвєд
нєгєнєдєкє	- нєгєгєр,
нєгєнєнє	- нєч
нєгєнєнє илє	- нєчєн гєрєв
нєгєнє нємєдєжє	- нєрєвєн зє
нєлє	- нєлє
нєлєн	- тєлгєй
нєлєкє	- нєлєхєй
нєлєр, нєгєлєр	- нєзєвєр
нєкєвє-	- бєрє-
нєкєлєн	- гє
нєкєн	- єрєв
нєкєн нєкєр	- єрєвєн хєєр
нєкєн нєгєн	- єрєвєн нєрєв
нєкєн илє	- єрєвєн гєрєв
нєкєн мєнєггє	- тєм
нєкєн тєнєгмє	- єрєвєн тєв
нєкєн ємєн	- єрєвєн нєгє
нєкєнєкєн	- нєйєм
нєкєнєкєнєнє	- нєє
нєкєнєкєнєнє нєдєн	- нєєн дєлє

кадум	- хадам
кадум амьён	- хадам эцэг
кадум оньён	- хадам эх
кайласун	- хайлс мөд
кайтн, кайчн	- хайч
калан, калал	- тогоо
каливун, калкун	- халну
хамниган	- хамниган
кана	- хана
кан	- хан
кара-	- хара-
кара-	- гара-
кара	- хар
кара гөрбсун	- баазгай
карин	- харин
катабчи	- хатавч
катакин	- хетагин
каткумал	- хатгамал
качихан	- нохой
каши-	- хашн-
кейер	- хээр
кеке-	- оро-
кэлэ-	- хэлэ-
кэлэ	- хэл
кэлэлцэ-	- хэлэлцэ-
кемён	- өглөө
көн	- хөн
көрөк	- хэрэг
кете	- олон
киджагар, киджар	- хязгаар
кидэ	- хийд
кили	- хил
килинг	- хилин
кимусу	- хумс

хирэ	- хэрээ
хирээ	- хярс
хислээ-	- хийсгээ-
хятад	- хангмад, хятад
хутга, утга	- хутга
хойр	- хоёр
хойн ^н	- хойн
хоймда	- бээлэй
хола	- хол
хойлор	- хонлор
хойд ^н , хоньд ^н	- хонь
хонгорин	- хар
хорбэ	- хормой
хорган	- хоргодо-
хорголжин	- хар тугалга, хорголж
хор-	- хорн-
хорган	- хороо
хорд	- хормой
хорой	- хорхой
хота	- хот
хөд	- хөх
хөдөр хангма	- төнгөр
хөжин	- хөгжин
хөжинрө-	- хөгирө-
хөмөө	- хоомой
хула	- хула
хулагуй	- хулагуй
хульен, хукин	- бөр
хулу	- хууль
хулар, хулар	- хүрэн
хул ^н , хул	- хул шулу
хул	- хүл
хулга	- хуухан
хулгад, хулгад ^н	- олон хуухан

нагачу абага	- нагача аага
наган	- долоо
наганьё	- дал
наган намьджи	- долоон зуу
наганьё нунгун	- далан зургаа
намьджи	- зуу
намьджи эмун	- зуун нэг
наму	- намаг
намур	- намар
намуража	- намаржаа
напчи, лапчи, лапчи, напчи	- навч
наресун, нарахун	- нарс мод
насу	- нас
нала	- гэр
нэ-	- тави-
накён	- хүзүү
накуп, некуп	- нуу, охин нуу
нэрэ	- нэр
ни	- хэн
ниьдцу-	- наалда-
нигэ	- нэг
нидур	- нудуур
нечи	- бага
никаки	- нохой
нимёр	- айл
нитук	- нутаг
нонад	- ноод
нонгокан	- унага
нонда	- арьс, шир
новёми	- нарийн
нор, нуор	- нуур
нелки	- хавар
нунгун, нунгун	- зургаа
нунгуньё, нунгуньё	- жар

току-	- тохо-
толугай	- толгой
тонке-	- тави-
терел	- терел
туге	- евел
тугесэл	- евелжее
тугучек	- хожуул
тукса-	- гүй-
туксаки	- чанцага
туксирен	- уултэж байна
тунгма	- тав
тунгмаду	- таванд, тавд
тунгманнэ	- тавь
тунгма намаджи	- таван зуу
турé-	- загна-
туру	- газар, шороо
тутуксан	- тугал
тутум	- тутум
турай	- туурай
хáранчанг	- тогруу шувуу
ханч ^к , ханчуй	- ханцуй
холбага	- холбого
^к хорбе	- хормой
хемен	- уруул
хуймекёкте	- шумуул, бургуул
хуо'	- буу
хургуон	- хуруу
^к ху	- хүү
хурé	- хурээ
уанг	- ван
угеми	- муу
угушки-	- буца-
удунджа-	- бороо оро-

чина-
чирга
чирухай
читкур
чóкур
чөкчөгөй
шангку
шөн
ши
шибү
шпбон
шигшур
шидун
шикун
шулму
шинага
шинесу
шира
ширгарин

- чана-
- чарга
- курхай
- четгөр
- коохор
- пөгигий бялзуухай
- шанх
- чих
- чи
- шувуу
- нар
- шигшуур
- шуд
- нар
- шулам
- шанага
- шинэс
- шар
- цагаан



Георги Иоханн Готтлибын зохиол «Описание всех обитающих в Российском государстве народов» гэдэг номыг (герман хэлээс оросоор орчуулж) Санктпетербург хотно Хуандийн Шинжлэх ухааны академиас 1799 онд хэвлэн нийтлэснээс «Хамниган хүн» гэдэг өнгий нь будгаар ялган зурсан зургаас буулгалаа



Георги Иоханн Готтлибын «Описание всех народов обитающих в Российском государстве» гэдэг зохиолыг (герман хэлнээс орчуулж) Хуандийн Шинжлэх ухааны академиас Санктпетербург хотноо 1799 онд хэвлэсэн номд буй гараар өнгөт будгийг ялган будсан зурагаас «Анд яваа хамниган хүн» гэдгийг буулгаж, тэр үеийн хамниган хүний хувцас байдал ямар байсныг үзүүлэв. Гэрэл зураг бий болох үеийн гар зураг, барт буулгасан зүйл болно.



Георги Иоханн Готтлибын «Описание всех обитающих в Российском государстве народов» гэдэг (германаас оросоор орчуулсан) «Орос улсын дотор оршин буй бүх улс угсаатны байдлыг өгүүлсэн бичиг» гэж Хуандийн Шинжлэх ухааны академиас Санктпетербург хотноо 1799 онд хэвлэсэн номд «Анд явдаг хувцсаа өмссөн хамниган хүний байдал араас нь» гэсэн гарз дүрсийг ялгасан зургаас буулгав. Д.3



Георги Иоханн Готтлибын «Описание всех обитающих в Российском государстве народов» гэдэг зохиолыг германаас оросоор орчуулж бусад гасан номд «Өргөнө голоор нутагтай хамниган бөөгийн байдал үрчлүүсэаа» гэсэн зургаас буулгав. Уг орос орчуулгыг Хуандийн Шинэ 1799 о ухааны академиас Санктпетербург хотноо 1799 онд хэвлэжээ.

Гес
осси
рчуу
799 о
раас
урга
1. Ш



йском
гар-
рдаа-
ж.тэх
Д.4


Георги Иоханн Готтлибын зохиол «Описание всех обитающих в Российском государстве народов» хэмээх номыг (германаас оросоор орчуулж), Хуандийн Шинжлэх ухааны академиас Санктпербург хотноо 1799 онд хэвлэснээс «Өргөнө голоор нутагтай хамниган бөөгийн байдал яраас нь» гэдэг тайлбартай зургийг гараар өнгий нь будаж ялгасан зургаас гэрэл зураг татан үзүүлвэй. Георгийн энэ номын зургийг Ц. Шагдарсүрэн татан буулгасан болно.

Д.5




Лүнээкир овогт Ваампилын Жамсран гэдэг хамниган хүний зураг
Dr. Phil. Albert Grünwedel гэдэг хүний зохиосон *Mythologie du Buddhismisme au Tibet et en Mongolie* буюу Төвд Монгол дахь бурхан шашны
домог судлал гэдэг, Лейпциг хотонд 1900 онд хэвлэгдэн гарсан нэвчлэл
«Чингисийн удмын хүний хэв шинж» гэж ноён Ухтомский авсан гэрэл зураг
зургаас хуулан нийтэлжээ. Хамниган хүн болохыг Бадамжавын зэрэгчид
них хүн магадлан нуталж хорьдугаар зууны эхний хамнигацуулын үеэс
дал дүр тул, Ухтомскийн болон Грюнведелийн номд нэр угсаагийн нэр
мэдсэнийг тодрууллаа.

Хэ
гийн з



Хэнтэйн хамниганы орон сууц. 1928 онд судар бичгийн хүрээлэн-
гийн эрдэм шинжилгээний ажилтан Кондратьевын авсан гэрэл зураг.

XVII зууны үеийн хамниганы тойм тархац



1. Нэлүл хамниган 2 Намиад хамниган 3. Нөрүүз мунжаас гаднах хамниган 4. 1689 оны орос-хятад хил 5. 1689 оны Нөрүүзүйн гэрээгээр хамших орос-хятад хил 6. 1727 оны Хуагтын гэрээгээр тогтсон орос-хятад хил. 7. Яс угсааны хил заах 8 Сэлэн хааны хамниган